



ОНЦГОЙ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2023 оны 10 сарын 20 өдөр

Дугаар А/338

Улаанбаатар хот

Дүрэм батлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.4-д заасныг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Онцгой байдлын байгууллагын “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дүрэм”-ийг нэгдүгээр, хөдөлмөрийн аюулгүй байдлын зааварчилгааны хяналтын хуудсыг хоёрдугаар, Шалгалтын дүнгийн хүснэгтийг гуравдугаар, Зааварчилгааны бүртгэлийг дөрөвдүгээр, Эмийн сангийн жагсаалтыг тавдугаар, Осол тогтоосон актыг зургаадугаар, үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын тухай яаралтай мэдэгдэх хуудсыг долоодугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Батлагдсан дүрэм, хөдөлмөрийн аюулгүй байдлын зааварчилгаа, хяналтын хуудас, дүнгийн хүснэгт, зааварчилгааны бүртгэл, эмийн сангийн жагсаалт, осол тогтоосон акт, яаралтай мэдэгдэх хуудсыг өдөр тутмын үйл ажиллагаанд хэрэгжүүлж ажиллахыг төв, орон нутгийн Онцгой байдлын байгууллагын дарга, захирагч нарт үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Тэргүүн дэд дарга, (бригадын генерал Ж.Чүлтэмсүрэн)-д үүрэг болгосугай.


4. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2018 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн А/433 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА,
ХОШУУЧ ГЕНЕРАЛ

Г.АРИУНБУЯН

000003270

Онцгой байдлын ерөнхий газрын даргын
2023 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн
А/338 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт



**ОНЦГОЙ БАЙДЛЫН БАЙГУУЛЛАГЫН ХӨДӨЛМӨРИЙН
АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙН ДҮРЭМ**

**НЭГДҮГЭЭР БҮЛЭГ
Нэг. Нийтлэг үндэслэл**

1. Онцгой байдлын байгууллагын дарга (захирагч), алба хаагчдын ажил үүргээ гүйцэтгэх үеийн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйг хангуулах, тэдгээрийн эрүүл мэнд, хөдөлмөрийн чадварыг хэвийн хадгалах, үүрэг гүйцэтгэх нөхцөлөөр хангахад энэхүү дүрмийн зорилго оршино.

2. Онцгой байдлын байгууллагын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дүрэм нь гамшгаас урьдчилан сэргийлэх, гал түймэр унтраах, эрэн хайх, аврах, хор уршгийг арилгах, улсын нөөц, хүмүүнлэгийн тусламж үзүүлэх, хойшлуулшгүй сэргээн босгох ажлыг гүйцэтгэх, сургалт, дадлага, өдөр тутмын үйл ажиллагаа явуулах үед Онцгой байдлын байгууллагын алба хаагч, ажилтны хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах, ажиллах нөхцөлийг бүрдүүлэх, хяналт тавихад үүсэх харилцааг зохицуулна.

3. Энэхүү дүрэм нь Гамшгаас хамгаалах тухай хууль, Галын аюулгүй байдлын тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад акттай нийцсэн байна.

4. Энэхүү дүрмийг Онцгой байдлын байгууллагын алба хаагч, ажилтнууд дагаж мөрдөнө.

5. Онцгой байдлын байгууллагын төв, орон нутгийн газар, хэлтэс нь хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй хариуцсан орон тооны мэргэжлийн алба, алба хаагчтай байна.

6. Онцгой байдлын байгууллага нь алба хаагч, ажилтны хөдөлмөрийн нөхцөл, ажил үүргийн онцлогт тохируулан аюулгүй байдлын шаардлагад нийцсэн ажлын хувцас, хамгаалах тусгай хувцас, хэрэгсэл, багаж, техник, тоног төхөөрөмжөөр хангана.

7. Төв, орон нутгийн Онцгой байдлын байгууллагын бүтцийн нэгжүүд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйг хангах арга хэмжээг жил бүр төлөвлөн зохион байгуулна.

8. Алба хаагчдын эрүүл мэндийг хамгаалах, аливаа өвчлөл, гэмтэл, бэртлээс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх, эмчлэх, сувилах, эрүүл мэндийн урьдчилсан болон хугацаат үзлэгийг зохион байгуулах, мэргэжлээс шалтгаалсан өвчин эмгэгийг тодорхойлох, ажлын байрны эрүүл мэндэд нөлөөлөх эрсдэлийн судалгаа, тандалт хийх, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх зорилгоор төв, орон нутгийн Онцгой байдлын байгууллага нь эмч, сувилагчтай байна

**Төв, орон нутгийн Онцгой байдлын байгууллагын дарга,
захирагчийн эрх, үүрэг**

9. Төв, орон нутгийн Онцгой байдлын байгууллагын дарга, захирагч нар дараах эрхтэй.

9.1. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалтад алба хаагчийг хамруулна.

9.2. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээ, зардлыг төлөвлөх, хэрэгжилтэд хяналт тавих.

9.3. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дүрэм зөрчсөн алба хаагчдад холбогдох хууль тогтоомж, дүрэм, журамд заасан хариуцлага хүлээлгэнэ.

10. Төв орон нутгийн Онцгой байдлын байгууллагын дарга, захирагч нар дараах үүрэгтэй.

10.1. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хууль, дүрэм журмын хэрэгжилтэд хяналт тавих.

10.2. Алба хаагчдын хөдөлмөрийн хэвийн нөхцөл, ажлын байрны эрүүл ахуйг хангах.

10.3. Хөдөлмөрийн нөхцөл эрүүл ахуйг сайжруулах үйл ажиллагаанд хяналт тавьж, шийдвэрлүүлэх.

10.4. Эрүүл мэндийн сайдын 2014 оны 340 дүгээр тушаалын дагуу алба хаагчдын эрүүл мэндийг хэвээр хадгалах, өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, эрүүл мэндийн урьдчилсан болон хугацаат үзлэгийг зохион байгуулах.

10.5. Алба хаагчийн ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгсэл, техник тоног төхөөрөмж, багаж хэрэгслийг засварлах, цэвэрлэх, ариутгах бодисоор хангах.

10.6. Гамшгаас хамгаалах үйл ажиллагаа, сургалт, дадлага, тэмцээн уралдаан зохион байгуулах үеийн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйг хангахад шаардлагатай зардлыг шийдвэрлүүлэх.

11. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйг хангах, хөдөлмөрийн нөхцөлийг сайжруулах ажлыг зохион байгуулахад холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах.

**Төв, орон нутгийн Онцгой байдлын байгууллагын анги,
салбарын захирагч, даргын үүрэг**

12. Энэ дүрэм зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, арга хэмжээг төлөвлөх, хэрэгжүүлэх.

13. Бие бүрэлдэхүүний хөдөлмөрийн аюулгүй байдлыг дээшлүүлэх, сургалт зохион байгуулан, сард 1 удаа шүүлэг авч баримтжуулж, хэрэгжилтэд хяналт тавих.

14. Тусгай зориулалтын техник, тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн хэвийн ажиллагааг холбогдох зааврын дагуу зохион байгуулж, зөрчлийг арилгуулах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

**Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй хариуцсан алба хаагчийн
үүрэг**

15. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй хариуцсан алба хаагч дараах үүрэгтэй.

15.1. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, дүрэм, журмын хэрэгжилтийг хангуулах зорилгоор төлөвлөгөө, удирдамж батлуулах, хичээл

сургалт зохион байгуулан бие бүрэлдэхүүнд зохион байгуулсан сургалтын дүнг гуравдугаар хавсралтын дагуу хөтөлнө. Сургалтыг Хөдөлмөрийн сайдын 2019 оны 370 дугаар тушаалын дагуу энэ дүрэмд нийцүүлэн зохион байгуулах.

15.2. Техник, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, ажлын байрны онцлогийг тусгасан хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дүрэм, зааварт нэмэлт өөрчлөлт оруулахаар санал дэвшүүлэх.

15.3. Зөрчил дутагдлыг арилгуулах, санал боловсруулах, удирдах албан тушаалтанд танилцуулах, шийдвэрлүүлэх.

15.4. Тогтоогдсон нормын дагуу хүн нэг бүрийн хамгаалах хэрэгсэл, хордлого саармагжуулах хүнсний бүтээгдэхүүн, цэвэрлэх, ариутгах бодисын зардлыг тооцоолох, хуваарилах, зарцуулалтад хяналт тавих.

15.5. Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчлөлийн судалгаа гаргах, байгууллагын удирдлагаас ослын магадалгаа (ОМ-1а) тогтооход оролцож, санал, дүгнэлт өгөх, зөрчлийг арилгуулах талаар санал боловсруулж, шийдвэрлүүлэх.

16. Гамшгаас хамгаалах үйл ажиллагаа, өдөр тутмын дадлага сургалт болон бусад ажилд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалтад хамрагдаагүй, зааварчилгаа аваагүй алба хаагч, ажилтныг оролцуулахыг хатуу хориглоно.

Онцгой байдлын байгууллагын алба хаагч, ажилтны эрх, үүрэг

17. Онцгой байдлын байгууллагын алба хаагч, ажилтан нь дараах эрхтэй.

17.1. Стандартад нийцсэн хүн нэг бүрийн хамгаалах тусгай хувцас, иж бүрэн хамгаалах хэрэгслээр хангагдах.

17.2. Удирдах албан тушаалтанд үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагыг хангуулах талаар хүсэлт гаргах, шийдвэрлүүлэх.

18. Онцгой байдлын байгууллагын алба хаагч, ажилтан нь дараах үүрэгтэй.

18.1. Энэхүү дүрмийг хэрэгжүүлэх чиглэлээр удирдлагаас өгсөн үүрэг, даалгавар, зааварчилгааг чанд сахин биелүүлэх, сургалт, дадлагад идэвхтэй оролцох.

18.2. Ажил үүрэг гүйцэтгэх үедээ хамгаалах тусгай хувцас, хүн нэг бүрийн хамгаалах хэрэгсэл, багаж тоног төхөөрөмжийг зааврын дагуу хэрэглэх.

18.3. Хамгаалах тусгай хувцас, хүн нэг бүрийн хамгаалах хэрэгсэл, техник, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл гэмтэлтэй, аюулгүйн ажиллагаа зөрчигдсэн тохиолдолд холбогдох дарга нарт нэн даруй мэдэгдэх.

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хяналт, шалгалт

19. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйд тавих хяналт, шалгалтыг дараах гурван үе шаттай зохион байгуулна. Үүнд:

19.1. Нэгдүгээр шатны (томилгоот ээлж халалцах, өдөр тутмын үүрэг гүйцэтгэх) хяналт, шалгалтыг салааны захирагч, туслах, бүлэг, тасгийн дарга нар өдөр тутам явуулж, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй хариуцсан алба хаагч эсхүл түүнтэй адилтгах албан тушаалтнууд хяналт тавьж, илэрсэн зөрчил, дутагдлыг тухай бүр арилгуулах арга хэмжээ авч, хяналтын хуудсанд тэмдэглэнэ.

19.2. Хоёрдугаар шатны (анги, байгууллага, агуулахын эд зүйлс, автомашин, техник, тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн бүрэн бүтэн байдал, ашиглалт) хяналт, шалгалтыг сард 1-ээс доошгүй удаа Гал түймэр унтраах, аврах ажиллагааны

автомашин, техникийн тусгай тоноглол, тоног төхөөрөмж, багаж хэрэгслийг туршин шалгах, үйлчилгээ хийх заавар¹, энэ дүрмээр өгч байгаа зааварт анги, салбарын дарга, захирагч нар явуулж, илэрсэн зөрчил, дутагдлыг арилгуулах талаар удирдах албан тушаалтанд санал боловсруулж танилцуулах, хяналтын хуудсанд тэмдэглэж, баримтжуулна.

19.3. Гуравдугаар шатны (автомашин, техник, тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн туршилт) хяналт, шалгалтыг Гал түймэр унтраах, аврах ажиллагааны автомашин техникийн тусгай тоноглол, тоног төхөөрөмж, багаж хэрэгслийг туршин шалгах, үйлчилгээ хийх зааврын дагуу байгууллагын захирагч, дарга, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй хариуцсан алба хаагчид зохион байгуулж, зааврын дагуу акт үйлдэж, хувийн дэвтэрт тэмдэглэл үйлдэнэ.

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зааварчилгаа

20. Хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны зааварчилгаа дараах төрлүүдтэй байна. Үүнд:

20.1. Нэгдүгээр шатны зааварчилгаа;

20.1.1. Хөдөлмөрийн тухай хууль, энэхүү дүрэм, тухайн албан тушаалын ажлын байрны тодорхойлолтод заасан гүйцэтгэх чиг үүргээр,

20.1.2. Өөртөө болон нэрвэгдэгсдэд үзүүлэх эмнэлгийн анхны тусламж.

20.2. Хоёрдугаар шатны зааварчилгаа;

20.2.1. Алба хаагч, ажилтны гүйцэтгэх үүргийн аюулгүй ажиллагааны заавар, ажлын онцлог,

20.2.2. Хувийн хамгаалах хэрэгслүүд, тэдгээрийг ашиглах заавар,

20.2.3. Тээврийн хэрэгсэл, техник, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэлд засвар, техник үйлчилгээ хийх болон ашиглалтын үед тавигдах аюулгүй байдал,

20.2.4. Өөртөө болон нэрвэгдэгсдэд үзүүлэх эмнэлгийн анхны тусламж.

20.3. Гуравдугаар шатны зааварчилгаа;

20.3.1. Энэхүү дүрмийн 20.1, 20.2-д заасныг, мөн бусад онцгой байдлын байгууллагад мөрдөгдөж буй стандарт, дүрэм, журмаар.

21. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зааварчилгааг дараах алба хаагч, ажилтанд, албан тушаалтан өгнө. Үүнд:

21.1. Нэгдүгээр шатны зааварчилгааг:

21.1.1. Алба хаагч, ажилтан бүр жил бүрийн 1 дүгээр сард ажилласан жил, боловсролын түвшнийг харгалзахгүйгээр,

21.1.2. Онцгой байдлын байгууллагад туршилтаар болон шинээр томилогдсон алба хаагч, ажилтан, сонсогчдод 2 цагаас багагүй хугацаагаар танхимын сургалтыг хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хариуцсан ажилтан буюу түүнтэй адил албан тушаалтан сургалт явуулж, зааварчилгааны хуудсыг хүн нэг бүрээр дүрмийн хоёрдугаар хавсралтын дагуу хөтөлж хувийн хэрэгт нь хадгална. /эмч, сэтгэл зүйч эрүүл ахуй, эмнэлгийн анхан шатны тусламж үзүүлэх, сэтгэл зүйн сургалт, эрүүл мэндийн үзлэг хийнэ/

21.2. Хоёрдугаар шатны зааварчилгааг :

¹ Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2023.06.06-ны өдрийн А/191 тоот тушаал “Гал түймэр унтраах автомашин, техникийн тусгай тоноглол, тоног төхөөрөмж, багаж хэрэгслийг туршин шалгах, үйлчилгээ хийх заавар”

21.2.1. Томилгоот ээлжийн үүрэг гүйцэтгэх, дадлага сургууль, гамшгийн голомтод ажиллах, ажлын байр нь өөрчлөгдсөн, шинэ техник, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл ашиглах, ажлын 60 хоногоос дээш хугацаагаар ажлаас чөлөөлөгдөн эргэж ажилдаа орсон, албаны болон нийтийн биеийн тамирын спортын төрлүүдэд оролцох үед тухайн алба хаагч, ажилтанд гал түймэр унтраах удирдагч, аврах ажиллагааны зааварлагч, салаа, бүлгийн дарга, цэгийн эрхлэгч, дасгалжуулагч, эдгээртэй адил албан тушаалтан өгч дүрмийн дөрөвдүгээр хавсралтын дагуу хөтөлнө.

21.2.2. Ажлын байран дахь хоёрдугаар шатны зааварчилгааг өгсөн тухай албан тушаалтан анги, салбарын дарга, захирагч, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй хариуцсан ажилтан, болон түүнтэй адилтгах албан тушаалтанд танилцуулсаны дараа бие даан ажиллуулах зөвшөөрөлийг олгоно.

21.3. Гуравдугаар шатны зааварчилгааг:

21.3.1. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй хариуцсан алба хаагч бие бүрэлдэхүүний мэдлэгийг бататгах зорилгоор улирал бүр өгч, шүүлэг авч дүрмийн гурав, дөрөвдүгээр хавсралтын дагуу баримтжуулна.

ХОЁРДУГААР БҮЛЭГ БАРИЛГА БАЙГУУЛАМЖ, АЖЛЫН БАЙРАНД ТАВИГДАХ ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙН ЕРӨНХИЙ ШААРДЛАГА

Барилга байгууламж, ажлын байранд тавигдах эрүүл ахуй аюулгүй ажиллагааны шаардлага

22. Онцгой байдлын байгууллагын төв, орон нутгийн газар, хэлтэс, анги, салбар нэгжийн байр нь тоосжилт, химийн хортой бодисын ууршилт, хэт богино долгионы нөлөө, хүний бие организмыг хордуулах, гэмтээх болон бусад хохирол учруулах хүчин зүйлсгүй байх шаардлагыг хангасан байна.

23. Ажлын байр нь дараах үзүүлэлтийг хангасан байна.

23.1. Агааржуулалт – ажлын байрны зохион байгуулалтыг төлөвлөхдөө нэг цагт нэг хүнд 30 м³ агаар ногдож байхаар тооцох ба агаарын бохирдол үүсэх хүчин зүйлгүй байх, ажлын байранд цаг тутам 15 минутаас багагүй хугацаагаар агаар солилцуулах, цэнэг хураагуур, түлш, химийн хортой бодисын ууршилттай өрөө, тасалгаа, бие засах өрөө, тавиулан зэрэг агаарын бохирдолттой өрөөний агааржуулах систем нь бүрэн ажиллагаатай байх, гадна орчинд агаар, орчны бохирдлыг саармагжуулах мод, зүлэг тарих.

23.2. Гэрэлтүүлэг – ажлын байрны зориулалт, онцлогоос хамааран 280- 750 лк /Нэгж гадаргууд тусаж байгаа гэрлийн урсгалын хэмжээг гэрэлтэлд буюу люкс гэнэ. Хэмжих нэгж лк/ байна. Гэрэлтүүлгийн зөвшөөрөгдөх хамгийн доод хэмжээ (шат, хонгил г.м) 50 люкс байж болно. Байнгын ажиллагаатай (Зарлан мэдээлэл, шуурхай удирдлагын төв, дуудлага хүлээн авагч), техникийн өрөө, хонгил, орц, шат, тавиулангийн гэрэлтүүлгийг байнга асаалттай байлгаж, гэрэл унтарсан үед ослын гэрэл автоматаар асаж байхаар тоноглох.

23.3. Чийглэг – тохиромжтой чийглэгийн хэмжээ 40-60%, зөвшөөрөгдөх дээд хэмжээ 75% байна.

23.4. Дуу чимээ – байж болох дээд хэмжээ 60 дБ (шуугианы даралтын түвшин) байх ба утсаар ярьдаг өрөөнд 40 дБ -ээс доош байвал зохино.

23.5. Талбай – Нэг хүнд ногдох талбайн хэмжээ 6м^2 , эзлэхүүн нь 20м^3 -ээс багагүй² байна.

23.6. Дулаан – Өрөөний агаарын температур гадаад температур, улирлын байдлаас хамаарч 18 ... 24⁰С градус байна.

24. Хөдөлмөрийн нөхцөлийн хэмжилтийг шаардлагатай гэж үзсэн болон шинээр бий болсон, шинэ төхөөрөмж, багаж хэрэгсэл суурилагдсан ажлын байр бүрээр хийлгэж, хөдөлмөрийн хэвийн нөхцөлийг хангах, сайжруулах арга хэмжээг авч хэрэгжүүлэх.

25. Хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангахад чиглэгдсэн техник, технологийг шинэчлэх, хөдөлмөр зохион байгуулалтыг боловсронгуй болгох, аюултай хүчин зүйл бий болсон, гарч болзошгүй ослын үед ажиллах шуурхай ажиллагааны дэг тогтоож түүнийг хэрэгжүүлж ажиллах.

26. Ажлын байранд үүсэж болох аюултай хүчин зүйлд хяналт тавих, осол, аюул гарсан үед болон эрсдэл бүхий ажлын байранд хориглох хаалт, хамгаалалт, дохио санамж, анхааруулга тавих. Энэ нь зөөврийн болоод байнгын байна.

27. Төв, орон нутгийн Онцгой байдлын байгууллагын газар хэлтэс, анги, салбар, нэгж нь ажлын байрны эрсдэлийн үнэлгээг мэргэжлийн байгууллагаар хийлгэх.

28. Техник, тоног төхөөрөмжийг үйлдвэрлэгчээс тогтоосон ашиглалт, аюулгүй ажиллагааны заавар, журмын дагуу ажиллуулж, техникийн гэрчилгээг хөтлөх.

29. Онцгой байдлын байгууллагын анги, салбар, нэгжийн барилга байгууламж нь барилгын норм, дүрэм, стандартын дагуу төлөвлөгдөн баригдаж төхөөрөмжлөгдсөн тусгай зориулалтын барилга байгууламжид байрлана.

30. Гал түймэр унтраах, аврах ангийн барилгад хоёрдугаар давхраас нэгдүгээр давхарт буух 1.5 x 1.5 метрийн хэмжээтэй нээлхий, доош буух багана нь 200 мм диаметртэй гялгар гадаргуутай, баганын доод хэсэгт эргэн тойрон 1 метр талбайд зөөлөвчтэй байна. Буух багана руу орох хаалга нь хоёр хавтастай дотогш онгойдог, түгжээтэй байна.

31. Хүн байнга байрладаг өрөө нь эрүүл ахуйн шаардлага хангасан материалаар, автомашины тавиулан нь бетон буюу цардмал (зориулалтын будгаар будсан), ариун цэвэр болон угаалгын өрөөнүүд зүймэл чулуун материалаар хийсэн шалтай байна. Өрөөний шал нь нэг түвшинд байх бөгөөд орох, гарах хаалганд өндөрлөсөн босго хийхийг хориглоно.

32. Гал түймэр унтраах, эрэн хайх, аврах анги, салбар, бүлгийн барилга нь агааржуулалтын систем, цэвэр, бохир усны шугамтай тавиулан дотор усан хангамжийн эх үүсвэртэй байна. Хоол үйлдвэрлэлийн өрөө, угаалгын өрөө, амьсгалын бие даасан төхөөрөмж, галын хоолой, багаж хэрэгслийн засвар үйлчилгээний болон хувцас хатаах өрөө халуун устай байна.

33. Харуулын байр, тавиулан тэдгээртэй залгаа явган хүний гарц нь ердийн гэрэлтүүлэгтэй байна. Томилгоот ээлжийн амрах байр нь тавиуландаа ойрхон, жижүүрийн болон нэмэлт дуудлагаар ирсэн бэлтгэл ээлжийн хүмүүс унтаж амрахад хүрэлцээтэй цагаан хэрэглэл бүхий ор дэвсгэртэй байна. Өрөө нь тавиулан тийш

² Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Дэлгэц бүхий тоног төхөөрөмжтэй ажиллах эрүүл ахуй, эргономикийн ерөнхий шаардлага MNS 5027:2001

онгойдог хоёр хавтастай, 1.2х2 метрийн хэмжээтэй, шатахууны ууршилт, угаарын хий орохоос хамгаалсан нягтруулагч бүхий хаалгатай байна.

34. Гал түймэр унтраах, аврах анги, эрэн хайх, аврах анги, салбар, нэгж нь гамшиг, аюулт үзэгдэл, ослын анхны дуудлагаар хоёроос дээш автомашинтай гарч явдаг бол тавиулан, амрах байр, сургалтын танхим, биеийн тамирын өрөөнд дуудлагын гэрэлт дохиотой, явах хүч хэрэгслийг заасан самбар байрлуулсан байна.

35. Томилгоот ээлжийн амрах байр, явах замын дагуу аврагч, гал сөнөөгчдийн хөдөлгөөнд саад болох эд зүйлс байлгахыг хориглоно.

36. Галын аюулгүй байдлын нормд заагдсанаар галын аюулгүй байдал хангагдсан байна.

Гал түймэр унтраах, эрэн хайх, аврах анги, салбар бүлгийн автомашины тавиулан

37. Тавиулан дотор автомашиныг дараах зай хэмжээний дагуу байрлуулна.

Үүнд:

37.1. Автомашинуудын хооронд 2 метр

37.2. Автомашинаас багана хүртэл 1 метр

37.3. Баруун гар талын автомашинаас барилгын хана хүртэл 2 метр

37.4. Зүүн гар талын автомашинаас барилгын хана хүртэл 2 метр

37.5. Автомашинаас барилгын урд хана хүртэл 3 метр

37.6. Автомашинаас барилгын хойд хана хүртэл 3 метр

38. Автомашины хөдөлгүүрийн яндангаас гарч буй утаа, угаарын хийг гадагш соруулах тусгай төхөөрөмж тавиуланд байрлуулсан байна.

39. Тавиулангийн хаалга бүр 3.5 метрээс дээш өндөр, 3.8 метр өргөн байх ба түгжээ, цоожлогчтой байх ёстой. Хаалганы түгжээ нь автоматаар эсвэл гар аргаар хялбар онгойдог байвал зохино. Хаалганы дээд хэсгийг зориулалтын шилээр шиллэж болно. Шилийг унахаас сэргийлж тусгай тоноглол хийсэн байна.

40. Хамгаалах тусгай хувцас, хүн нэг бүрийн хамгаалах хэрэгслийг богино хугацаанд хялбар өмсөж болохуйц эвхэж тавих зориулалт бүхий тавиур, өлгүүрийг тавиулангийн хананд тулгах буюу гал сөнөөгч, аврагчдад саад болохооргүй газар байрлуулна.

41. Тавиулан болгон зориулалтын гэрэлтүүлэгтэй, засварын сувагтай байна. Сувгийн дээд хэсэг модон хаалттай байна. Сувгийн хоёр талаар 8-10 см өндөр хашлага хийж өгнө. Засварын суваг нь нэг талдаа гишгүүр бүхий шат, нөгөө талдаа босоо төмөр шаттай байна.

42. Тавиуланд автомашин орж, гарах үед хөдөлгөөний аюулгүй байдлыг хангасан автомашин байрлах заагийг шалан дээр цагаан, шар өнгийн будгаар хязгаарлах тэмдэглэгээ байна. Автомашин тавиулангаас гарах үед хоёр талын бүхээг, багажны хайрцгийн хаалга, таг онгорхой эсэхийг жолооч харахад зориулан тавиулангийн хаалганы хоёр талын хананд толь байрлуулсан байна.

43. Өрөө тасалгаанаас тавиулан руу орох хаалганууд тавиулан тийш онгойдог байх, тавиулангийн шал нь хаалга тал руу 2 градусын налуу байна.

44. Тавиуланд тогтоосон тооноос илүү автомашин байрлуулахыг хориглоно.

45. Тавиулан, галын хоолой, багаж хэрэгсэл, засвар үйлчилгээ, хувцас хатаах, цэнэг хураагуурын өрөөнүүд нь +10 градусаас доошгүй байна.

46. Тавиулангийн гадна хаалганаас 6 метрийн зайд жолоочид харагдахуйц Замын хөдөлгөөний дүрмийн 1 дүгээр хавсралтын 3.5-д заасныг хэрэгжүүлэн “ЗОГС” тэмдэглэгээг хийсэн байна.

Шуурхай удирдлага, зарлан мэдээллийн байр

47. Гамшиг, осол, гал түймрийн дуудлага хүлээн авах, дамжуулах өрөө нь +18 градусаас багагүй дулаантай, дуу чимээ нэвтрүүлдэггүй, утаанаас тусгаарлагдсан, гэрэлтүүлэг сайтай байна.

48. Гамшиг, осол, гал түймрийн дуудлагаар тавиулангаас хуваарийн дагуу түрүүлж гарах автомашинд ойрхон тавиулан талын хананд 0.5x0.5 метрийн хэмжээтэй цонх, амрах буйдан, тавдугаар хавсралтад заагдсан жагсаалт бүхий эмийн сан байна.

49. Холбооны техник хэрэгслийн аюулгүй байдлын хангасан байна.

50. Стандарт, хэмжилзүйн газрын даргын 2022 оны 9 дүгээр сарын 06-ны өдрийн С/39 дугаар тушаалаар батлагдсан “Гамшгийн аюулыг зарлан мэдээлэх системд тавих техникийн ерөнхий шаардлага” MNS 6979:2022-ыг мөрдлөг болгон ажиллах.

Цэнэг хураагуурын өрөө

51. Цэнэг хураагуур хадгалах өрөө нь “Цэнэг хураагуурын өрөө” гэсэн хаягтай, “Галын аюултай” болон бусад шаардлагатай санамжуудтай байна.

52. Цэнэг хураагуурын өрөөний гэрэлтүүлэг, агааржуулалтын төхөөрөмж нь норм стандартын дагуу хийгдсэн, хана нь хүчилд тэсвэртэй материалаар хийгдсэн эсвэл зориулалтын будгаар будсан байна.

53. Цахилгаан тоног төхөөрөмжүүд нь аюулгүй ажиллагааны шаардлагыг хангасан байна.

54. Хүчил, шүлтийн зайн хураагуурыг тус тусад нь байрлуулж, хаягжуулна.

55. Цэнэг хураагуурын өрөөнд ил гал гаргах, тамхи татах, хүнс бараа, бүтээгдэхүүн хадгалах, бусад зориулалтаар ашиглахыг хориглоно.

Алдрын танхим, сургалтын танхим, биеийн тамирын танхим, архивын өрөө

56. Алдрын танхим, сургалтын танхим, болон биеийн тамирын танхимын хаалганы өргөн, хийц нь аль болох аюулгүй, хурдан гарах нөхцөлийг бүрдүүлсэн, өдөр, шөнийн гэрэлтүүлэгтэй байх ба Барилга, байгууламжийн галын аюулгүй байдал БНБД 21-01-02-ийн дагуу төлөвлөнө.

57. Архивын өрөөнд байгууллагын архивын ажлын үндсэн зааврыг мөрдөн ажиллана.

Дасгал сургуулилтын цамхаг

58. Сургуулийн цамхаг нь үндсэн барилгатай хамт буюу тусад нь барьж болно. Үндсэн барилгатай хамт баригдсан дасгал сургуулилтын цамхгийн гал тэсвэршилтийн зэрэг нь үндсэн барилгатайгаа адил байна.

59. Үндсэн барилгаас дасгал сургуулилтын цамхаг нь галд тэсвэртэй хаалгаар тусгаарлагдсан байна.

60. Дасгал сургуулилтын цамхаг нь дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

60.1. Цамхгийн нүүрэн тал нь цонхноосоо өөр ямар нэгэн нүх цоорхойгүй,

цамхгийн 2 дугаар давхрын цонхонд өлгөсөн араатай шатны гурав дах хөндлөөс доош 1-2 см зайд 6х6 см-ийн хөндлөн огтлол бүхий дэр модтой байна.

60.2. Цамхаг нь дотор талдаа байнгын шат, гал түймэр унтраах анхан шатны багаж хэрэгслээр хангагдсан байна. Цамхгийн дотуур шат нь хамгаалалт бүхий бариултай байна.

60.3. Цамхгийн цонхноос эсрэг талын хана хүртэлх өргөн нь 1.5 метрээс багагүй байна.

60.4. Цамхгийн 4 дүгээр давхарт хамгаалалтын төхөөрөмж хийсэн байна. Хамгаалалтын төхөөрөмжийг жил бүрийн хавар нэг удаа туршин шалгана.

60.5. Цамхгийг сургалт, дадлага хийх болон галын хоолой хатаахаас өөр зориулалтаар ашиглахыг хориглоно.

60.6. Хоёрдугаар давхрын цонхны доод ирмэгээс газар хүртэл цамхгийн нүүрэнд уян материалаар хаалт хийж тамирчдыг ослоос хамгаална.

60.7. Цамхгийн нүүрэн талд 1 метр гүн, 4 метр өргөн, цамхгийн урд талаас хоёр тийш 1 метрээс багагүй урттай хамгаалалтын зөөлөвчтэй байна.

60.8. Хамгаалалтын зөөлөвчийн доод хэсгийн 0.5 метр гүнд зөөлөн материал буюу модны үртэс дэвсэж, сийрсэн материалаар жийрэг тавиад дээд хэсэгт нь 0.5 метрийн зузаан 1:1 хэмжээний элс, үртэсний хольц хийж тэгшилнэ.

60.9. Цамхаг дээр дадлага, сургууль хийхийн өмнө зөөлөвчийг сийрэгжүүлнэ. Зөөлөвчийг 2 жил тутам нэг удаа солино.

60.10. Цамхгийн урд талд 2 дугаар давхрын цонхны харалдаа хамгаалалтын тор байрлуулна. Хамгаалалтын тор нь газраас 5.15 метр, цамхгийн нүүрэн талаас 0.75 метрийн зайтай байрлах бөгөөд торны өргөн 2.5 метр, урт цамхгийн замаас хамаарч өөр өөр байна.

Хоол үйлдвэрлэлийн өрөөнд тавигдах шаардлага

61. Хоол үйлдвэрлэлийн өрөөний төлөвлөлт шийдэл нь үйлдвэрлэл, үйлчилгээний технологийн зөв урсгалтай эрүүл ахуй болон үйлдвэрлэлийн зохистой дадал хэрэгжих боломжтойгоор зохион байгуулагдсан байна.

62. Хоол үйлдвэрлэлийн өрөөнд ашиглах ахуйн хийн баллоныг галын аюулгүй байдлын дүрэмд заасны дагуу барилгын гадна байрлуулж, галын аюултай шатамхай хий гэсэн тэмдэг, тэмдэглэгээ хийсэн байх

63. Хоол үйлдвэрлэлийн өрөөнд хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны шаардлага хангасан тоног төхөөрөмжийг байрлуулж, үйлдвэрлэгчээс тогтоосон технологи, ажиллагааны дарааллын дагуу ашиглах.

64. Агааржуулалтын хоолой нь зэвэрдэггүй материалаар хийгдсэн, авч цэвэрлэхэд хялбар, шавж хорхойноос хамгаалагдсан торон хаалттай байна.

65. Хоол үйлдвэрлэлийн өрөө нь дотор агаарыг гадагшлуулах, гаднаас цэвэр агаарыг оруулах албадан болон энгийн салхивчийн системээр тоноглогдсон байна.

66. Хоол үйлдвэрлэлийн өрөөнд ажиллах ажилтан эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээнд жилд 2-оос доошгүй удаа хамрагдсан мэргэжлийн хүн байна.

67. Ажиллагсад нь хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангасан хамгаалах тусгай /халаад, гутал, хормогч, бээлий, үсийг бүрэн халхлахуйц толгойны өмсгөл/ 2-оос доошгүй ээлжийн хувцастай байна.

ГУРАВДУГААР БҮЛЭГ
ТУСГАЙ ЗОРИУЛАЛТЫН ХАМГААЛАХ ХУВЦАС ХЭРЭГСЭЛ, ХҮН НЭГ
БҮРИЙН ХЭРЭГСЭЛТЭЙ АЖИЛЛАХ ҮЕИЙН АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ
ЗААВАР

Хамгаалах тусгай хувцас

68. Гал түймэр унтраах, аврах анги, эрэн хайх аврах анги, салбар бүлгийн бие бүрэлдэхүүний хамгаалах тусгай хувцас, бээлий, дуулга малгай, бүс, гутал нь халуун, хүйтэн нөхцөлд ажиллахад тохиромжтой, хүн нэг бүрийн биед таарсан, химийн бодис материалтай ажиллахад эрүүл ахуйн шаардлага хангасан байна.

69. Хамгаалах тусгай хувцас, хүн нэг бүрийн хамгаалах хэрэгсэл нь стандартын шаардлага хангасан байна.

70. Стандартын шаардлага хангаагүй хамгаалах тусгай хувцас, хүн нэг бүрийн хамгаалах хэрэгслийг ашиглахыг хориглоно.

71. Төрөл мэргэжлийн аврагч, гал сөнөөгчид хамгаалах тусгай хувцас хэрэгслийг иж бүрэн өмссөний дараа автомашинд суух ба ажиллагаанд оролцоно.

72. Эрэн хайх, аврах, хор уршгийг арилгах, объектын болон ой, хээрийн гал түймэр унтраах ажиллагааны үед хамгаалах тусгай хувцас хэрэгслийг захирагч, даргын зөвшөөрөлгүй тайлах, дутуу өмсөхийг хатуу хориглоно.

Гал түймэр унтраах тусгай зориулалтын хувцас, хэрэглэл

73. Онцгой байдлын байгууллагын алба хаагчид гал түймэр унтраах дадлага сургууль, унтраах ажиллагаанд оролцох үед стандартын шаардлага хангасан, гал тэсвэрлэх шинж чанар бүхий хамгаалах тусгай хувцасыг журамд³ заасны дагуу бүрэн өмсөж хэрэглэнэ.

74. Гал түймэр унтраах, аврах ангийн тавиуланд хөдөлгөөнд саад болохооргүй газар гал түймрээс хамгаалах хүн нэг бүрийн хэрэгслийг богино хугацаанд хялбар өмсөж болохуйц нормативд⁴ зааснаар эвхэж тавих зориулалт бүхий тавиур, өлгүүрт байрлуулна.

75. Амьсгалын бие даасан төхөөрөмжийг гал түймэр унтраах удирдагчийн тушаалаар, зааврын дагуу өмсөнө.

76. Дулаан эсэргүүцэх хувцсыг хий, газрын тосны бүтээгдэхүүний болон дулааны өндөр эрчимтэй гал түймрийг унтраах, дадлага сургуулийн үед өмсөнө.

77. Дулаан эсэргүүцэх хувцсыг хэрэглэхдээ амьсгалын бие даасан төхөөрөмжийг хувцасны дотуур өмсөж хэрэглэнэ.

78. Дулаан эсэргүүцэх хувцсыг хүний тусламжтайгаар дараах дарааллын дагуу өмсөнө.

78.1. Дулаан тусгаарлах дотуур хувцас өмссөн байна.

78.2. Комбинезоны доод хэсэг буюу өмд болон гутлыг өмсөнө.

78.3. Амьсгалын бие даасан төхөөрөмжийг нуруундаа үүрч үүрэг гүйцэтгэх ажиллагааны үед хөдөлгөөнд саад болохооргүй өөртөө тохируулна.

³ Онцгой байдлын байгууллагын Объектын болон ой, хээрийн гал түймэр унтраах үйл ажиллагаанд зориулсан хамгаалах тусгай хувцас, хүн нэг бүрийн хамгаалах хэрэгслийг хэрэглэх журам

⁴ Гал түймэр унтраах дасгал сургуулийн норматив

78.4. Комбинезоны дээд хэсгийг өмсөж, чангалагч бүч чангалж, товчийг товчилж, хамгаалалтын хаалтыг хаахдаа хамгийн дээд талын товч болон бүчийг түр үлдээнэ.

78.5. Амьсгалын бие даасан төхөөрөмжийн агаар хадгалах саван дах агаарын даралтыг шалгаж, нүүрний хамгаалах багийг толгойдоо тааруулан чангалсны дараа дуулганы дотуурх малгайг өмсөж, дуулга малгайн сагалдаргыг чангалан өмсөнө.

78.6. Дулаан эсэргүүцэх хувцасны бүх товчийг товчилж, бүчийг чангалж дуусгана.

79. Ой, хээрийн гал түймрийг унтраах ажиллагаанд ой, хээрийн гал түймэр унтраах ажиллагаанд зориулсан хамгаалах тусгай хувцас, хамгаалах нөмрөгийг ашиглана.

80. Ой хээрийн гал түймрийг унтраах ажиллагаанд зориулсан хамгаалах тусгай хувцас хэрэгслийг бүрэн өмсөж оролцоно.

81. Хамгаалах нөмрөгийг түймрийн уулга, галын хуйлрал, хувцсанд гал авалцсан үед нөмөрч хэрэглэнэ.

82. Гал түймэр унтраах ажиллагааны дараа хамгаалах тусгай хувцасны шошгод заасан санамжийн дагуу зориулалтын цэвэрлэгээний горимоор цэвэрлэж, дараагийн ажиллагаанд бэлтгэж тавина.

Биологийн аврах ажиллагааны тусгай зориулалтын хувцас хэрэглэл⁵

83. Биологийн аврах ажиллагааны буюу хүн, мал, амьтны гоц халдварт өвчний халдварын голомтод үүрэг гүйцэтгэх үед нэг удаагийн тусгай зориулалтын халдвар хамгааллын хувцас хэрэглэлийг өмсөж хэрэглэнэ.

84. Тусгай зориулалтын халдвар хамгааллын хувцас хэрэглэлийг өмсөлгүйгээр хүн, малын гоц халдварт өвчний сэжигтэй буюу нас барсан хүн, ялаа, шумуул, шавж, мэрэгч амьтад, малын сэг зэмд гар хүрэх, оролдох, малын арьс, махыг хүнсэнд хэрэглэхийг хориглоно.

85. Халдвар хамгааллын хувцас хэрэглэл нь биологийн бохирдлоос хамгаалах химийн бодис болон усанд тэсвэртэй материалаар хийсэн комбинезон, гутлын углааш, хормогч, бээлий, амьсгал хамгаалах хэрэгсэл, нүд хамгаалах хэрэгслээс бүрдэнэ.

86. Аврагч нь халдвар хамгааллын хувцас хэрэглэлийг үүрэг гүйцэтгэхэд хөдөлгөөнийг хязгаарлахгүй, өмсөхөд чөлөөтэй байхаар биеийн хэмжээндээ тааруулан өмсөнө.

87. Комбинезоны дотуур хөвөн даавуун дотуур хувцас юм уу ажлын хувцас, гутал өмсөнө.

88. Халдвар хамгааллын хувцсыг халдварын голомт руу орохоос өмнө дараах дарааллын дагуу өмсөнө.

89. Комбинезоныг өмсөж цахилгааныг татна.

90. Комбинезон өмсөж дараа нь углаашийг давхар углаж өмсөнө.

91. Амьсгалын замаар халдвар авахаас сэргийлэх амьсгал хамгаалах хэрэгсэл эсвэл амны хаалтыг зүүнэ.

⁵ Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2018 оны А/52 дугаар тушаалын 2 дугаар хавсралтыг баримтална

92. Хамгаалах нүдний шил зүүнэ. Нүдний шил нь үсэрсэн эмгэгт материал, шингэн зэргээс нүдийг хамгаална. Нүдний шил нь нүдний тойронд нягт сууж хэмжээ нь тохирсон байна.

93. Ердийн нүдний шилийг хамгаалалтын шилний оронд хэрэглэхийг хориглоно. Хамгаалалтын шилийг нүдний харааны шилэн дээр давхар зүүж болно.

94. Амьсгал болон нүд хамгаалах хэрэгслээ зүүсний дараа комбинезоны малгайг өмсөнө.

95. Хормогчийг комбинезон дээрээ өмсөх бөгөөд илүү бохирдлоос хамгаална. Хормогчийг уутнаас нь гаргаж хүзүүндээ углаж бүчийг нь ар нуруундаа уяж зангидна.

96. Ариутгаагүй, нитрилэн хоёр хос бээлий байна. Эдгээр бээлийг давхарлаж эхлээд цагаан буюу тунгалаг бээлийг өмсөөд дараа нь бараан өнгөтэй бээлийг давхарлаж өмсөнө.

97. Эмгэгт материал, шингэнээр бохирдсон арьс, хувцас тайлсны дараа дотор талын бээлийг халдваргүйжүүлж цэвэрлэхэд зориулалтын нойтон цаасан алчуур ашиглана.

98. Халдвар хамгааллын хувцас, хэрэгслийг тайлахдаа халдварын аюултай бүсээс гарсан байх ба дараах дарааллын дагуу тайлна.

99. Хормогчоо тайлж ашигласан халдвар хамгааллын хувцас, хэрэгслийг хаях хог хаягдлын уутанд хийнэ.

100. Гадна бээлийг нойтон цаасан алчуураар арчиж, хэрэглэсэн цаасан алчуураа хаягдлын уутанд хийнэ.

101. Гутлын углаашийн дээд ирмэгээс барьж тайлаад хаягдлын уутанд хийнэ.

102. Гадна талын бээлийг тайлаад хаягдлын уутанд хийнэ.

103. Комбинезоныг юүдэн талаас эхлэн дотрыг нь гадагш эргүүлж доош хуйлж тайлаад хаягдлын уутанд хийнэ.

104. Нүдний шилээ чангалагч уяанаас дээшээ татаж тайлаад хаягдлын уутанд хийнэ.

105. Амны хаалтын дээд талын уяаг эхэлж мулталж тайлаад дараа нь доод талын уяаг толгой дээгүүрээ мулталж тайлан хаягдлын уутанд хийнэ.

106. Дотор талын бээлийг тайлаад хаягдлын уутанд хийнэ.

107. Гараа халдваргүйжүүлэх зориулалт бүхий нойтон цаасан алчуураар арчиж хэрэглэсэн алчуурыг хаягдлын уутанд хийнэ.

108. Хаягдлын уутны амыг хааж, зангидаж битүүмжилнэ.

109. Халдварын голомтод ажиллах үед болон түүний дараа хувийн ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлагыг нарийн чанд сахиж, гараа тогтмол угаана.

110. Гар угаахдаа усаар норгож савандаж 20 секундээс багагүй хугацаанд үрж хөөсрүүлж, усаар сайтар булхаж зайлан нэг удаагийн алчуурт арчих юм уу агаарт хатаана.

111. Халдвар хамгааллын хувцас өмсөж ашиглах үед дараах зүйлсийг анхаарч ажиллана.

112. Халдвар хамгааллын хувцас, хэрэглэлийг зөвхөн нэг удаа хэрэглэнэ. Дахин хэрэглэхийг хориглоно.

113. Халдвар хамгааллын хувцас, хэрэглэлийг хэрэглэхтэй холбоотой зааварчилгааг урьдчилан өгөх ба эрүүл мэндийн хувьд тохирохгүй хүнд хэрэглэхийг хориглоно.

114. Халдвар хамгааллын хувцас, хэрэглэлийг хэрэглэж байгаа үедээ амьсгалын хушуувч, нүдний шил зэргийг тайлахыг хориглоно.

115. Халдвар хамгааллын хувцас, хэрэглэл нь урагдаж битүүмж алдагдах, бохирдвол нэн даруй солино. Ажил завсарлаж дараа нь дахин ажиллахаар бол шинэ хувцас өмсөнө.

116. Халдвар хамгааллын хувцас, хэрэглэлийг өмсөх, тайлах газрыг урьдчилан тогтоосон байвал зохино.

117. Халдвар хамгааллын хувцас, хэрэглэлийг тайлахдаа халдварын аюултай бүсээс гарсан байна.

118. Хэрэглэсэн халдвар хамгааллын хувцас, хэрэглэлийг шатаах болон автоклавдаж устгана.

Химийн ослын үеийн хамгаалах тусгай зориулалтын хувцас хэрэглэл

119. Химийн ослын үед аврах ажиллагааны үүрэг гүйцэтгэхэд осол тохиолдсон газар орны байршил, цаг агаарын нөхцөл байдал, химийн хорт болон аюултай бодисын төрөл, тархалтын байдлаас хамаараад “А”, “В”, “С” зэрэглэлийн, нэг удаагийн болон олон удаагийн хамгаалах тусгай хувцас хэрэглэл өмсөж ашиглана.

120. Аврагч нь хамгаалах тусгай хувцас хэрэглэлийг хөнгөн, хөдөлгөөн хязгаарлахгүй хувцсан дээр үүрэг гүйцэтгэхэд чөлөөтэй байхаар биеийн хэмжээндээ тааруулан өмсөнө.

121. хамгаалах тусгай хувцас хэрэглэл нь комбинезон, нүүр болон амьсгал хамгаалах хэрэгсэл, бээлий, гутал зэргээс бүрдэх ба дараах дарааллын дагуу өмсөнө.

121.1. Химийн бодисоос хамгаалах комбинезон өмсөж, товчилно.

121.2. Гутал болон гутлын гадуурх улавчийг өмсөнө.

121.3. Нүүр болон амьсгал хамгаалах хэрэгсэл өмсөнө.

121.4. Хэрэв нүдний шил тусдаа бол зүүнэ.

121.5. Амьсгал болон нүд хамгаалах хэрэгслээ зүүсний дараа комбинезоны малгайг өмсөнө.

122. Зориулалтын хоёр хос бээлийг давхарлан өмсөнө.

123. Ажиллагааны дараа аюултай бүсээс гарсан байх ба хувцас хэрэглэлийг дараах дарааллын дагуу тайлна.

124. Гутлын гадна талын улавчийг тайлж хаягдлын уутанд хийнэ.

125. Гадна талын бээлийг тайлж уутанд хийнэ.

126. Комбинезоныг юүдэн талаас эхэл нь дотрыг нь гадагш эргүүлж доош хуйлж тайлаад хаягдлын уутанд хийнэ.

127. Нүдний шилээ чангалагч уяанаас дээшээ татаж тайлаад хаягдлын уутанд хийнэ.

128. Амны хаалтыг дээд талын уяаг эхэлж мулталж тайлаад дараа нь доод талын уяаг толгой дээгүүрээ мулталж тайлан хаягдлын уутанд хийнэ.

129. Дотор талын бээлийг тайлаад хаягдлын уутанд хийнэ.

130. Хаягдлын уутны амыг хааж, зангидаж битүүмжилнэ.

131. Хэрэв нэг удаагийн хувцас хэрэглэл бол хаягдлын уутанд битүүмжилсэн хувцсыг автоклавдаж устгана.

132. Олон удаагийн хувцас бол хувцсыг тайлахаас өмнө болон тайлсны дараа автоклавдаж бүрэн хоргүйжүүлнэ.

Агаарын хөлгийн өргөгч төхөөрөмжтэй аврах ажиллагааны үед тусгай зориулалтын хувцас хэрэглэл

133. Нисдэг тэрэгний өргөгч төхөөрөмжтэй аврах ажиллагааны үед тусгай зориулалтын хувцас хэрэгслийг өмсөж хэрэглэнэ.

134. Стандартын шаардлага хангаагүй хамгаалах тусгай хувцас, хамгаалах хэрэгслийг ашиглахыг хориглоно.

135. Аврах ажиллагааны мэргэжилтэн, аврагч, эмч, сувилагч нар эрэн хайх, аврах ажиллагаанд оролцох үед

135.1. Хамгаалах хувцас

135.2. Каск /Аврах ажиллагааны мэргэжилтэн удирдагч холбооны төхөөрөмжтэй тусгай зориулалтын каск өмсөх/

135.3. Бээлий

135.4. Нүд хамгаалах хэрэгсэл /Нүдний шил/

135.5. Зориулалтын гутал /Уулын халтирахгүй ултай/

136. Хамгаалах тусгай хувцас хэрэгсэл тухайн алба хаагчийн биед таарсан байна.

137. Аврах ажиллагаанд ашиглагдах хамгаалах тусгай хувцас болон тусгай зориулалтын багаж хэрэгслийн аюулгүй ажиллагааг тогтмол шалгаж, хүлээлцэх, удирдлага зохион байгуулалтаар хангах чиг үүргийг тодорхой тусгах,

138. Тусгай зориулалтын болон аврах ажиллагааны багаж хэрэгслийн аюулгүй ажиллагааны зааварчилгааг ашиглагдах багаж тоног төхөөрөмж тус бүрээр боловсруулан батлуулах, хэрэгжилтийг хангуулах,

139. Аврах ажиллагаанд үүрэг гүйцэтгэх, ашиглагдах багаж хэрэгслийн жагсаалтыг гаргаж, хариуцан ажиллах албан тушаалтан тус бүрээр томилгоожуулана

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

АВРАХ АЖИЛЛАГААНЫ НИСДЭГ ТЭРЭГ, ТУСГАЙ ЗОРИУЛАЛТЫН АВТОМАШИН ТЕХНИК, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ, БАГАЖ ХЭРЭГСЭЛТЭЙ АЖИЛЛАХ ҮЕИЙН АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ЗААВАР

Нисдэг тэрэгтэй ажиллах үеийн аюулгүй ажиллагаа

140. Нисдэг тэргийг түлшээр цэнэглэх үеийн аюулгүй ажиллагаа

140.1. Шатахуунаар цэнэглэх үед агаарын хөлөгт зорчигч байхгүй, түлш цэнэглэж буй талын хаалгыг хааж, харин түлш цэнэглэж байгаа талын эсрэг талын хаалгыг нээлттэй байлгана.

140.2. Агаарын хөлөгт гал гарсан тохиолдолд (хүнд нэрвэгдсэн агаарын хөлгөөс буух боломжгүй) зорчигчдыг агаарын хөлгөөс буулгах нэг албан хаагч бэлэн байх ёстой. Агаарын хөлгийг газардуулж галын хорыг бэлэн байлгана.

140.3. Дараах зүйлсийг хатуу хориглоно:

140.3.1. Цэнэглэх явцад ил гал гаргах, тамхи татах,

140.3.2. Түлшээр цэнэглэх явцад гар утас ашиглах

140.3.3. Ангарын дотор агаарын хөлгийг шатахуунаар цэнэглэх

141. Нисдэг тэрэг аюулгүйн болон аврах ажиллагааны тоног төхөөрөмжөөр тоноглогдсон байна. Үүнд:

141.1. Нислэгийн ашиглалтын зааварт заасан галын хор

141.2. Цохилт, чөлөөт уналтын нөлөөгөөр автоматаар ажилладаг ба гар ажиллагаагаар идэвхжиж болдог ослын байршлын дохио дамжуулагч радио, тусгай дуут болон гэрлэн дохио

141.3. Анхны тусламжийн хайрцаг

141.4. Нүүлгэн шилжүүлэх зааварчилгаа

142. Аюулгүйн бүс: Аюулгүйн бүс нь газардах талбайн хэмжээтэй байх ба хамгийн бага хэмжээ (урт эсвэл диаметр) нь нисдэг тэрэгний хэмжээнээс 1.5 дахин том байна. Газрын тоног төхөөрөмжүүдээс (GSE) (цахилгаан тэжээл үүсгүүр, гал унтраагуур, шатахуун цэнэглэгч гм) бусад бүх хэрэгслийг аюулгүйн бүсийн гадна холдуулан зайчилсан байх ёстой.

143. Нисдэг тэргүүдийг гагцхүү Агаараас эрэн хайх, аврах ангиас олгосон чирэгч машин техник (чирэгч трактор) ашиглан тусгай бэлтгэгдсэн ажилтнаар гүйцэтгүүлнэ.

144. Сэнс хөдөлгүүр эд ангийг ажиллуулах эсвэл зогсоох

144.1. Нисдэг тэрэгний хөдөлгүүрийг асаах болон сэнс эргэлдэж эхлэхээс өмнө инженер техникийн ажилтан дараах зүйлсийг хянах ёстой:

144.2. Аюулгүйн бүс дотор нисэх ажиллагаанд оролцох эсвэл үйлчилгээ үзүүлж байгаа хүнээс бусад ямар ч гадны хүн байхын хориглоно..

144.3. Аюулгүйн бүсэд агаарын хөлөг хөөрөх үед түүнд гэмтэл учруулж болзошгүй аливаа эд зүйлсийг (даавуу, төмрийн өөдөс, хувцас гм) холдуулсан байна. Нисгэгч, инженер техникийн ажилтан нар хоорондоо маршал дохио холбоогоор мэдээ солилцсоны дараа хөдөлгүүр болон сэнс, эд ангийг ажиллуулна. Ажиллуулж эхэлсний дараа хөөрөхөөс өмнө инженер техникийн ажилтан нь талбайгаас газрын тоног төхөөрөмжүүдийг (GSE) (цахилгаан тэжээл үүсгүүр, гал унтраагч, шатахуун цэнэглэгч гм) чөлөөлсөн байх үүрэгтэй.

145. Ангиас гадуурх нислэгийн ажиллагаа

145.1. ОБЕГ-ын нисдэг тэрэгнүүд зарим тохиолдолд ангийн байрлалаас өөр газруудад урт богино хугацаагаар байрлах шаардлагатай ажиллагаанд оролцож болно.

145.2. Цаг агаарын гэнэтийн таагүй байдлаас үүдэлтэйгээр (цас, мөс, хяруу гэх мэт) нөмөр хамгаалалтгүй газарт өдрийн турш зогсож болно. Энэ тохиолдолд нисдэг тэргийг хамгаалалт, хараа хяналт бүхий хашаалсан газарт байрлуулах боломжуудыг хайна (цэнгэлдэх хүрээлэн, цэргийн талбай гэх мэт).

145.3. Боломжтой бол бэлчээр, мал нэвтэрч болохуйц газраас хол зогсох

145.4. Өвлийн улиралд: нисдэг тэргийг тодорхой хугацааны туршид ашиглалтын зохих нөхцөлийг хангах (хөлдөлт, мөстөлтөөс хамгаалах, гэсгээх, сэнсний давших ирмэгийн цасыг цэвэрлэх гм), бүхий л арга хэмжээг авах, аккумуляторыг салган дулаан газар хадгална.

Нисдэг тэргэнд ажиллах аюулгүй ажиллагаа

146. Агаарын хөлөг дээр хийгдэх бүх техник үйлчилгээний хэвшүүлэх ажил зөвхөн инженерийн зөвшөөрлөөр хийгдэнэ. Агаарын хөлөг дээр ажил эхэлсэн,

дууссан болон илэрсэн дутагдлууд, тэдгээрийг арилгасан тухайгаа төрөл бүрийн мэргэжилтнүүд инженерт мэдэгдэнэ. Бүхээгийн дэвтэр болон хяналтын хуудсанд агаарын хөлгийг нислэгт бэлтгэсэн тэмдэглэл хийж, гарын үсэг зурна.

147. Шаардлага хангаагүй газрын үйлчилгээний автотехник, газрын тусгай техник болон материал хэрэгслээр нисдэг тэргийг цэнэглэх, сумлах, шалгах, чирэхийг хатуу хориглоно.

148. Хөдөлгүүр асаахын өмнө гал унтраах багаж хэрэгсэл шаардлага хангасан байдлыг шалгана.

149. Хөдөлгүүрийг асааж шалгах хугацаанд нисгэгч /техникч/, газрын техникч /механикч/ нарын хооронд радио холбоо ба дохионы хэрэгсэлтэй байна.

150. Газрын техникч /механикч/ нь хөдөлгүүрийг асааж шалгаж буй нисгэгч /техникч/-д харагдахуйц аюулгүй зайд дохионы хэрэгсэл /улаан дарцаг, дохиур, гар чийдэн/-тэй байрлана.

151. Хөдөлгүүр ажиллаж байгаа үед нисдэг тэрэгний бүхээгт хөдөлгүүрийн удирдлагыг эзэнгүй орхихыг хориглоно.

152. Газарт агаарын хөлөг, нисэх хэрэгслүүдэд мөстөлт үүссэн тохиолдолд мөсийг бүрэн арилгахгүйгээр нислэгт гаргахыг хориглоно.

153. Агаарын хөлгийн техникийн үзлэг, үйлчилгээ, засварын ажил хийж гүйцэтгэхэд нисэх хэрэгслийн үүрэг зориулалт, бүтэц, ашиглалтыг судалж мэдсэн, техникийн ажиллагааны зохих мэдлэгийг эзэмшсэн, зохих баримт бичиг /мэргэжлийн диплом, үнэмлэх, тушаал шийдвэр г.м/ бүхий албан бичгээр баталгаажсан албан тушаалтныг ажиллуулна.

154. Инженер техникийн бүрэлдэхүүн нь хамгаалах тусгай хувцас, хүн нэг бүрийн хамгаалах хэрэгслийг тогтмол, зориулалтын дагуу бүрэн зөв өмсөж, хэрэглэнэ.

155. Инженер техникийн бүрэлдэхүүн нь хөдөлмөрийн аюулгүй байдлын арга техникийн шаардлагыг бүрэн биелүүлж байхаас гадна хамт ажиллаж буй хүмүүст түүнийг биелүүлж байх талаар хатуу шаардан сануулж байх үүрэгтэй.

156. Агаарын хөлгийг нислэгээс ирэхэд хөдөлгүүрүүд нь унтарч сэнсний эргэлт нь зогсмогц газардуулгыг буулгана.

157. Агаарын хөлгийн газардуулгыг буулгахгүйгээр түлшээр сумлах, сумалгаа хийж байх үед цахилгаан эд ангиудыг ажиллуулж шалгахыг хориглоно.

158. Агаарын хөлгийн аккумуляторыг солих, зөөвөрлөх, байрлуулах үед хамгаалах тусгай хувцас, гар хамгаалах хэрэгсэл өссөн байх ба ил задгай хүчлийн уусмал асгах, унагахгүй байх бүх нөхцөлийг хангасан байна.

159. Агаарын хөлгийн зогсоолын ойр орчимд байгаа 220-380В цахилгаан дамжуулах станцтай ажиллахдаа түүний бүрэн бүтэн байдлыг сайн шалгаж цахилгааны аюулгүй байдлыг мөрдөж ажиллана.

160. Техникийн үзлэг үйлчилгээ болон засварын ажилд зөвхөн зориулалтын эвдрэл, гэмтэлгүй багаж, тоног төхөөрөмжийг ашиглана.

161. Нисдэг тэрэгний дээр ажиллах үед түлхүүр багаж, эд анги, агрегатууд, сэлбэг хэрэгслүүдийг унахаас урьдчилан сэргийлэх, гадны биет авч гарахыг хориглоно.

162. Агаарын хөлөг дээр зориулалтын бус зүйл ашиглан авирч гарах, үсэрч буухыг хориглоно.

163. Avgas 100 LL бензин ба ТС-1 керосиноор гараа угаах, нүцгэн биедээ хүргэхийг хориглоно

164. Хөдөлгүүр ассаны дараа нисдэг тэрэгнээс тээврийн хэрэгслийг техникчийн дохиогоор хөдөлгөөн үйлдүүлнэ.

165. Суурин цахилгаан тэжээлийн залгуурыг салгахдаа хөдөлгүүрийн гарах байгууламжаас гарах хийн урсгалын болон даах сэнсний эргэлтийн бүсэд орж ажиллахыг хориглоно.

166. Агаарын хөлөгт техникийн үзлэг үйлчилгээний шат, тэргэнцэр, тавцангууд руу өгсөх, буух үйлдлийг нүүрэн талаараа гишгүүрүүд рүү харж бариулаас гараараа барьж гүйцэтгэнэ.

167. Агаарын хөлгийг түлш, масло, шингэнээр цэнэглэхдээ түлшний савны гадуур болон халиаж асгахыг хориглоно.

168. Агаарын хөлөгт цэвэрлэгээ хийхдээ шатах тослох материал ашиглахыг хориглоно.

169. Зөөврийн халаагч, механизмуудыг ашиглахдаа аюулгүй ажиллагааны зааврыг хатуу мөрдөж ажиллана.

170. Агаарын хөлөгт үйлчилгээ үзүүлдэг машин механизмтай харьцах дэс дарааллыг нарийн баримталж, аюулгүй байдлыг чанд сахин ажиллана.

171. Агаарын хөлгийн техникийн үзлэг, үйлчилгээний үед галын аюулгүй байдлыг бүрэн найдвартай хангаж ажиллана.

172. Хөдөлгүүр, редуктор болон эд ангийг солиход инженерийн албыг байлцуулна.

173. Агаарын хөлөг дээр ажиллах бие бүрэлдэхүүн техник ашиглалтын заавар, дүрэм журмыг судалсан байна.

174. Цэнэглэгч автомашин нисдэг тэргийг цэнэглэхдээ өөрөө талбайг бүрэн чөлөөлөхөд хүрэлцэхүйц шатахуунтай байна.

175. Нисдэг тэрэг дээр үзлэг хийхдээ эвдрэл гэмтэлгүй зөөврийн гэрэл ашиглана.

176. Цацраг идэвхт төхөөрөмжтэй ажиллахдаа аюулгүй ажиллагааны дүрмийг мөрдөж ажиллана.

177. Агаарын хөлгийн техникийн үзлэг, үйлчилгээний үед галын аюулгүй байдлыг бүрэн найдвартай хангаж ажиллана.

178. Агаарын хөлгийг ангар байгууламжаас гаргаж шилжүүлэн байрлуулах явцад анхаарал сэрэмжтэй, ойр орших шат, тавцанг холдуулах, нэг нэгнийхээ өгсөн команд дохиог сайн ойлгож дамжуулна.

179. Агаарын хөлгийн цахилгаан тусгай тоноглол болон радиоэлектрон тоноглолын ашиглалтын шаардлага

180. Дараах тохиолдолд нисдэг тэргэнд зай хураагуур тавих, орхихыг хориглоно.

180.1. Эвдрэл гэмтэлтэй

180.2. Нисдэг тэргийг хадгалалтад байх үед

180.3. Нисдэг тэргийг хасах хэмд удаан хугацаагаар зогсоох үед

180.4. Хүчил болон шүлтийн зай хураагуурын баттерейг нэг дор хадгалах цэнэглэх

181. Гироскофийн төхөөрөмж орсон системийг ашиглахдаа гадны доргилт цохилтоос хамгаалах арга хэмжээ авахгүйгээр тээвэрлэх, гироскоф төхөөрөмжийг шалгахгүйгээр хөөрөлт, буулт хийх зэргээс урьдчилан сэргийлэх шаардлагатай.

182. Агаарын даралтаар ажилладаг төмөр хоолой, резинэн гуурсыг зөв залгахын тулд тэдгээрт өнгөөр ялгасан тэмдэг тавина.

183. Гидродатчик, авиагоризантыг сольсон үед нисдэг тэргийг агаарт шалгах нислэг үйлдэж тэдгээрийн ажиллагааг шалгана.

Онгоцонд суух, буух аюулгүй ажиллагаа

184. Онгоцонд суухдаа ардаа сэнстэй онгоцны урдуур нь, урдаа сэнстэй онгоцны араар нь тойрч, жингийн дарааллаар жагсан бага жинтэйгээсээ эхлэн онгоцонд орно.

185. Онгоцон дотор онгоцны эд анги, бусдын шүхрээр оролдох, онгоцон дотор босож явах, тогтоосон дараалал, журмыг өөрчлөх, тооцоологч, гаргагчийн үйл ажиллагаанд садаа болохыг хориглоно.

186. Шүхэрчин онгоцноос гараад:

186.1. Шүхэртээ хяналт хийнэ. (Бүрэн задарсан эсэх, бункерийн байдал, оосрууд гэх мэт).

186.2. Удирдлагын чагтыг авч эргэн тойрондоо хяналт хийнэ. (Ойрхон шүхэрчин байгаа эсэх, шүхэрчинтэй ойртож байгаа эсэх гэх мэт)

186.3. Агаарт шүхэрчид хэт ойртсон тохиолдолд түрүүлж харсан нь команд өгч аль болох түргэн холдох арга хэмжээ авна.

186.4. Буух цэгээ олж харна.

186.5. Салхины чигийг тогтооно. Газраас 100 м-ийн зайд салхи сөрөн, буух газраа сонгосон байна.

186.6. Үндсэн шүхэр хагас задарсан, эргэлдсэн тогтворгүй хөдөлгөөнтэй, доошлолтын хурд ихтэй үед үндсэн шүхрийн салгах замгийг салган нөөц шүхрийг задална. Энэ үед үндсэн шүхрийг заавал салгаж байж нөөц шүхрийг задална.

187. Онгоцноос гарах үед хориглох зүйл.

187.1. Командгүй онгоцноос гарах.

187.2. Онгоцны хаалганы хажуу, дээд тал руу цохиж гарах.

187.3. Уртасгагчийг суганы доогуураа ба хүзүү, хөлөөрөө ороох.

187.4. Онгоцны хаалга, бариулаас дүүжлэгдэх.

187.5. Онгоцноос салалт муутай үсрэх, онгоцны их биеийг дагаж гулсах.

187.6. Гарч байгаа шүхэрчний болон гаргагчийн биеэс барих.

187.7. Хэт дээшээ үсэрч гарах, хөл гарыг салгах болон эргэлдэж гарах зэргийг хориглоно.

188. Газардахад анхаарах зүйл.

188.1. Газардах орчноо зөв сонгох.

188.2. Газар ойртолтыг мэдэрч байх.

188.3. Газраас өгч байгаа командыг сонсох.

188.4. Газардах үед доор хүн байвал “Агаар” команд өгөх.

188.5. Салхины эсрэг харж газардахад хурдан эргэж салхины уруу харах.

188.6. Их салхитай үед чирэгдэх тохиолдолд салдаг замгийг салгах ба бункерийн газартай харьцаж байгаа доод хэсгийн хэсэг оосруудаас татаж бункерийг унтраах.

188.7. Шүхэрчин 100м өндөрт ирмэгц салхиа сөрж газардах орчноо сонгосон байх ба ямар нэгэн саад (хашаа, байшин, шон, хад, чулуу, өндөр хүчдэл, машин гэх мэт) байгалийн саадуудаас аль болох зайлсхийж бууна.

188.8. Шүхрийн удирдлагыг огцом ширүүн хийх, гарыг салгаж удирдах, нам доор эргэлт хийх, салхины уруу ба хөндлөн газардахыг хориглоно.

188.9. Спорт шүхрийн удирдлагын доод горимд удаан барьж ар тийшээ “СРЫВ” уналтад орохоос болгоомжлох.

188.10. Уналтад “СРЫВ”-д орсон тохиолдолд удирдлагын чагтыг 15-20 см хэмжээтэй зөөлөн буцааж өгөх ба дээш огцом өгөхийг хориглоно.

189. Онгоц буух зурваст газардсан тохиолдолд шүхрээ авч зурвасыг хурдан чөлөөлж өгнө.

190. Хэт нам өндрөөс буух үеийн ажиллагаа

190.1. Нам өндрөөс (150-300м) буухад нөөц шүхэр ашиглах боломжгүйг анхаарах.

190.2. Нам өндрөөс онгоцноос гарахдаа шүхэр задартал гарсан байрлалаа хадгалах.

190.3. Шүхэр задармагц газардалтад бэлтгэхийг анхаарах.

Тусгай зориулалтын автомашин, тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн техникийн үйлчилгээнд (ТҮ) тавигдах аюулгүй ажиллагаа

191. Тусгай зориулалтын автомашин, техник, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл нь стандартад нийцсэн, бие бүрэлдэхүүний эрүүл мэнд, аюулгүй ажиллагааг хангасан байна.

192. Автомашин техник, тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээг ТҮӨБ, ТҮ-1, ТҮ-2, ТҮУ (ОБЕГ-ын даргын 2016.06.02-ны өдрийн А/157 дугаар тушаал)-ыг тогтоосон хугацаанд аюулгүй ажиллагааг хангаж хийнэ.

193. Багаж хэрэгслийг томилгоот ээлж хүлээлцэх үед бие бүрэлдэхүүн нэг бүрчлэн шалгаж, салааны захирагч, бүлгийн даргад биечлэн танилцуулсны дараа хэрэглэнэ.

194. Аврах олс, жижиг сүхийг тусгай гэрэнд хийнэ.

195. Тусгай зориулалтын автомашин нь аврах, сэргээн босгох үйл ажиллагаанд шаардлагатай тоног төхөөрөмж, багаж хэрэгслээр тоноглогдсон байна.

196. Стандартын шаардлага хангаагүй автомашин, тоног төхөөрөмж, багаж хэрэгслийг ашиглахыг хориглоно.

197. Тусгай зориулалтын автомашин, техник, тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн засвар үйлчилгээг мэргэжлийн байгууллагаар авто засварын газарт хийлгэнэ.

198. Засвар үйлчилгээ мэргэжлийн байгууллагаар хийлгэх боломжгүй заалшгүй нөхцөлд дараах аюулгүй ажиллагааг хангасан байна. Үүнд:

198.1. Засвар, техникийн үйлчилгээг хийх ажлын төлөвлөгөө, удирдамжийг шууд удирдах албан тушаалтнаар баталгаажуулна.

198.2. Засвар үйлчилгээ хийж буй алба хаагчдад техник, тоног төхөөрөмж хариуцсан мэргэжилтэн биечлэн хяналт тавьж, зааварчилгаа өгч баталгаажуулна.

198.3. Бүх төрлийн засвар үйлчилгээг хийхээс өмнө автомашин техникийг бүрэн унтрааж, цахилгаан тоног төхөөрөмж, багаж хэрэгслийг хүчдэлээс салгана.

198.4. Засвар, үйлчилгээ хийх алба хаагч нь хийгдэх ажлын онцлогоос хамаарч

гар, нүүр, хөл хамгаалах хэрэгсэл, хамгаалах тусгай хувцастай байна.

198.5. Тусгай зориулалтын автомашиныг өргөх төхөөрөмжөөр /демократ/ өргөхдөө тэгш, шигдэхээргүй (газарт шигдэхээр бол хамгаалалт ивүүр тавьж болно) газар байрлуулж, гар тоормос татаж, дугуйн ивүүр хийсний дараа өргөх ажиллагааг эхлэх ба өргөх ажиллагаа дууссаны дараа автомашины өргөгдсөн хэсэгт тулгуур хийнэ.

Автомеханик шатны автомашин

199. Автомеханик шатны автомашиныг / цаашид автомеханик шат гэх/ 3-с доошгүй жил ажилласан сагстай өргөгчийн операторын сургалтад суусан хүнийг томилно.

200. Автомеханик шат байрлуулах талбай нь хатуу хучилттай 6 градусаас ихгүй налуу байна.

201. Автомеханик шатыг өгөгдсөн цэгт зөвшөөрөгдсөн өнцгөөр цонх, тагт, дээвэр зэрэгт шатыг чиглүүлэн сунгаж, налуулж болохоор зайнд байрлуулж ажиллуулна.

202. Автомеханик шатыг цахилгаан гүйдлийн болон радио, холбооны шугамд хүргэхээргүйгээр сунгана.

203. Барилгын хэсэгт сунган байрлуулсан автомеханик шатаар буух, өгсөх гал сөнөөгчдийн хоорондын зай 3 метрээс багагүй байна. Хэрэв шатаа барилгын хэсэгт тулгаагүй хөндий, 60 хэмээс ихгүй налуу өнцөгтэй байрлуулсан бол зөвхөн нэг гал сөнөөгч ажиллана. Харин шатны сунгалтын налуу өнцөг нь 60-75 хэм байвал шатан дээр 10 метрийн зайтай хоёр гал сөнөөгч, 75-80 хэм налуу өнцөгтэй сунгасан үед 5 метрийн зайтай гурван гал сөнөөгч ажиллана.

204. Агаар механикийн хөөсний болон суурьтай хушууг автомеханик шат нь дээр бэхэлж ажиллуулахдаа дараах зүйлийг баримтална. Үүнд:

204.1. Автомеханик шатыг үйлдвэрээс тогтоосон аюулгүй ажиллагааны зааврыг баримтлан ажиллуулна.

204.2. Автомеханик шатыг ажиллуулахдаа эргэлтийн хурдыг тохируулж ажиллах

204.3. Даралтын хоолойг шатыг голлуулан дэлгэж бэхэлгээ хийх

204.4. Даралтын хоолойн усны даралтыг огцом нэмэгдүүлэхгүй, багасгахгүй байх

204.5. Гал унтраах бодис гаргах хушуунд ирэх даралт нь 0.5-0.7 кгс/см² байх

205. Автомеханик шатыг сунгах үед шат тэгшлэлтийн автоматыг салгах, шатыг сунгасан нөхцөлд автомашиныг байрнаас нь хөдөлгөхийг хориглоно.

206. Шатыг гар ажиллагаагаар сунгахад шатны сунгалтын урт, налуугийн өнцгийг зохих заалтын дагуу байнга хянах. Шатыг сунгахын өмнө дөрвөн тулгуурыг заавал буулгасан байх шаардлагатай.

207. Автомеханик шатыг ажиллуулахдаа үйлдвэрээс техникийн тодорхойлолтоор өгөгдсөн аюулгүй ажиллагааны зааврыг мөрдөж ажиллана.

208. Автомеханик шатыг хүчдэлтэй байгаа гүйдэл дамжуулах хэсэгтэй ойр сунгах, ажиллуулах тохиолдолд доорх хүснэгтэд тогтоосон аюулгүй зайн хэмжээ баримтална.

Эрчим хүчний сайдын 2014 оны 101 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтын / 1дүгээр хүснэгт/ -ээр

Хүчдэл (кВ)		Ажилтан ба тэдний хэрэглэж байгаа багаж хэрэгсэл, түр хаалт хашилт хүртэл зай (м)	Автомашин, ачаа өргөх кран, оосорлох хэрэгсэл ба ачааны ойртож болох зай (м)
1кВ хүртэл	Агаарын шугамд	0.6	1.0
	Бусад цахилгаан байгууламжид	Норм тогтоохгүй, хүрч шүргэж болохгүй	1.0
1-35 кВ		0.6	1.0
60*;110 кВ		1.0	1.5
220 кВ		2.0	2.5
330 кВ		2.5	3.5
400*; 500 кВ		3.5	4.5
*-тогтмол гүйдэл			

209. Автомеханик шатыг албаны ажлаас бусад зүйлд ашиглахыг хориглоно.

Гал унтраах хоолойн албаны автомашин

210. Гал унтраах хоолой албаны машиныг усны эх үүсвэрээс 2.5 метрээс багагүй зайд байрлуулна.

211. Гал унтраах үйл ажиллагаанд бие бүрэлдэхүүн даралтын хоолойг нэг бүрчлэн шалгаж, салааны захирагч, бүлгийн даргад биечлэн танилцуулсны дараа хэрэглэнэ.

212. Хоолойн албаны автомашины гал унтраах даралтын хоолой дэлгэх үед багаж хэрэгслийг гэмтээх хурц үзүүртэй болон шатах материалаас хол байрлуулан ажиллуулна авто замын хэсэгт хоолойн гүүр ашиглана.

213. Даралтын хоолойн үзлэг шалгалтыг өдөр тутмын туршин шалгах, үйлчилгээ хийх зааврын дагуу анги, салбарын дарга, захирагч нар явуулж, илэрсэн зөрчил, дутагдлыг арилгуулах талаар холбогдох албан тушаалтанд танилцуулан, хяналтын хуудсанд тэмдэглэж, баримтжуулна.

214. Хоолойн албаны автомашины жолооч нь хоолойн төв шугамыг дэлгэхдээ гэрэл, дуут дохиог өгч болно.

215. Хоолойн албаны автомашинд даралтын хоолойг эвхэх дамарт ороох үед гартаа гэмтэл учруулахаас сэргийлж хүрдний бариулаас барьж, даралтын хоолойг зааварын дагуу бэхэлж байрлуулна.

216. Гал түймэр унтраах удирдагчийн шийдвэргүйгээр хоолойг дэлгэх, даралт өгөх, хөдөлгөөн үйлдэхийг хориглоно.

Хөөс, нунтагаар гал унтраах автомашин

217. Хөөс, нунтагаар унтраах зориулалтын автомашиныг хөөс үүсгэгч, нунтаг бодисоор цэнэглэх үед алба хаагч нь хамгаалалтын нүдний шил, арьсны өнгөн хэсгийг далдалсан бээлий, ус нэвтрэхгүй хувцас өмссөн байна.

218. Цэнэглэж дууссаны дараа арьс болон нүдний салс бүрхэвчийг цэвэр ус

эсвэл давсны уусмалаар /2 хувийн борын хүчлийн уусмал/ угааж цэвэрлэнэ.

219. Хөөс үүсгэгч, нунтаг бодисоор цэнэглэх үед автомашиныг тавиулангаас гаргаж тусгайлсан багаж хэрэгслээр цэнэглэнэ.

220. Цахилгаан хүчдэл болон цахилгаан тоног төхөөрөмжид гарсан гал түймрийг унтраах үед зориулалтын автомашины газардуулгыг хийсэн байна.

Өөрөө явагч машин механизмтай ажиллах үеийн аюулгүй ажиллагаа

221. Зам засах, саад арилгах зориулалт бүхий өөрөө явагч, машин механизмуудыг механик жолоочийн дамжаа төгссөн, тусгай тоног төхөөрөмж ажиллуулах эрхийн үнэмлэхтэй, техникийн аюулгүй ажиллагааны дүрэмтэй танилцсан алба хаагчийг ажиллуулна.

222. Ажилд гарахын өмнө механик, жолооч нар өөрийн хариуцсан өөрөө явагч машин механизмд ТҮ-1, ТҮ-2-ын үзлэг хийж, илэрсэн эвдрэл гэмтлийг засна.

223. Өвлийн улиралд машин техникийн халуун тогоог зохих журмын дагуу ажиллуулж, хөдөлгүүрийн тос халсан үед асаана.

224. Шөнийн цагт ажиллахад шаардлагатай гэрэлтүүлгийн хэрэгслүүд бүрэн ажиллагаатай, ажлын байрыг сайн гэрэлтүүлж чадахуйц байна.

225. Хол зайд (10 км-ээс илүү) шилжилт хийхэд газар шорооны ажлын тоноглолыг аяны байдалд тавина. Хөмрөгийг аяны байдалд тавихын өмнө түүний жигүүр хөмрөгийн бэхэлгээг заавал шалгана.

226. Бутархай үйрмэг, сул хөрсөнд бүх төрлийн ажлыг гүйцэтгэхдээ ухрах хөдөлгөөн, эргэлт хийхгүй байж, машины хазайлтыг 16 градусаас хэтрүүлэхгүй.

227. Машин, механизмын хөдөлгүүрийг зогсоосны дараа зай хураагуурын товчлуурыг заавал салгана. Налуу газар тавих тохиолдолд дугуйнд ивүүр хийнэ.

228. Ажил дууссаны дараа машин механизмын гидро тулгуурыг эвхэж цоожилно.

229. Зам засах, саад арилгах машин, механизмыг ажиллуулах үед дараах зүйлийг хориглоно. Үүнд:

229.1. Автомашин, механизмыг асаалттай эзэнгүй орхих

229.2. Техникийн хувьд бүрэн бус тоноглолтой байх

229.3. Ажлын үед засвар, тохиргоо, тосолгооны ажил хийх, буух, суух

229.4. Хөдөлгүүр ажиллаж байгаа үед тоног төхөөрөмж дээр гарах, суух

229.5. Ажлын үед шахагч механизмын урд зогсох, доогуур явах, ойр орчинд ажиллах

229.6. Налуу газар хөндлөн чиглэлд (30 градусаас дээш) ажиллах

229.7. Гидро механизмыг дутуу өргөж дээд хурдаар явах, огцом эргэлт хийх

230. Техникийн бүрэн бүтэн байдлыг хангаагүй машин, механизмыг ашиглахыг хориглоно.

Өргөх, ачих машин, механизмын аюулгүй ажиллагаа

231. Өргөх, ачих зориулалттай механизмуудыг зохих мэргэжил эзэмшсэн, тусгай тоног төхөөрөмж ажиллуулах эрхийн үнэмлэхтэй, техникийн аюулгүй ажиллагааны дүрэмтэй танилцсан хүн ажиллуулна.

232. Ажил эхлэхийн өмнө дэгээ, татлага, татлага ороох хүрд, тоормосны бүрэн бүтэн ажиллагааг шалгана.

233. Өргөх, ачих механизмаар ажил үүрэг гүйцэтгэхдээ гидро тулгууруудыг

сунгаж хатуу хөрсөнд (гадаргууд) буулгаж тулна.

234. Экскаватораар газар шороо ухах, ачих ажил гүйцэтгэхдээ шанагыг хөрснөөс бүрэн хөндийрсний дараа тавцанг эргүүлнэ.

235. Ачааг өргөхийн өмнө экскаваторчин нь заавал дохио өгөх бөгөөд ачааг 0.1-0.2 м өндөрт урьдчилан өргөж торомз найдвартай ажиллаж байгааг болон экскаваторын тогтвортой байдлыг шалгана.

236. Ачаатай шанагыг тээврийн хэрэгсэл болон экскаваторын бүхээг дээгүүр зөөвөрлөхийг хориглоно.

237. Өргөгч цамхгийн жолооч, оосорлогч нар хоорондоо харилцах дохиог сайн мэддэг байвал зохино.

238. Дэгээг дээш өргөхөд түүний чиглүүлэх дамар, сумны үзүүрийн блок хоёрын хоорондох зай 0.5 м-ээс багагүй байна.

239. Дэгээнд ачааг өлгөхдөө ган татлага, гинжээр мултарч унахааргүй оосорлох бөгөөд оосруудын хоорондох өнцөг 90 хэмээс ихгүй байна.

240. Оосор татлага буюу гинжийг дэгээнд өлгөхдөө түүнийг зангирах, гогцоорох, мушгигдахаас сэргийлэх.

241. Ачаа өргөж байх үед оосрын бүх гогцоонууд жигд ачаалалтай байгаа эсэхийг байнга хянана.

242. Нэг ачааг хоёр авто өргөгчөөр өргөн шилжүүлэх үед оосор нь эгц босоо байхаас гадна өргөгчийн даацаас ачааны жин бага байна.

243. Овор багатай ачааг зориулалтын саванд хийж өргөх бөгөөд нурж унахаар овоолохгүй.

244. Ачаа өргөж, буулгахдаа оосрыг хавчуулахгүйн тулд түүний дор ивүүр тавина.

245. Өргөгч цамхгаар өргөсөн ачааг замд тохиолдох саадаас 5 м-ээс дээш өргөж, хажуу тийш нь шилжүүлэн тавина.

246. Ажил дууссаны дараа гидро тулгууруудыг эвхэж, эргэх тавцанг тээврийн байдалд оруулан цоожилж, өргөх механизмыг зохих тулгуур дээр байрлуулна.

247. Өргөх, зөөх тоноглолтой ажиллах үед дараах зүйлийг хориглоно. Үүнд:

247.1. Жин нь үл мэдэгдэх болон даацаас илүү жинтэй ачаа өргөх, өргөгдсөн ачааны доогуур явахыг

247.2. Шороогоор болон бусад зүйлээр дарагдсан, газар наалдаж хөлдсөн, бэхлэгдсэн зүйлийг өргөж татах, ховхлох

247.3. Ачааг өргөхдөө угзрах, савлуулах, огцом шилжүүлэх, ивүүр дээр тогтвортой байрлуулахаас өмнө оосор (гинж)-ыг мултлах

247.4. Ажлын дараа болон завсарлагааны цагаар дэгээнд ачааг дүүжлээтэй орхих, өргөгч цамхагт ажиллах үед чирэгчийн бүхээг дотор болон тавцан дээр хүн байлгах

247.5. Газар дээр байгаа ачааг краны татлагаар чирэх, татлага орооцолдсон буюу дэгээ мултарсан үед өргөх

247.6. Салхины хурд 15-18 м/сек байхад ажиллуулах, хүнд шаантаг хэлбэртэй төмрийн тусламжтайгаар хөрс ухах, бутлах ажил гүйцэтгэх

Гинжит хөвөгч тээвэрлэгчтэй ажиллах үеийн аюулгүй ажиллагаа

248. Гинжит хөвөгч тээвэрлэгчийн ашиглалт, аюулгүй ажиллагааг сайн мэддэг, дадлага туршлагатай эрхийн үнэмлэхтэй хүн жолоодно.

249. Ажилд гарахын өмнө машинд үзлэг шалгалт хийж илэрсэн дутагдлыг арилгана.

250. Хөдөлгүүрийг асаах, хөдөлгөөн үйлдэхийн өмнө анхааруулах дохио өгч, ухрах хөдөлгөөнийг машины ахлагч буюу чиглүүлэгчийн дохиогоор үйлдэнэ.

251. Хөвөгч тээвэрлэгчийн хөдөлгүүр ажиллах үед буух, суух ажиллагааг зөвхөн буулгагч тавцанг ашиглан гүйцэтгэнэ.

252. Тэвш нь дээр ачааг гинж, оосроор хөдөлгөөнгүй бэхэлж, ус руу орохын өмнө хуяг, дээд нээлхий, ус асгах нүхний бөглөө, буулгах тавцан нягт хаагдсан эсэх, ус шавхах шахуургуудын ажиллагаа зэргийг нэг бүрчлэн шалгаж, илэрсэн дутагдлыг арилгана.

253. Усанд орохын өмнө давлагааны хаалтыг ажлын байдалд оруулж, зангууг хаяхад бэлтгэн, тоотууд аврах хантааз өмсөж, усны гүн, автомашины эд ангийг гэмтээж болзошгүй саад, эргийн байдал зэргийг урьдчилан шалгана.

254. Усанд орохдоо нэг ба хоёрдугаар араагаар урсгалд тэгш өнцгөөр, ширүүн урсгалтай бол 30-40 градусын өнцгөөр хамгийн дээд хурдаар гарна.

255. Усанд хөвөх үед тоотууд нь хуягт орсон усны төвшин, шавхах шахуургуудын ажиллагааг байнга хянана.

256. Гинжит хөвөгч тээвэрлэгчтэй ажиллах үед дараах зүйлийг хориглоно. Үүнд:

256.1. Тоотууд нь өөр хоорондоо харилцах холбооны болон дохионы хэрэгсэл ажилгүй болсон тохиолдолд ажиллах

256.2. Хөдөлгөөн үйлдэж байгаа үед тоот нь зориулалтын малгайгүй ажиллах, бүхээгийн тагийг бэхлэхгүй байхаас гадна түүн дээр гарч суух

256.3. Ачаа ачих, буулгах үед буулгах тавцангийн дор буюу ойролцоо хүн байлгах, тэвшний хөдөлгөөнт суурь дээр тавилгүйгээр ачааг чирэх

256.4. Гинжит хөвөгч тээвэрлэгчийг эгц эрэгтэй газраар ус руу оруулах, гаргах, даацаас хэтэрсэн ачаа тээвэрлэх

Аврах завьтай ажиллах үеийн аюулгүй ажиллагаа

257. Аврах завьтай ажиллах аюулгүй ажиллагааг Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2013 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн А/921 дүгээр тушаалаар баталсан “Уснаас эрэн хайх аврах ажиллагааг зохион байгуулах журам”-ыг удирдлага болгон зохион байгуулна.

258. Усанд хөвөхийн өмнө аврах завинд байх зүйлсийг (сэлүүр, хөл хөөрөг, эмийн сан, аврах хантааз, аврах цагариг, усчны хувцас, усны гүн хэмжигч, завь нөхөх хэрэгсэл, усны олс, зангуу гэх мэт) сайтар шалгана.

259. Аврах ажиллагааны завийг сард нэг удаа урсгал ус, нуур, цөөрөмд тавьж шалгана.

260. Ачааг завинд тал бүрдээ тэнцвэртэй байхаар ачна.

261. Аврах завины аль нэг тасалгаанаас хий алдвал хий гарч байгаа талаар завинд ус орохоос сэргийлж ачааг хөнгөлж, яаралтай эрэг рүү гарна.

262. Аврах завины хөдөлгүүрийн аюулгүй ажиллагааг шалгаж шаардагдах шатахууныг нөөцлөн авч явна.

263. Эргээс холдох зайг цаг агаарын байдалтай уялдуулж зохицуулна.

264. Аврах завьтай ажиллахад дараах зүйлийг хориглоно.

264.1. Хийлдэг завийг автомашины хий шахагчаар хийлэх, завины гадаргууг идэмхий шингэн (бодис) -ээр арчих

264.2. Хий султай завь ашиглах, тогтоосон даацаас хэтэрсэн ачаа ачих, илүү чадалтай хөдөлгүүр хэрэглэх, завийг хуурай газар чирэх.

264.3. Завин дээр халуун эд зүйлс ачих, зориулалтын бусаар ашиглах.

264.4. Завийг хүйтэн температурт хадгалахыг хориглоно. Нарны тусгалаас хамгаалж +25 агаарын градус хадгална. Хадгалалтын өмнө завийг сайтар цэвэрлэж хуурай болгоно.

264.5. Аврах ажиллагаанд цоорхой завь, богино олс, урагдаж гэмтсэн хөвөгч хантааз зэрэг шаардлага хангахгүй хэрэгсэл ашиглах, үсэрч суух.

264.6. Завинд нэг нэгээрээ орж жигд тарж суух бөгөөд хөвж байгаа үед зогсож явахыг хориглоно.

264.7. Завинд шовх өсгийтэй гуталтай суух

264.8. Завин дээр тамхи татах болон гал гаргахгүй байх

264.9. Завь моторт хөдөлгүүртэй байсан ч сэлүүргүй явах

264.10. Завин дээр мал амьтан зориулалтын бус зүйлс ачих.

Аврах хөнгөн завь /катер/ жолоодох үеийн аюулгүй ажиллагаа

265. Аврах хөнгөн завь ашиглах болон техникийн аюулгүй байдлыг хангах тусгай мэдлэгийг сургалтаар эзэмшсэн мэргэжлийн үнэмлэхтэй, эрүүл мэндээр тэнцсэн алба хаагч байна.

266. Аврах хөнгөн завины жолооч нь ажиллагааг гүйцэтгэх үед болзошгүй хүчин зүйлүүдийг мэдсэн байх ёстой. Үүнд:

266.1. Хөнгөн шатамхай бодисууд;

266.2. Хар тугалгатай бензин;

266.3. Тоног төхөөрөмж, хэрэгсэл, бэхэлгээ;

266.4. Усанд хүн унах;

266.5. Дуу чимээ;

266.6. Чичиргээ;

266.7. Нар салхи, дулааны нөлөө.

267. Шатамхай бодис (уур, хий), аюулгүй ажиллагааны дүрэм зөрчсөн нөхцөлд гал түймэр гарах, дэлбэрэлт болох аюултай нөхцөлд үүсэхээс сэргийлэх.

268. Тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл болон дагалдах хэрэгслийг зориулалтыг бусаар ашиглахыг хориглоно.

269. Зөвхөн техникийн гэмтэлгүй аврах завь, аврах хөнгөн завийг ажиллахыг зөвшөөрнө.

270. Аврах хөнгөн завины жолооч дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

270.1. Ажиллах үедээ мансууруулах бодис, согтууруулах ундаа хэрэглээгүй

270.2. Усан орчинд хөдөлгөөний үеийн аюулгүй ажиллагааны дүрмийг баримтлах

270.3. Галын аюулгүй байдлын дүрмийг баримтлах.

271. Аврах хөнгөн завины жолооч усны осол гарсан тохиолдолд нэрвэгдэгсдэд тусламж үзүүлэх чадвартай байх ёстой.

272. Аврах хөнгөн завины жолооч аюулгүй ажиллагааны шаардлагыг зөрчих тохиолдолд түүнийг холбогдох хууль, дүрмийн дагуу хариуцлага хүлээнэ

273. Удирдлагын заавар нь аюулгүй байдлын шаардлагыг зөрчиж байгаа бол аврах хөнгөн завины жолооч дагахгүй байх эрхтэй.

274. Аврах хөнгөн завины жолооч хувийн хамгаалалтын /аврах хантааз, бээлийтэй/ тоног төхөөрөмжийг ажиллуулна.

275. Аврах хөнгөн завинд зорчих хүний тооны хязгаарт тохирсон аврах хантааз, шаардлагатай үед ашиглах аврах цагариг, олсыг бэхэлсэн байна.

276. Аврах хөнгөн завинд зорчих хүн нэг бүр аврах хантааз хэрэглэнэ.

277. Аврах хөнгөн завины жолооч нь энэ дүрэм, Зам тээвэр, хөгжлийн сайдын 2017 оны 263 дугаар тушаал “Усан замын тээврийн хэрэгслийн хөвөлтийн аюулгүй байдлын (усан замын тээврийн хэрэгслийг удирдах, жолоодох) дүрмийг мөрдөнө.

Ариутгагч, шүршүүрийн авто төхөөрөмж (ДДА-ЗБ)-ийг ажиллуулах үеийн аюулгүй ажиллагаа

278. Тогоог галлахын өмнө автомашины түлшний сав хаалттай эсэхийг шалгана.

279. Ажиллаж буй уурын тогооны хэвийн ажиллагаа, ажиллуулж дууссаны дараа гал унтарсан эсэх болон тогооны даралт атмосферийн даралттай адил болсон эсэхэд тогтмол хяналт тавина.

280. Уурын тогооны хамгаалах хавхалга 4.2 кг/см^2 их даралттай үед усны түвшин заагч шилэнд үзэгдэхгүй болох, гар насос, уур урсгуурын сэлгүүр, даралт хэмжигч ажиллагаагүй болсон тохиолдол бүрд тогооны ажиллагааг нэн даруй зогсооно.

281. Шүршүүрт өгөх усны халуун 42 градус, хувцсанд ариутгал хийхдээ 98 градусаас илүү өгч болохгүй.

282. Шингэн түлшийг дамжуулахдаа асгаж дусаахгүй байх, төхөөрөмжийн гал унтраах хэрэгслийг байнга бэлэн байлгана. Өвлийн улиралд гар насос, ус дамжуулах болон сифон хоолойнууд, буцаах хавхлаг, даралт хэмжигч зэргийг халуун уураар үе үе халааж байх шаардлагатай,

283. Тогоог галлаж байх үедээ тогооны галын аманд эгц өөдөөс нь харж галлаж болохгүй хажуу талаас нь галлах хэрэгтэй.

284. Ашиглахыг хориглосон болон тусгай зориулалтын тоног төхөөрөмж, багаж хэрэгслийг шалгаж, тохируулах нэгжээс шалгаагүй тогоог ажиллуулж болохгүй.

285. Ариутгагч, шүршүүрийн авто төхөөрөмж (ДДА-ЗБ)-ийг ажиллуулахад хориглох зүйлүүд:

285.1. ДДА-ЗБ тогоог ажиллуулах мэдлэг, дадлагагүй алба хаагчийг бие даалган ганцаар ажиллуулах

285.2. Уурын тогоог усгүй эсвэл усны хэмжээ бага байхад ажиллуулах, усны халуун тогоонд ус шахах, уурын тогооны даралт 4 кг/м^2 -аас хэтэртэл их хэмжээний даралт үүсэх үед, усыг асгах, ажиллагаагүй даралт хэмжигч, усны төвшин заагчгүй, хамгаалах хавхалгагүй ажиллуулах, шөнийн цагт гэрэлтүүлэггүй ажиллах, даралттай уурын тогоонд засвар үйлчилгээ хийх.

285.3. Тогоог ажиллуулах үед хянах эзэнгүй орхих, шатахуунаар галлах, галлагчаас бусад хүмүүс галлах амны урд талд зогсох, цэвэрлэгээг хялбар шатах зүйлээр хийх.

Юүлэн хуваарилах автостанц (АРС-14у)- тай ажиллах үеийн аюулгүй ажиллагаа

286. Газрын тосны бүтээгдэхүүн, утаат хэрэгсэл, тээвэрлэх, хадгалах, ашиглах

үед галын аюулгүй байдлыг хангах.

287. Юүлэн хуваарилах станцын битүүмжлэлийг урьдчилан шалгана.

288. Бодис, уусмал найруулах, цэвэрлэгээ, ариутгал, идэвхжил сулруулалт хийхдээ хүн нэг бүрийн хамгаалах хэрэгслийн бүрэн бүтэн байдлыг шалгаж, хэрэглэнэ.

289. Хамгаалах хувцсыг

289.1. 30 градусаас дээш үед 15-20 минут

289.2. 25-29 градуст 20-35 минут

289.3. 20-24 градуст 40-60 минут

289.4. 15-19 градуст 90-120 минут

289.5. 15 градусаас доош бол 180 минутаас дээш хугацаагаар хамгаалах хувцастай ажиллана.

290. Станцыг өвлийн улиралд ажиллуулахдаа алба хаагч хамгаалах хэрэгслийн дотуур дулаан хөвөнтэй болон даавуун хувцас өмсөнө.

291. Цацрагийн болон химийн хордолтын аюулгүй байдлын тунг хэмжиж, хяналтыг тогтмол явуулна.

292. Ажиллагааны дараа бүх шугамыг шавхана.

293. Ашигласан бодис, материал, хог хаягдлуудыг зориулалтын нүхэнд булж, шатааж устгана.

294. Үлдэгдэл бодис, материал, уусмалуудыг аюулгүй болгон саармагжуулж, зориулалтын газарт устгана.

295. Юүлэн хуваарилах автостанц (АРС-14у)-тай ажиллахад хориглох зүйлс.

295.1. Газрын тосны бүтээгдэхүүнийг тээвэрлэх, ашиглах үед суурин буюу гинжит газардуулгыг байнга хэрэглэж, газардуулга байхгүй тохиолдолд станцыг ашиглах.

295.2. Голомтын бүсэд аврах ажиллагааны удирдагчийн зөвшөөрөлгүй хамгаалах хувцсыг тайлах, тамхи татах, хүнсний зүйл идэж уух.

295.3. Голомтын бүсэд автомашины цонхыг нээх, станцын хавхалгыг хааж ажиллуулах.

295.4. Голомтын бүсэд ажиллаж байгаа бие бүрэлдэхүүн бүрэн цэвэрлэгээ хийлгэлгүй голомтын бүсээс гарах.

Ариутгалын автостанц (ДУК)-тай ажиллах үеийн аюулгүй ажиллагаа

296. Бодис уусмал найруулах, цэвэрлэгээ ариутгал, идэвхжил, сулруулалт хийх үед хүн нэг бүрийн хамгаалах тусгай хувцас, хамгаалах хэрэгслийг бүрэн хэрэглэнэ.

297. Усан хөөрөг ажиллах үед яндан болон агаарын хоолойд хүрч болохгүй.

298. Гар асаагчаар (татагч) асаахад үйлдвэрээс тогтоосон аюулгүй ажиллагааг хангана.

299. Засварын ажил хийхдээ осол, аюулаас урьдчилан сэргийлж цахилгааныг заавал салгаж, өндөр хүчдэлээс хол байх.

300. Ариутгалын автостанц (ДУК)-тай ажиллахад хориглох зүйлс.

300.1. Үйлдвэрээс тохируулсан тохиргоог дур мэдэн хөдөлгөх.

300.2. Усан хөөргөний ременийг хамгаалалтгүй ажиллах, ремений хүрдэнд оосорлогдох, салбагар болон томдсон хувцас хэрэгсэлтэй ажиллах.

300.3. Яндангийн ойролцоо хялбар асах зүйлийг байлгаж болохгүй.

300.4. Төхөөрөмж ажиллаж байгаа үед түлшний саванд түлш хийх, бүрэн

цэвэрлэгээ хийгдээгүй бол голомтын бүсээс гарах.

Нисгэгчгүй нисэх төхөөрөмжтэй ажиллах үеийн аюулгүй ажиллагааны зааварчилгаа.

301. Нисгэгчгүй нисэх төхөөрөмж /цаашид дрон гэх/ бүрэн бүтэн байдал, радио удирдлагын бүрэн бүтэн байдал, баттерейн цэнэг шалгана.

302. Дроныг зохих сургалтад хамрагдсан, заагдсан нислэгийн цагийг хангасан алба хаагч ажиллуулна.

303. Сэнсийг шалгаж, хөөргөх тохиромжтой газарт байрлуулсан эсэхийг нягтлан тохиргоог хийнэ.

304. Хүний хөдөлгөөнөөс хол байрлуулж антен, дохио орж ирж байгаа эсэх, камерын тогтворжуулагчийн ажиллагаа, камерт карт хийсэн эсэх зэргийг шалгаж саад болж болзошгүй зүйлсийг холдуулсны дараа нисгэнэ.

305. Дрон операторт эсвэл видео хяналтад харагдаж байх. Хяналтын камерын линз нь бодит байдлаар нь харуулдаг байх. (ойртуулах, "fisheye" эффект ороогүй байх).

306. Дрон заавал байнгын хяналт, жолоодогчтой байх. Зөвхөн өдрийн цагаар нисгэх. (Орон нутгийн албан ёсны нар мандах, нар жаргах цагаар)

307. Бусад дрон болон онгоцонд саад учруулахгүй байх.

308. Дээд хурд 161 км/цагаас хэтрэхгүй байх.

309. Газраас дээш 500м-ээс хэтрэхгүй байх.

310. Хамгийн багадаа газрын станцаас 5км зайд цаг агаар-ын хувьд харагдахуйц байх.

311. Нисгэгч олон дроныг зэрэг жолоодохгүй байх.

312. Анхаарал, болгоомжгүй, аз туршсан үйлдэл хийхгүй байх.

313. Дроныг нисгэхийн өмнө оператор заавал үзлэг хийх.

314. Нисгэгч бие махбод болон сэтгэл зүйн бэлтгэлгүй гэж үзсэн тохиолдолд дроныг нисгэхгүй байх.

315. Нисгэгч нь заавал аэронавтик болон дроны мэдлэгтэй дроны үнэмлэхтэй, дроныг жолоодох ур чадвартай хүн байна.

316. LiPo баттерей нь дараах зүйлүүдээс болж гэмтдэг. Үүнд хэт халаах, хэт цэнэглэх, хэт цэнэгээ алдах, хэт өндөр гүйдэлд цэнэглэх, богино холболт, гадаргууг нь гэмтээх, цохигдсон байдал орно. Гэмтсэн LiPo баттерей нь шатах аюултай.

317. Хэрвээ дроныг унагаасан бол задлах, боолтынх нь толгой алагдах, гимбалных нь моторын ороомгийг таслах, коннекторыг нь сугалах, гимбалаа задалж байгаад уянг гэмтээхгүй байх.

318. А зэрэглэлийн нисэх буудлын эргэн тойронд буюу 8-н км-н тойрогт нисгэх хориотой.

319. В зэрэглэлийн нисэх буудлын эргэн тойронд буюу 800-н м-н тойрогт нисгэх хориотой.

320. Төрийн тусгай хамгаалттай газруудад нисгэх хориотой.

321. Дроныг агаарын замд оруулах, зөвшөөрөлгүй долгион ашиглах, тусгай зөвшөөрөлтэй долгионыг хулгайгаар ашиглах үйлдэл гаргахгүй байх.

Холбоо, мэдээллийн технологийн техник хэрэгсэлтэй ажиллах үеийн аюулгүй ажиллагаа

322. Барилга, байгууламжийн дээвэр дээр антены байгууламжийн тулгуурыг 8 м-ээс өндөргүй босгож, тулгуурын бэхэлгээг 4-5 мм-ийн голчтой ган утсаар хийж дээврийн яс мод, хананд сайтар бэхэлнэ. Энэ ажлыг гүйцэтгэхэд 3-аас доошгүй хүний бүрэлдэхүүнтэй хамгаалах тусгай хувцас, хэрэгсэлтэй ажиллуулна.

323. Антены байгууламжийг аюулгүй ажиллагааны шаардлагыг бүрэн хангасан, зориулалтын цамхагт байрлуулан аянга зайлуулагч болон газардуулгыг хийж, орчиндоо аюулгүй байхаар ашиглана

324. Хээрийн нөхцөлд антеныг зориулалтын тулгуур дээр дэлгэх бөгөөд эдгээр нь байхгүй тохиолдолд 4 м-ээс доошгүй өндөртэй мод, багана, банз зэрэг материалыг ашиглан газардуулахгүйгээр байрлуулна.

325. Радио станц техник хэрэгсэлд 150 Ом-оос (цахилгаан эсэргүүцэл-ОМ) илүүгүй эсэргүүцэлтэй газардуулагчийг хэрэглэж, гал хамгаалагч нь техникийн норм, стандартын хэмжээ, маягтад тохирсон байна. Гал хамгаалагчийг зориулалтын бус хэрэгслээр орлуулахыг хориглоно

326. Радио нэвтрүүлэгч, хүлээн авагч, хуваарилах самбар, шулуутгагч, цэнэгийн агрегатыг байрлуулах шалан дээр резинэн дэвсгэр дэвсэнэ.

327. Цахилгаан сүлжээнээс тэжээгдэх радиостанц, хүлээн авагч, шулуутгагч зэрэг бусад хэрэгслийг үүр буюу сэрээгээр (холбогч) шугамд холбоно.

328. Радио станц, техник хэрэгслийг засварлах, техник үйлчилгээ хийхийн өмнө цахилгаа үүсгүүрээс салгаж, чийгтэй даавуу, болон бусад цэвэрлэгээний шингэн бодис хэрэглэхгүй байх. Урсгал засвараас бусад засварыг мэргэжлийн инженер, техникчид гүйцэтгэнэ.

329. Холбооны техник хэрэгслийн засварын ажлыг гүйцэтгэх хугацааны туршид уг хэрэгслийн залгуур дээр “залгаж болохгүй, хүмүүс ажиллаж байна” гэсэн санамж бичиг байрлуулна.

330. Цас, мөсөнд дарагдаж халтиргаа үүссэн, хүчтэй салхи, цасан болон шороон шуургатай үед барилга, байгууламжийн дээвэр дээр антен байрлуулах, түүний татуургыг байшингийн яндан, салхивчийн хоолой, хаалга, цонхны яс мод зэргээс бэхлэх.

331. Аянга, дуу цахилгаантай бороотой болон гадна ямар нэгэн хүчдэлийн үед радиостанц, дагалдах хэрэгсэлтэй ажиллах, шатсан гал хамгаалагч солих.

332. Радио станцаар 15 секундээс дээш хугацаанд тасралтгүй нэвтрүүлэг хийхийг хориглоно.

333. Радио станцыг антенгүйгээр нэвтрүүлэх хийхийг хориглоно. Ингэснээр радио станцын гаралтын транзистор шатах эрсдэлээс хамгаална

Автомашины суурин станцын аюулгүй ажиллагаа

334. Суурин станцыг автомашины зай хураагуурын холболтыг зөв холбох

335. Зөөврийн холбооны антеныг хөдөлгөөнгүй бэхлэх

336. Радио станц, холбооны техник хэрэгслийг асаалтай байхад автомашиныг асаахыг хориглоно

337. Холболтын цахилгаан гүйдэл дамжуулах утасны гадна бүрээсийг гэмтэл үүсэхээс хамгаалах

338. Автомашин унтраалттай үед радио станцаар удаан хугацаагаар ашиглахыг хориглоно.

Зай хураагуур ба цэнэгийн станцуудтай ажиллах үеийн аюулгүй ажиллагаа

339. Ажил эхлэхийн өмнө нэг бүрийн хамгаалах хувцас (резинэн гутал, бээлий, хормогч, нүдний шил) өмсөж, ажлын багаж хэрэгсэл болон туслах материалын бүрэн бүтэн байдлыг шалгаж хэрэглэх дэс дарааллаар тавина.

340. Цахилгаан хөдөлгүүр, хувиргагч, шулуутгагч ба цахилгаан багажуудын арьсны хамгаалах газардуулга байгаа эсэхийг шалгана.

341. Зайн хураагуурт үйлчилгээ, үзлэг хийхдээ зөвхөн 12-24 Вт-ын (энергийн шилжилтийн хурд Вт) хүчдэлтэй зөөврийн гэрлийг ашиглана.

342. Хээрийн нөхцөлд хүчил, шүлтэн зайн хураагуурыг цахилгааны эх үүсвэрт залгагдсан цэнэгийн станц, шулуутгагчаар цэнэглэнэ.

343. Ажлын дараа болон хооллохын өмнө гар нүүрээ савантай бүлээн усаар угааж, амаа сайтар зайлна.

344. Цахилгаан эд, ангитай ажиллахдаа цэнэглэх станцын тоноглолд засвар хийх, ил буюу далд байгаа тусгаарлагчгүй гүйдэл дамжуулагчид хүрэхийг хориглоно.

Цахилгаан хэрэгслийг ашиглах үеийн аюулгүй ажиллагаа

345. Цахилгаан хэрэгслийг дадлага, туршлагатай мэргэжлийн хүн ажиллуулна.

346. Цахилгаан хэрэгслийг хүчдэлтэй цахилгаан шугамд залгах, салгахдаа түүний унтраалгыг урьдчилан унтрааж, тусгаарлагч резинэн бээлийтэй ажиллана.

347. Цахилгаан гүйдэл тасрах, ажлын завсарлага, байр солих зэрэгт цахилгаан багаж хэрэгслийг сүлжээнээс заавал салгана.

348. Цахилгаан багаж хэрэгслээр ажиллахын өмнө дараах шалгалтыг хийнэ.

349. Цахилгаан багажийн зангилгаа, хийцийг бэхэлсэн эргэний чанга, сул

350. Цахилгаан багажийн дамжуулах эд, анги, түгжигч, салаалагчийн аюулгүй байдал.

351. Газардуулагч ба хамгаалан салгах байгууламж, цахилгаан багаж хэрэгслийн утас тусгаарлагчийн бүрэн бүтэн байдал.

352. Цахилгаан багаж хэрэгсэлтэй ажиллахад хориглох зүйлс.

352.1. Багажийн эргэх, зүсэх хэсгүүдэд хүрэх, хувцсаа орооцолдуулах, цахилгаан дамжуулах утаснаас барих.

352.2. Шугамнаас салгалгүйгээр буюу салгасан ч бүрэн зогсоогүй байхад нь засвар үйлчилгээ хийх.

352.3. Задалж засварлах, хэт ачаалал өгөх, халаах, ажиллах үед огцом хөдөлгөх, эзэнгүй орхих, бусдад дамжуулах.

352.4. Цахилгаан багаж хэрэгслийг дараах тохиолдлуудад цахилгаан сүлжээнээс яаралтай салгана.

352.5. Цахилгаан хөдөлгүүрийн эд анги эвдрэх, утаа, гал гарах.

352.6. Цахилгаан багаж хэрэгсэл хурдан халж, эргэлтийн хурд огцом буурах.

Нарны зайн системийг ашиглахад анхаарах, аюулгүй ажиллагааг хангах

353. Нарны зайн системийг ашиглалтын зааврыг сайтар уншиж танилцсаны дараа ашиглана.

354. Системийг норгох, шингэн зүйл асгах, чийг цохиулахаас сэргийлнэ.
355. Гадна орчны агаар +40 градусаас өндөр болсон тохиолдолд хувьсах гүйдлийн 220В-н хэрэглээг зогсоох шаардлагатай.
356. Нарны зайн төхөөрөмж нь 12В цахилгаан хэрэглээг хангахад зориулагдсан.
357. Хувиргагч (инвертер) ашиглан 220В цахилгаан хэрэглээнд 300Вт чадлаас хэтрүүлж болохгүй
358. Нарны зайн цэнэг хураагуурыг ил гал, хэт халах төхөөрөмжөөс хол байрлуул.
359. Холболт хийхдээ зааврын дагуу хийнэ.
360. Цахилгаан үүсгүүрийг холбосны дараа нарны дэлгэцийг холбоно.
361. Системийн удирдлагын самбар дээрх цэнэг хураагуурын төлөв байдал болон нарны дэлгэцийн цэнэгийн хэмжээг тогтмол шалгах.
362. Нэмэх, хасах туйлыг буруу холбохоос зайлсхий.
363. Нарны дэлгэцийн холболт гүйцэд түгжигдэж холбогдсон эсэхийг шалгах.
364. Хэрэв сул холболт хийсэн нөхцөлд тухайн хэсэгт халалт үүсэж залгуурын хэсэг хайлах, цаашлаад гал гарах аюултай.
365. Нарны зайн цэнэг хураагуурын цэнэгийг бүрэн дуусгаж болохгүй.
366. Нарны зайн дэлгэцийн тоос шороог тогтмол цэвэрлэх.
367. Нарны зайн дэлгэцийг хаглаж гэмтээхээс сэргийлэх.
368. Нарны зайн дэлгэцийн өвөл зуны тохируулгыг улирлын байдлаас хамаарч тогтмол хийх.
369. Дараах зүйлийг хориглоно
- 369.1. Төхөөрөмж дээр хэт хүнд зүйл тавих.
- 369.2. Цэнэг хураагуурыг нарны цахилгаан үүсгүүрээс өөр төрлийн цахилгаан үүсгүүрт холбох.
- 369.3. Системийг газардуулаагүй үед хувьсах гүйдлийн 220 В-ийн залгуурыг задалж засварлах.
- 369.4. Тогтмол гүйдлийн хэлхээний хэсэгт цахилгааны холболтын утсыг уртасгаж залгах.
- 369.5. Системд автомашины цэнэг хураагуур ашиглах.
- 369.6. Цэнэг хураагуурт хэмжээнээс хэтэрсэн ачаалал өгөх, нарны зайн дэлгэцээс салгасан байдалд хэт олон цагийн хэрэглээ хийх.
- 369.7. Их нартай өдрүүдэд цэнэг хураагуурт ачаалал өгөхгүйгээр удаан хугацаагаар залгаатай байлгах.
- 369.8. Нарны зайн системд зориулагдсан цэнэг хураагуурыг автомашинд ашиглах.

Гал түймэр унтраах, аврах багаж хэрэгслийг ажиллуулах.

370. Тусгай зориулалтын багаж, хэрэгслийг зориулалт, ажиллуулах зарчмыг сайтар эзэмшсэн албан хаагч ажиллуулна.
371. Алба хаагч нь багаж, хэрэгсэл ажиллуулахдаа хамгаалах тусгай хувцсыг иж бүрэн өмссөн байна.
372. Бага оврын хөдөлгүүр, багаж, хэрэгслийг ашиглахын өмнө үзлэг хийж, хөдөлгүүрийг зүгшрүүлэхдээ бага эргэлтээр шалгаж ажилд бэлтгэнэ.

373. Бага оврын хөдөлгүүрийн багаж, хэрэгслийг ажиллуулах үед түлшний савыг таглаатай байлгаж, засвар үйлчилгээ хийхдээ шатахууны үлдэгдлийг заавал юүлж авна.

Аврах багаж хэрэгсэлтэй ажиллах үеийн аюулгүй ажиллагаа

374. Аврах ажиллагааны тоног төхөөрөмж, багаж хэрэгслийг ашиглалтын зааврын дагуу ажиллуулна.

375. Тусгай зориулалтын багаж, хэрэгслийг зориулалт, зохион байгуулалт, ажиллуулах зарчмыг сайтар эзэмшсэн албан хаагч ажиллуулна.

376. Алба хаагч нь багаж хэрэгсэл ажиллуулахдаа хамгаалах тусгай хувцсыг иж бүрэн хувцас өмссөн байна.

377. Багаж хэрэгслүүдийн тоноглолуудын хэвийн ажиллагааг шалгаж байх.

378. Тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн хэвийн ажиллагаа алдагдах, ашиглалт, аюулгүй ажиллагааны дүрэм, заавар зөрчигдөж болзошгүй болон зөрчигдсэн тохиолдолд захирагч, дарга нарт мэдэгдэж арга хэмжээ авхуулна.

379. Бага оврын хөдөлгүүрийн багаж, хэрэгслийг ажиллуулах үед түлшний савыг байнга таглаатай байлгаж, засвар үйлчилгээ хийхдээ шатахууны үлдэгдлийг заавал юүлж авна.

380. Бага оврын хөдөлгүүрийн багаж, хэрэгслийг ашиглах үед угаарын хий хуримтлагдах газар ажиллуулж болохгүй.

381. Шатахуун хийхээс өмнө хөдөлгүүрийг унтраасан байна.

382. Шатахуун асгарахаас сэргийлэн шатахууныг хийж, шатахууны савнаас агаар гарах зай үйлдээх хэрэгтэй.

383. Зөвхөн зориулалтын саванд шатахууныг нөөцөлнө.

384. Хөдөлгүүрээс шатахуун уурших, шүүрч байгаа тохиолдолд хөдөлгүүрийг асаах, ажиллуулахыг хориглоно.

385. Угаарын хийнд хордохоос сэргийлж ажиллаж байгаа хөдөлгүүрийн яндангийн ард зогсож болохгүй.

Гар ажиллагаатай багаж хэрэгсэл ашиглах үеийн аюулгүй ажиллагаа

386. Гар ажиллагаатай багаж хэрэгслийг зориулалтын дагуу ашиглана.

387. Тусгаарлагч бариултай багаж хэрэгсэл ашиглахдаа зориулалтын бус хэсгээс барихыг хориглоно.

388. Үйлдвэрлэлийн зааврын дагуу багаж хэрэгслийг ажиллуулна.

389. Алх, сүх, хүрз зэрэг гар ажиллагаатай багажийн модон бариул сул, цуурсан, хагарсан, гэмтэлтэй багажийг ашиглахгүй.

390. Төмөр эсвэл ган гар багаж нь шатамхай бодисын эргэн тойрон дах галын эх үүсвэр, шатамхай хий, өндөр хэлбэлзэлтэй шингэн болон бусад тэсэрч дэлбэрэх бодисыг хадгалж, ашиглаж байгаа тохиолдолд резин материалаар хийсэн багаж хэрэгслийг ашиглана.

391. Төмөр утас, бусад хэлбэрийн төмөр бэлдцүүдийн төгсгөлүүд нь бэхлэгдээгүй үед дараах аюулгүй ажиллагааны арга хэмжээг зайлшгүй авах шаардлагатай.

392. Төмөр тасалж байгаа бүсэд гаднын хүн байлгахыг хориглоно. Аюулгүйн бүсийг тогтоохдоо тасарсан төмөр утас ойж, үсрэн хүмүүсийг гэмтээж болохыг тооцоолох хэрэгтэй.

393. Богино хэмжээтэй төмрийг тастах үед (төмөр буюу түүний хайчлагдсан богино хэсэг) шуудай, брезент болон бусад материалаар бүтээсэн байх ёстой.

394. Нүд хамгаалах хэрэгсэл, хамгаалах тусгай хувцас, гар хамгаалах хэрэгсэл /бээлий/ өмсгөлгүй ажиллуулахыг хориглоно

395. Хайчийг ажиллуулахын өмнө хөшүүргүүдийн бэхэлгээ, хайчны ир бүтэн эсэхийг заавал шалгах хэрэгтэй.

396. Ир нь мөхсөн болон хэрчих ирмэг нь гэмтсэн, бусад төрлийн гэмтэлтэй багажаар ажиллахыг хориглоно.

397. Аврагч нь хайчилж байгаа төмөртэй нэг шугамд байрлаж болохгүй

Автомат хийн шахуурга, цахилгаан хэрэгсэл ашиглах үеийн аюулгүй ажиллагаа

398. Цахилгаан гар багажийг -35°C -аас $+35^{\circ}\text{C}$ хүртэл градуст болон $+20^{\circ}\text{C}$ -д харьцангуй чийгшил 90 хувьтай үед ашиглана. Металл болон тусгаарлагчийг сүйтгэгч химийн идэвхтэй орчинд буюу тэсэрч дэлбэрэх аюултай байранд, түүнчлэн цас, бороо орж байх үед ил задгай талбайд цахилгаан гар багаж хэрэглэн ажил гүйцэтгэхийг хориглоно.

399. Ажиллуулахын өмнөх шалгалт:

399.1. Дискний ил байгаа хэсэг нь 150° -аас илүүгүй байна

399.2. Даралтат агаарын аюулаас болгоомжил

399.3. Хоолойн холбоснуудыг шалгах

399.4. Таслагч ирийг шалгах

399.5. Цав гарсан эсэхийг шалгах

399.6. Цахилгааны дамжуулагч утсыг шалгах

399.7. Залгуурын холболт шалгах

399.8. Утас буюу хамгаалалтын хоолойг

400. Дараах эвдрэлүүд үүссэн тохиолдолд цахилгаан гар багажуудыг ашиглахыг хориглоно

400.1. Дамжуулах механизм эвдрэх, залгуур муу ажиллаж байвал

400.2. Редуктораас тос гоожвол

400.3. Тусгаарлагчаас шатаж байгаа үнэр буюу утаа гарч байвал

400.4. Цахилгаан багаж, хэрэгсэл хурдан халж, эргэлтийн хурд огцом буурах

400.5. Их биеийн эвдрэл, ан цав үүссэн болно

401. Хориглох зүйлүүд:

401.1. Даралт өгсөн гидро ажиллагаатай багажийг цохих

401.2. Хүснэгтэд зааснаас илүү ачаалал өгч ажиллуулах

401.3. Хэвийн бус ажиллагаатай гидро ажиллагаатай багажийг ашиглах

401.4. Гидро ажиллагаатай гар багажийг ажиллуулж байх үед эргэн холбоосыг салгах, залгах, нугалах

401.5. Гидро ажиллагаатай гар багажийг сургалтад хамрагдаагүй хүмүүст өгч ажиллуулах

401.6. Гагнуурын болон бусад цахилгаан утсан дээр гишгэх.

Цуравдагч

402. Цуравдагчийг ажиллагаанд салаа, бүлгийн даргын зөвшөөрөл, зааврын дагуу ашиглах бөгөөд, туршлагатай алба хаагчийг томилон ажиллуулна.

403. Цуравдагчийг ажиллагаанд хэрэглэх үед цэнэглэх бөгөөд гал түймрийн захаас 20-30 метрийн зайд цэнэглэнэ. Бусад үед хушууг хураан түлшгүйгээр тээвэрлэх болон хадгална.

404. Ажиллагааны үед сэгсрэх, хэт өндөр буюу өвдөгнөөс дээш барих, бамбарын хэсгийн галыг унтраалгүй цэнэглэх, салхины чиглэлийг тооцоололгүй ажиллахыг хориглоно.

405. Цуравдагчаар ажиллах үедээ түлшний савны тагийг сайтар хаасан байна.

406. Түлшний савны гадуур асгарсан түлшийг ажиллуулахаас өмнө арчиж цэвэрлэсэн байна.

407. Ажиллагааны үед цуравдагчийг туршлагатай хоёр алба хаагч ажиллуулна.

Үүргийн гал унтраагуур (РЛО)

408. Гадна талын их бие, шахуурга, хоолой, хушууны бүрэн бүтэн байдлыг шалгана.

409. Үүргийн гал унтраагуур (РЛО) нь мөрөвч болон их биен дээрээ гэрэл ойлгогчтой байна.

410. Үүргийн гал унтраагуураар гал түймэр унтраах бодисоос өөр төрлийн шингэн зөөвөрлөхийг хориглоно.

Цохиур, троссон шүүр

411. Ой, хээрийн гал түймэр унтраах гар багаж хэрэгслүүд нь дулааны болон механик үйлчлэлд тэсвэртэй байх ба троссон шүүр, цохиурын бариул нь дулаан тусгаарлагчтай байна.

412. Цохиур болон троссон шүүрийн иш нь угсардаг байж болно.

Цахилгаан /мотор/ хөрөө

413. Цахилгаан хөрөөгөөр ургаа, тулгуур модыг унагаахдаа голчийн 1/4-тэй тэнцэх хэсгийг хөрөөдөж түүний эсрэг талаас 2-4 см-ийн өндөрт хөрөөдөх бөгөөд мод унаж эхэлмэгц алба хаагч нь анхааруулга өгнө.

414. Шатаж байгаа ургаа болон унанги, барилгын хийц бүтээцэд ашигласан мод хөрөөдөхдөө хөдөлгүүрийг унтраалгүйгээр хөрөөний байрлал солихыг хориглоно.

415. Түймрийн үед салхины хурд 6 м/с -ээс их, 20-оос дээш хэмийн налуу газар мод унагаах ажил хийхийг хориглоно.

416. Тусгай зориулалтын тоног төхөөрөмж багаж хэрэгслийг туршин шалгах хугацааг “Гал түймэр унтраах автомашин, техникийн тусгай тоноглол, тоног төхөөрөмж, багаж хэрэгслийг туршин шалгах, үйлчилгээ хийх заавар”-ын дагуу гүйцэтгэнэ.

417. Цахилгаан гүйдлээс хамгаалах хэрэгсэлд дараах зүйл хамаарна. Үүнд:

417.1. Резин хамгаалалттай бээлий

417.2. Резин гутал

417.3. Хөндийрүүлэгч гадаргуу бүхий 50х50 см-ийн хэмжээтэй резин дэвсгэр

418. Цахилгаан гүйдлээс хамгаалах хэрэгслийг автомашинд тусгай зориулалтын хайрцагт хадгалж, зориулалтын бус зүйлд ашиглахыг хориглоно.

419. Багаж хэрэгсэл, гэрэлтүүлгийн төхөөрөмжийн цахилгаан гүйдэл дамжуулагч утас нь ус, хөөс нэвтрэхгүй зөөлөн утас байх бөгөөд багаж хэрэгсэл, төхөөрөмжид газардуулга хийсэн байна.

Гар ажиллагаатай шат

420. Гурав сунадаг шатыг барилгын хананд байрлуулахдаа:

420.1. Барилгын хананаас 1.5-2 метрийн зайтай 80-83 градусын налуу өнцөгтэй сунгана.

420.2. Шатыг огцом бус алгуур татаж олсыг орооцолдуулахгүйгээр сунгана.

420.3. Сунгаж буй шатны гадна талын гуянаас эрхий хуруугаар ороохгүйгээр барина.

420.4. Шатыг сунгах үед хоёр тийш нь хазайлгахгүйгээр хөдөлгөөнгүй байрлуулна.

421. Гурав сунадаг шатаар дараах нөхцөл бүрдсэн тохиолдолд өгсөж, буухыг зөвшөөрнө. Үүнд:

421.1.1. Шатыг сунгасны дараа цоожлогч хөндөл дээр найдвартай түгжигдсэн байна.

421.1.2. Барилга байгууламжийн хананд налуулж байрлуулсан шатны гадна талын гуянаас барина.

421.1.3. Араатай болон гурав сунадаг шатаар сургуулийн цамхаг дээр бэлтгэл сургуулилт хийхийн өмнө цамхгийн нүүр талын зөөлөвч, хамгаалах хэрэгслийн аюулгүй байдлыг шалгаж, давхар бүрд байх хамгаалалтын хүмүүст зааварчилгаа өгнө. Шатаар өгсөх, буух хушуутай буюу гар багаж хэрэгсэлтэй ажиллах үед шатны хамгаалалтын хүнийг байнга байлгахгаас гадна карабинаар шатнаас бэхэлнэ.

422. Гар ажиллагаатай шатыг үйлдвэрээс гаргасан аюулгүй ажиллагааны зааврын дагуу ашиглана.

423. Гар ажиллагаатай шатны хөндлүүдийн бэхэлгээнүүд сул, хөдөлгөөнтэй байвал ашиглахыг хориглоно.

Мотопомптой ажиллах үеийн аюулгүй ажиллагаа

424. Мотопомпыг ажиллуулахыг өмнө техникийн аюулгүй байдалд үзлэг шалгалт хийнэ.

425. Засвар үйлчилгээг хөдөлгүүрийг ажиллаагүй үед хийнэ.

426. Мотопомпыг хялбар шатдаг материалын ойролцоо угсрах, засвар үйлчилгээ хийх, хөдөлгүүрийг асаахдаа оосрыг гартаа ороож барихыг хориглоно.

Цахилгаан үүсгүүрийг ажиллуулах үеийн аюулгүй ажиллагаа

427. Цахилгаан үүсгүүрийг ажиллуулахын өмнө түлшний сав, дамжуулах хоолой, цахилгаан утас, холбоосны бүрэн бүтэн байдлыг шалгана.

428. Цахилгаан үүсгүүрийг ажиллуулахын өмнө заавал газардуулга хийнэ.

429. Хөдөлгүүр хэт халсан үед радиоторын тагийг онгойлгох шаардлага гарвал хамгаалалтын бээлийтэй ажиллана.

430. Цахилгаан үүсгүүртэй ажиллах үед хориглох зүйлүүд:

430.1. Цахилгаан үүсгүүр ажиллаж байхад засвар, тохируулга, цэвэрлэгээ хийх, яндангийн орчим хялбар шатах зүйл байлгах

430.2. Жижиг оврын түлшний болон том оврын шатахуунаар ажилладаг цахилгаан үүсгүүрүүдийн хөдөлгүүрийг халааж, гэсгээхэд галт бамбар ашиглахыг хориглоно.

Өндөр даралтын хий шахагч

431. Өндөр даралтын хий шахагчийн тосолгоонд зөвхөн зориулалтын тос хэрэглэнэ.

432. Ажил эхлэхийн өмнө хийн хоолойнуудын холбоос, цэвэрлэгээг нарийвчлан шалгаж, багажийг ажилд бэлэн болгосны дараа хийн хаалтыг нээнэ.

433. Хийн хоолойг цэвэрлэхдээ үзүүрээс нь барьж эгц дээш чиглүүлэн шахсан хийгээр үлээлгэнэ.

434. Өндөр даралтын хий шахагчаар ажиллах үед эвдрэл гэмтэл тохиолдвол хий хуваарилагчийн хаалтыг хаана.

435. Өндөр даралтын хий шахагчийг ажиллуулахад хориглох зүйлүүд:

435.1. Бүрэн бус багажаар ажиллах, шахсан хийн даралт багажид ирж байгаа үед эвдрэлийг засах, өрөмдөх, бутлах алхыг сул ажиллуулах.

435.2. Ажиллагсад нь бээлий, нүдний шилгүй ажиллах, багажийг авч явахдаа хоолой, багажийн ирнээс барих.

435.3. Өндөр даралтын хий шахагчийг битүү байранд ажиллуулж, хий шахагчийн шүүр болон шахсан агаартай харьцдаг хийцүүдийг шатах, тослох материалаар цэвэрлэх.

435.4. Ажиллаж байгаа өндөр даралтын хий шахагчийн станцын ойролцоо гал гаргах, тамхи татах, шатахуун хадгалах.

ТАВДУГААР БҮЛЭГ

ГАЛ ТҮЙМЭР УНТРААХ, ЭРЭН ХАЙХ, АВРАХ АЖИЛЛАГААНЫ ҮЕИЙН АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ЗААВАР

Улсын хяналт шалгалт хийх үед тавигдах аюулгүй ажиллагаа

436. Гамшгаас хамгаалах, Гал түймрийн улсын хяналтын байцаагч, объектын гэрээгээр бие бүрэлдэхүүн объектын захиргаанаас тогтоосон аюулгүй ажиллагааны дүрмийг мөрдлөг болгон хяналт шалгалтыг зохион байгуулна.

437. Газрын тосны бүтээгдэхүүн, инженерийн шугам сүлжээ, цацраг химийн бодис материал хадгалах, борлуулах байгууламжид хяналт шалгалтыг явуулахдаа хамгаалах хэрэгслийг хэрэглэнэ.

438. Гал түймрийн улсын хяналтын байцаагч, эрх бүхий албан тушаалтан нь гал түймрийн хэргийн газарт үзлэг хийх, шалтгаан нөхцөлийг тогтоохоор шинжээчээр ажиллах үедээ хамгаалах тусгай хувцас, хамгаалах хэрэгслийг бүрэн өмссөн байна.

439. Мөн хөдөлмөрийн аюулгүй байдал хангуулахыг тухайн байгууллагаас шаардах эрхтэй.

440. Гал түймрийн улсын хяналтын байцаагч, эрх бүхий албан тушаалтан барилга байгууламжийн зураг төслийн явцын болон төлөвлөгөөт бус хяналт, шалгалтыг явуулахдаа толгой хамгаалах хэрэгслийг хэрэглэнэ.

Гал түймэр унтраах үеийн аюулгүй ажиллагаа

441. Гал түймэр унтраах тархалт хийх үед дараах зүйлийг хориглоно.

441.1. Объектын гал түймэр унтраах ажиллагаанд зориулсан хамгаалах тусгай хувцас, хэрэгсэлийг гал унтраах удирдагчийн зөвшөөрөлгүй тайлах.

441.2. Гүний худагт ил галаар гэрэлтүүлэх, амьсгалын бие даасан төхөөрөмж хэрэглэхгүй, аврах олсоор хамгаалалт хийлгүй худаг руу орох.

441.3. Гал унтраах даралтын хоолойд залгасан хушууг биедээ бэхэлж барилгын өндөр өөд өгсөх, ажиллах.

441.4. Өндөрт гаргаж, буулгаж байгаа гал унтраах багаж хэрэгсэл, бусад хэрэгсэл доор зогсох.

441.5. Хурц үзүүр, иртэй гал унтраах багаж хэрэгслийн ир, үзүүрийг хөдөлгөөний чигт харуулан авч явах.

441.6. Барилгын өндөрт гал унтраах даралтын хоолой, хушууг бэхлээгүй, хушуучин гал сөнөөгч ажлын байраа эзлээгүй үед гал унтраах бодис өгөх.

441.7. Автомеханик шат, болон бусад төрлийн шат, өргөгч дээр ажиллах үед аюулгүй ажиллагааг бүрэн хангаагүй үед гал унтраах бодис өгөх.

442. Хүний амьсгалын зам, арьсыг гэмтээх аюултай хордуулагч хий, шингэлгийн уур бүхий орчинд ажиллахдаа битүүмжлэгдсэн тусгай хувцас, амьсгалын бие даасан төхөөрөмж хэрэглэж ажиллана.

443. Хордуулагч хий, уурын хуримтлалыг багасгах зорилгоор байр тасалгаанд цацруулагч хушуугаар ус гаргаж агаарыг саармагжуулна.

444. Үлэмж хэмжээний дулаан ялгаруулан ил задгай талбайд шатаж буй гал түймрийг унтраахад дулаан эсэргүүцэх (мөнгөлөг) хувцас хэрэглэнэ.

445. Гал түймэр унтраах явцад болон түүний хор уршгийг арилгахаар ажиллаж буй бие бүрэлдэхүүн нь тухайн цагийн байдалд зөв үнэлгээ өгч барилгын хийц бүтээц, үйлдвэрлэлийн технологийн тоног, төхөөрөмжийг ашиглахад аюул учрахаар бол гал түймэр унтраах удирдагч болон тухайн хэсэгт ажиллаж байгаа бүрэлдэхүүнд нэн даруй мэдэгдэнэ.

446. Тэсрэлт, нуралт, буцлалт, дэврэлт үүсэж аюул учруулах нөхцөл үүсэн үед аюултай бүсээс нэн даруй гарах.

447. Тэсрэх, дэлбэрэх, хольц үүсэж болох даралтаар ажилладаг төхөөрөмж, хэрэгсэл, дамжуулах хоолойн шугамаас гарч байгаа шатамхай хий, уурын гал түймрийг унтраах тохиолдолд объектын захиргаанд мэдэгдэж шатамхай хий, уурын хаалтыг хаах, аюулгүй байдлын арга хэмжээ авхуулах, тоног төхөөрөмж, барилгын хийц бүтээцийг хөргөх ажлыг зохион байгуулна.

448. Гал түймэр унтраах явцад автомеханик шат болон гар ажиллагаатай шатны байрлалыг өөрчлөх тохиолдолд уг шатаар гарсан алба хаагчид урьдчилан мэдэгдэж аюулгүй байдлаа хангасны дараа шинэ байрлалаа зааж өгнө.

449. Барилгын хийц бүтээцэд задаргаа хийхийн өмнө ажиллах орчны цахилгаан гүйдлийг заавал салгана.

450. Барилга, байгууламжийн босоо хийц бүтээцийг задлахдаа тэдгээрийг унахаас болгоомжилж бэхэлгээ, тулгуурыг гэмтээж болохгүй. Хэрэв ийм хийц бүтээцийг унагаах, нураах шаардлага гарвал машин техник, бие бүрэлдэхүүнийг аюулгүй газар байрлуулсны дараа энэ ажлыг гал түймэр унтраах удирдагч хариуцан зохион байгуулна.

451. Барилгын давхар, дээвэр дээрээс хийц бүтээц, бусад зүйлийг хаях, буулгахын өмнө доор байгаа хүмүүст анхааруулах, хашлага хийх, хамгаалалт тавих арга хэмжээ авсан байна.

452. Задаргаа хийсэн барилгын хийц бүтээц, аварч гаргасан тоног төхөөрөмж, эд материалыг гал түймэр унтраах ажиллагаанд саад болохгүй хэсэгт, барилгын хучилтын даацыг харгалзан хураана.

453. Цахилгаан хэрэгсэл, гэрэлтүүлэгч ажиллуулахдаа дараах зүйлийг анхаарна.

454. Цахилгаан хэрэгсэл, багажийг резин бээлийтэй зөөвөрлөх, ажиллуулах, нүдний хамгаалалт шилтэй байна.

455. Гэрэлтүүлэгч болон гэрэлтүүлэх хэрэгслийг ус, хөөс хүрэхээргүй, чийгтэй орчноос хамгаалсан бүрхүүлтэй, тогтвортой суурин дээр байрлуулна.

456. Томилгоот ээлжид цахилгаан хэрэгслийг хүлээн авсан алба хаагч хариуцаж ажиллуулна.

457. Цахилгаан хэрэгслийг гүйдлээс салгахгүйгээр өөр газар зөөх, гэмтэж эвдэрсэн хэрэгслийг ажиллуулахыг хориглоно.

458. Гал түймрийн голомтод ажиллаж байгаа хушуучин гал сөнөөгч, барилгын хийц бүтээцэд задаргаа хийх газар, гал унтраах даралтын хоолой дэлгэх, шат тавих талбайн орчимд цахилгаан гүйдэл бүхий тасархай буюу ил задгай голчтой шугамын утас байгаа эсэхийг нарийн шалгаж тухай бүр гал түймэр унтраах удирдагчид илтгэнэ.

459. Цахилгаан шугамын утас нь гүйдэлтэй эсэхийг тогтоогоогүй бол гүйдэлтэйд тооцож аюулгүй болгох арга хэмжээг авна.

460. 220 вольтоос ихгүй хүчдэлтэй цахилгааны утсыг тэжээлээс зайлшгүй салгах шаардлага гарвал резин гутал, бээлий бүхий дадлага туршлагатай аврагч, гал сөнөөгч, салааны захирагчийн хяналтын дор тусгай зориулалтын хайчаар тасална.

461. Цахилгаан гүйдэл бүхий шугамын утсыг таслахдаа дараах журмыг баримтална.

462. Шугамын утсыг огтлохдоо тухайн барилга, барилгын давхар буюу хэсгийн цахилгаан гүйдлийн тэжээлийг тасалсан байхаар тооцох.

463. Цахилгаан гүйдлийн тэжээлийн шугамын утсыг таслахдаа хэрэглэгчийн талын тусгаарлагчийн ойролцоо доод талын шугамаас эхлэн таслах.

464. Шугамын утсыг нэг нэгээр нь огтлох буюу эрчлээг арилган нэг нэгээр нь таслах, олон салаа утас болон кабель утас түүнчлэн тусгаарлагч хоолой дотор байгаа цахилгаан гүйдлийн шугамын утсыг огтолж таслахыг хориглоно.

465. Хөөс үүсгэгч болон ус гарган ажиллаж буй бие бүрэлдэхүүн нь биеийн арьс ялангуяа нүдээ хамгаалах хэрэгтэй. Хэрэв биеийн арьс, нүд нь хөөс болон уусмалд өртвөл бүлээн усаар сайтар угаана.

466. Гал түймэр унтраах явцад гал унтраах автомашины жолооч нарт дараах зүйлийг хориглоно.

466.1. Гал түймэр унтраах удирдагчийн тушаал шийдвэргүйгээр ус, хөөс гаргах, даралт өгөх, зогсоох, гал унтраах багаж хэрэгслийн хураах, гал унтраах автомашиныг шилжүүлэн байрлуулах, автомашиныг унтраахыг хориглоно.

466.2. Гал унтраах автомашин, мотопомп, хөөрөг, багаж, хэрэгслийг эзэнгүй орхих.

467. Гал түймэр унтраах явцад ажиллаж байгаа автомашин техникийн хянах, хэмжих хэрэгсэлд гэмтэл үүсэх, ажиллагаагүй болсон тохиолдолд гал түймэр унтраах удирдагчид мэдэгдэх.

468. Шөнийн цагт гал унтраах тусгай зориулалтын автомашин техникийг ажиллуулахдаа хөөрөг хянах, хэмжих хэрэгслийн гэрэлтүүлэг асаалттай байна.

469. Гал унтраах автомашины хөөрөг, мотопомп, цахилгаан үүсгэгч, гал түймэр унтраах бусад төхөөрөмж, автомеханик шат зэргийн ажиллагааг хянах, хэмжих хэрэгсэлгүйгээр буюу тэдгээр нь эвдэрч гэмтсэн тохиолдолд ашиглахыг хориглоно.

470. Нүүрсхүчлийн хийн төрлийн гал унтраагуулын цацруулагч хушууг бээлий хамгаалалтгүй гараар барьж болохгүй.

471. Цахилгаанаар ажилладаг (36 вольтоос илүү) тоног төхөөрөмжийн болон устай үйлчилснээс урвалд орох, түүнчлэн буцлах, хөөрч цацагдах, тэсрэх, шаталт хүчтэй явагдах бодис материалд гарсан гал түймрийг унтраахад хөөс үүсгэх гал унтраагуулыг хэрэглэхийг хориглоно.

472. Гал түймэр унтраах удирдагч нь гал түймрийн нөхцөл байдал хүндэрч хүний амь нас эрсдэх, их хэмжээний хохирол учруулж болзошгүй үед энэ дүрмийн заалтыг зөрчсөн шийдвэр гаргах эрхтэй.

473. Объектын гал түймэр унтраах ажиллагаанд зориулсан хамгаалах тусгай хувцас, хэрэгсэлгүй нэмэлт дуудлагаар хүрэлцэн ирсэн бие бүрэлдэхүүнээр гал түймрийн голомтод үүрэг гүйцэтгүүлэхийг хориглоно.

474. Барилгын дээврийн хөндийд гарсан гал түймрийг унтраах үед дээврийн дам нурууг дамжих, галд шатаж буй нурсан хэсэгт орохыг хориглоно.

475. Барилгын өндөрт хоёроос доошгүй гал сөнөөгч нэг хушуутай ажиллах бөгөөд ус тавьж дууссан үед ч хушууг эзэнгүй орхихыг хориглоно.

476. Гал түймэр унтраах, аврах, хайгуул хийх.

477. Гал түймрийн голомтод хайгуулын үүргийг хоёроос доошгүй хүний бүрэлдэхүүнтэйгээр тасгийн дарга, туршлагатай алба хаагчаар ахлуулан зохион байгуулна.

478. Хүндрэлтэй нөхцөлд гал түймрийн хайгуулын үүргийг гал түймэр унтраах удирдагч буюу салааны захирагч, туслах ахлан гурваас доошгүй хүний бүрэлдэхүүнтэйгээр зохион байгуулна.

479. Хэд хэдэн чиглэлд гал түймэр унтраах хайгуулын үүргийг зохион байгуулж болно.

480. Хайгуулын хэсгийн бие бүрэлдэхүүн нь гал түймэр гарсан объектын онцлог, шатлагийн нөхцөл байдал, утаажилтыг харгалзахгүйгээр дараах багаж хэрэгслээр хангагдсан байна. Үүнд:

480.1. Амьсгалын бие даасан төхөөрөмж

480.2. Гэрэл, холбооны хэрэгсэл

480.3. Бусдыг болон өөрийгөө хамгаалах хэрэгсэл

480.4. Барилгын хийц бүтээцийг задлах багаж хэрэгсэл

480.5. Даралттай хоолойд холбосон гал унтраах усны эсвэл хөөсний хушуу

481. Хайгуул хийхдээ дараах журмыг баримталж ажиллана Үүнд:

481.1. Орчны нөхцөл байдалд үнэлгээ өгч, явах замаа судлан ажиглаж бие бүрэлдэхүүн цуваагаар явна.

481.2. Цахилгаан, инженерийн байгууламж, шугам сүлжээ, өндөр даралтаар ажилладаг төхөөрөмж, тэсрэх, дэлбэрэх, хордуулагч, цацраг идэвхтэй бодис, материал хадгалах, ашигладаг байр, тасалгаанд мэргэжлийн байгууллагаас зааварчилгаа авч аюулгүй байдлыг хангаж ажиллана.

481.3. Галын дөл, утаа хийн тэсрэлт, дэлбэрэлтэд барилгын хийц бүтээцийн нуралтаас сэргийлж аюулгүй байдлаа ханган хаалга, салхивчийг болгоомжтой нээх, хаах.

481.4. Объектын хийц бүтээцэд үнэлгээ өгч, галын тархалтын чиглэл, голомтыг тогтоож, гал түймэр унтраах удирдагчид илтгэх.

481.5. Гал түймрийн аюулаас хүн аврах үед аюулгүй ажиллагааг хангаж утаажилтын байдлыг харгалзахгүйгээр аврах замаар гарч буй хүмүүсийг хайгуулын хэсгийн алба хаагч заавал дагалдана.

482. Гурав ба түүнээс дээш давхраас гадна талын шатаар хүн буулгахдаа аврах олсоор хамгаална.

483. Барилгаас аврах олсоор хүн аварч буулгах ажлыг түүнээс өөр хэлбэрийн авралтын арга хэрэглэх боломжгүй нөхцөлд хэрэглэнэ.

484. Өөрийгөө болон бусдыг аврах олсоор хамгаалах, аврахын өмнө буух газарт аврах олсны урт хүрэлцэх эсэхийг шалгасны дараа гүйцэтгэнэ. Аврах олсны уяа, бэхэлгээг зөв хийж шалгасан байна.

485. Өөрийгөө болон бусдыг аврахдаа хэт нойтон чийглэг, мөн урьдчилан туршиж, шалгаагүй аврах олс хэрэглэхийг хориглоно. Аврах ажлын үед гарын бээлий заавал өмссөн байна.

486. Цахилгаан байгууламж ба түүний хамгаалалтын бүсэд гал түймэр унтраах үед Эрчим хүчний сайдын 2014 оны 101 дүгээр тушаалын нэгдүгээр хавсралт “Цахилгаан байгууламжийн ашиглалтын үед мөрдөх аюулгүй ажиллагааны дүрэм”-д заасан холбогдох заалтыг мөрдөнө.

487. Цахилгаан байгууламж, тоног төхөөрөмжийн хаалт хашилтгүй хүчдэлтэй байгаа гүйдэл дамжуулах хэсэгт Гал түймэр унтраах дадлага сургууль, унтраах үйл ажиллагаа зохион байгуулахдаа Эрчим хүчний сайдын 2014 оны 101 дүгээр тушаалын нэгдүгээр хавсралтын 1 дүгээр хүснэгтэд зааснаас дотогш зайд ойртохыг хориглоно.

Ойн гал түймэр унтраах үеийн аюулгүй ажиллагаа

488. Ойн гал түймрийг унтраах удирдагч /дарга, захирагч/-ийн үүрэг:

488.1. Ойн гал түймрийг унтраах алба хаагчдыг томилсон тушаал гаргах.

489. Алба хаагчдыг гал түймэр унтраах багаж, хүн нэг бүрийн хэрэгсэл, 3 хоногийн хоол хүнсний нөөцөөр хангасан байна.

490. Ажиллагаанд оролцох алба хаагчдад хачгийн эсрэг ийлдэс бүхий тарилга урьдчилан хийлгэсэн байх.

491. Ажиллагаанд оролцох алба хаагчдыг газар орон дээр ундны усаар хангах. Хэрвээ ажиллагаа явуулах газар ундны усны эх үүсвэр байхгүй тохиолд нэг хүнд 5-6 литр усны (цэвэр усны сав, халуун сав, дашмаг гэх мэт) нөөцтэй явуулах.

492. Ойн гал түймэр унтраах ажиллагаанд тухайн жил биеийн эрүүл мэндийн үзлэгээр орж тэнцсэн 18-50 насны, энэхүү ажлыг гүйцэтгэх дадлага туршлагатай алба хаагчдыг оролцуулна.

493. Ойн гал түймэр унтраах ажиллагааны туслах ажилтнаар, гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн анги, орон нутгийн удирдлага, ард иргэдийн туслалцааг авахдаа (хангалт үйлчилгээний, хоол бэлтгэх, жижүүр гэх мэт) жирэмсэн болон хөхүүл хүүхэдтэй эмэгтэйчүүдээс бусад эмэгтэйчүүдийг, мөн насанд хүрсэн эрүүл мэндээр тэнцсэн иргэдийг ажиллуулна.

494. Ойн гал түймэр унтраах ажиллагаанд согтууруулах болон мансууруулах бодис хэрэглэсэн хүнийг оруулахыг хориглоно.

495. Ойн гал түймрийг унтраах ажиллагаанд оролцож буй алба хаагч, ажилчид зөвхөн гал түймэр унтраах удирдагчийн заавраар ажиллана.

496. Түймрийн голомтод 25-аас дээш бүрэлдэхүүн ажиллах үед эмнэлгийн тусгай хэрэгсэлтэй 1 эмч заавал томилон ажиллуулна.

Ажиллагааны өмнөх аюулгүй ажиллагааны шаардлага

497. Ажиллагаанд явахдаа түймэр унтраах багаж хэрэгсэл, бие бүрэлдэхүүний хувцас, гутал, бусад хамгаалалтын хэрэгслийг (шумуулын тос, тор, эмийн сан гэх мэт) шалгана.

498. Ажиллагаанд явахын өмнө бие бүрэлдэхүүн нь үндсэн ажлын байран дээр ХАБЭАД-ийн нэгдүгээр шатны зааварчилгааг тухайн асуудал хариуцсан алба хаагч танилцуулж гарын үсэг хүн нэг бүрээр зуруулсан байна.

499. Түймэр унтраах бүрэлдэхүүнийг түймрийн бүсэд зөвхөн өдрийн цагаар буюу харагдах нөхцөл сайтай үед хүргэж өгнө.

500. Бие бүрэлдэхүүнийг тээврийн хэрэгсэл болон агаарын хөлгөөр хүргэх үед тухайн хэрэгсэлд тавигдах аюулгүй ажиллагааны шаардлагыг зохих журмын дагуу хангасан байх ёстой.

501. Нисдэг тэрэгнээс агаарт түр зогсолт хийх, буух үеийн аюулгүйн ажиллагааны зааварчилгааг өгөх ба түүнд тавих хяналтыг мэргэжлийн алба хаагч гүйцэтгэнэ.

502. Нисдэг тэрэг буух болон суулт хийх үед мотор бүрэн зогссоны дараа буюу сэнс зогсох хүртэл даргын зөвшөөрөлгүйгээр хэн ч гарж болохгүй.

503. Нисдэг тэрэгнээс буухдаа сэнс нь гарах хаалганаас 45⁰ урагш хөндлөн тэнхлэгтэй байх үед бууна. /Агаарын ажиллагааны зааварчилгааг дагаж мөрдөх /

504. Түймэр унтраах үед машинаар болон явган явах үед харанхуйгаас өмнө хоноглох газрыг сонгосон байна.

505. Гол, намагтай газраар гарах тохиолдолд бүлгийн дарга, даргын томилсон туршлагатай алба хаагч саваа мод ашиглан гарах хэсгийг шалгана.

506. Шатсан, нунтаг чулуутай, унангитай газраар сонор сэрэмжтэй явах, бололцоотой бол түүнийг тойрч гарах.

507. Ажиллагааны үед болон бусад үед зүг чигээ алдаж баримжаалах нөхцөлгүй болсон тохиолдолд задгай талбай болон өндөрлөг газар гаран хайж байгаа бусад алба хаагчдад дэмжлэг үзүүлэх зорилгоор утаа гаргах, дуут дохио өгөх, дохионы пуужин ашиглан өөрийгөө мэдэгдэх арга хэмжээ авах.

508. Онцгой тохиолдолд суурин газар луу явах, гол горхины урсгалын дагуу явж байгаа газартаа өөрийн мэдээлэл болох тэмдэгтүүдийг тавьж өгнө.

Ажиллагааны үед тавигдах аюулгүй ажиллагааны шаардлага

509. Ойн гал түймэр унтраах ажиллагааны удирдагч нь ойн түймрийн төрөл тэдгээрийг унтраах арга техникт суралцсан зохион байгуулах чадвартай, газар орныг байдлыг үнэлж чаддаг, ойд зүг чиг сайн баримжаалж сурсан алба хаагчийг томилон ажиллуулна.

510. Ойн гал түймрийг унтраахаас өмнө ажиллагааны удирдагч тандалтыг зохион байгуулж түймрийн хил, тархалтын хурд, чиглэлд байгалийн саад байгаа эсэхийг тодорхойлж унтраах арга зүйг тогтооно.

511. Хөвч тайга, ойн гүнд ажиллах алба хаагчдыг 5-аас доошгүй хүний бүрэлдэхүүнтэй томилж унанги, хөвдийн цөмрөлт, хөрсний халалт, түймэр бүслэх аюултай нөхцөлөөс урьдчилан сэргийлж аюулгүй ажиллагааны зааварчилгаа өгнө.

512. Ажиллагааны удирдагч тандалтын мэдээг үндэслэн түймэр унтраах газар орон дээр албан хаагчдад дараах зааварчилгааг өгнө. Үүнд:

513. Түймрийн үед байрлах аюулгүй газар, (хорогдох газар) буцах замыг зааж өгөх түүнчлэн байрлалаа солих үеийн хөтчийг томилно.

514. Амрах болон хоноглох газрыг зааж өгнө. Бие бүрэлдэхүүнд газар орон дээр болон байр зүйн зураг дээр түймрийн байрлал, хамгийн ойрхон байгаа суурин газар, автомашины зам тэдгээрийн шинж чанар, түймрийг унтраах хамгийн үр дүнтэй арга, хугацаа, хэрэгжилт зэргийг тодорхой тайлбарлан зааж өгнө.

515. Албан хаагчдад тэдний үүрэг, түймрийг унтраах аргыг зааж өгч бүрэлдэхүүний амрах, хооллох, ээлж солигдох журмыг тогтоож өгнө.

516. Гэнэтийн эрсдэлтэй нөхцөл байдал үүссэн үед хэрхэн ажиллах зааварчилгааг өгнө.

517. Ойн гал түймэр унтраах үед алба хаагчдыг гурваас доошгүй хүнтэй хэсэг, бүлгүүдэд хуваарилж, ахлах даргыг гал унтраах (ажиллагааны) удирдагч томилно.

518. Ойн гал түймэр унтраах бүлэг, хэсгийн дарга нь хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйг хангуулан хяналт тавин ажиллах ёстой.

519. Түймрийн захад ажиллах үед алба хаагч дараах зүйлийг анхаарна:

519.1. Харагдах нөхцөл сайтай үед хоёр алба хаагчдын аюулгүйн хоорондох зай нь 5 метрээс илүүгүй байна.

519.2. Зэргэлдээ ажиллаж байгаа алба хаагчдын хөдөлгөөнд байнга хяналт тавина.

519.3. Эрсдэл учирсан үед удирдах даргад нэн даруй мэдэгдэх.

519.4. Түймрийн захыг тойрч гарах ба ухрах үед ахлах даргад нэн даруй мэдэгдэнэ.

519.5. Аюултай нөхцөл үүссэн үед зэргэлдээх алба хаагчдад заавал мэдэгдэнэ.

519.6. Гал түймэр унтрааж байх явцад ахлах даргын зөвшөөрөлгүй голомтыг дур мэдэн орхиж болохгүй. Гэмтсэн, утаанд угаартсан, эрүүл мэндэд ноцтой хохирол учирсан үед зэргэлдээх алба хаагч болон ахлах даргад мэдэгдэнэ.

519.7. Түймрийн захад байгаа хуурай ургамлуудад байнга хяналт тавьж, тэдгээрийг түймрийн дотогш оруулан цэвэрлэж байх.

520. Алба хаагч нь тусгай хамгаалалтын хувцаснаас гадна хамгаалалтын малгай, тоосноос хамгаалах амны хаалт, амьсгалын эрхтэн хамгаалах утаа шүүгч, нүд хамгаалах хэрэгсэл хамгаалах хэрэгсэлтэй байна.

521. Өндөр хэмийн халуун, утаатай орчинд ажиллаж буй алба хаагчдыг ойролцоогоор 1-2 цагийн дараа ээлжийг солино. Өндөр хэм, утаагүй орчинд богино хугацаанд амраасны дараа дахин ажиллагаанд оруулна.

522. Ажиллагааны удирдагч цурав тавих үед угтуулан гал /цурав/ тавих талбай болон түймрийн зурвасын хооронд хүн болон техник хэрэгсэл байгаа эсэхийг

шалгасны дараа цурав тавих дохиог өгнө. Зурвасыг түймэр давж гарахаас урьдчилан сэргийлэн байнга хяналт тавина.

523. Тулгуурт зурвасыг байгуулахдаа тухайн түймрийн тархалтын хурдыг харгалзан үзэх ёстой. Хурдтай оройн түймрийн үед албан хаагчид түймрийн захаас 250 метрийн зайд байна.

524. Хөрсөн доогуурх түймрийг (хүлэр) унтраахын өмнө тандалтыг явуулан хилийг тогтоох ёстой. Түймрийн хилийг тогтоосны дараа туг болон гарын доорх эд зүйлсээр тэмдэг тавьж өгнө.

525. Хөрсний доогуурх түймрийг унтраахад алба хаагчид мод унах аюулаас сэрэмжилж тогтоосон хилээс дотогш орохгүй.

526. Химийн найрлагатай шингэнээр найруулсан усаар түймрийг унтраахад алба хаагчид амьсгалын эрхтэнд орохоос сэргийлж салхины эсрэг талд байрлана.

527. Түймрийг түрэгч техник /бульдозер/ ашиглан унтраах үед алба хаагчид түүний ойр байрлахгүй.

528. Түрэгч техник /бульдозер/-ийн жолооч нь чиглүүлэгчийн дохиогоор ажиллана.

529. Чиглүүлэгч нь түймрийн тархалтын чиглэл, түймрээс цог, нурам тулгуурт зурвасыг давж буй эсэхэд хяналт тавина.

530. Уулын бүсэд түймэр унтраах үед дараах зүйлсийг хориглоно:

530.1. Уулын налуугийн өнцөг нь 20⁰ дээш шаталга эрчимтэй явагдаж болох залуу шилмүүст мод болон бут, ургамалтай газарт ажиллах.

530.2. Түймрийн тархалтын чиглэлийн дагуу нарийн хавцал болон хад, чулуу нуруу болзошгүй газар байрлах.

530.3. Амрах болон хоноглох газар нь түймрийн захаас 500 метрээс багагүй зайд байна. Хоноглох газрыг тойруулан 2 метрийн өргөнтэй хамгаалалтын зурвас хийсэн байна. Түймрээс хамгаалах зурвасыг давж болзошгүй үед нэмэгдэл зурвас байгуулж болно. Хоноглох газрын 50 метрийн тойрогт байгаа шатамхай мод, бут, ургамлыг цэвэрлэнэ. Амралтын үед жижүүрийг томилон ажиллуулна. Харин том хэмжээний түймэртэй үед 24 цагаар байнгын жижүүрийг томилон түймрийн тархалтын чиглэл болон хурдыг хянаж байх ёстой.

530.4. Хоноглох байрыг сонгохдоо усны эх үүсвэртэй газар байвал зохимжтой.

530.5. Мөн тээврийн хэрэгсэл ирж болох /агаарын хөлөг буух талбайтай/ газар орон байвал зохино.

530.6. Хоноглох газрыг гал түймэр унтраах /ажиллагааны/ удирдагч сонгоно

530.7. Хоноглох газрыг дараах газар байрлуулж болохгүй. Үүнд:

530.7.1. Уулын орой, налуу хэсэг, бэлд;

530.7.2. Чулуу нурах, хөрсний гулсалт, цасан нуранги үүсэж болзошгүй газар;

530.7.3. Голын усны түвшин нэмэгдэж болзошгүй болон нам доор газар;

530.7.4. Цахилгаан, нефтийн болон байгалийн хий дамжуулах шугамын ойролцоо;

530.7.5. Усанд автаж болзошгүй арал болон голын эрэг;

530.7.6. Унаж болзошгүй модны ойролцоо;

530.7.7. Голын ойролцоо хоноглох газрыг сонгохдоо усны түвшин нэмэгдэж усанд автаж болзошгүй газрыг харгалзан үзэх ёстой.

530.7.8. Түүнчлэн шумуулаас хол байхын тулд задгай газар байвал зохино.

531. Ойн гал түймрийг унтраах ажилд эрүүл мэндийн үзлэгээр орж тэнцсэн албан хаагчдыг ажиллуулна. Түүнчлэн цацраг идэвхт бодисоор бохирдсон орчинд хэрхэн ажиллах зааварчилгааг өгсөн байна.

532. Ойн гал түймэр унтраах ажиллагаанд оролцох алба хаагчид ой, хээрийн гал түймрээс ой, хээрийн гал түймэр унтраах ажиллагаанд зориулсан хамгаалах тусгай хувцас, хэрэглэлийг бүрэн өмссөн байна.

533. Хамгаалалтын зурвасыг байгуулахдаа ус болон ус цацах, гар багаж хэрэгсэл /механик/ болон агаарын төхөөрөмжүүдийг ашиглана.

534. Ойн цацраг идэвхт бодисын бохирдол их $15 \text{ ki}/\text{km}^2$ (цацраг идэвхт бодисын бохирдол ki) дээш тохиолдолд түймрийг агаараас агаарын хөлгийн тусламжтайгаар унтраана.

535. Ойн цацраг идэвхт бодисын бохирдол $15 \text{ ki}/\text{km}^2$ дээш тохиолдолд албан хаагчид түймэр унтраах бол тусгай зориулалтын хамгаалалтын 3 иж бүрдэл хувцсаар хангасан байна. Уг хувцас нь цацраг идэвхт бодисоор бохирдсон газар ажиллахад аюулгүй ажиллах шаардлага хангасан хувцас байх ёстой.

536. Цацраг идэвхт бодисоор бохирдсон газар ажилласан бол ажиллагааны дараа заавал албан хаагчид усанд орох ба хамгаалалтын хувцсыг солих ёстой.

537. Цацраг идэвхт бодисоор бохирдсон газар орон дээр хоноглож болохгүй.

538. Цацраг идэвхт бодисоор 0,5 бэр (5 мЗв) (цацраг идэвхт бодисын хэмжээ мЗв) дээш бохирдсон газар орон дээр ажилласан албан хаагчийг нэг жилийн хугацаанд дахин ийм орчинд ажиллуулж болохгүй.

539. Эрсдэлтэй нөхцөл үүссэн үед тавигдах аюулгүй ажиллагааны шаардлага

540. Эрсдэлтэй нөхцөл үүсэх шалтгаанууд.

540.1. Хамгаалалтын зурвасыг түймэр даван гарч ар талд дахин жижиг хэмжээний түймэр гарч бүслэн унтрааж буй алба хаагчдад эрсдэлтэй нөхцөл бий болгодог,

540.2. Утаатай орчин түймрийн зах /фронт/-ыг харах нөхцөлийг бууруулдаг,

540.3. Ойд налуу газар түймэр унтраах явцад том модны доор ургасан олон тооны залуу шилмүүст моднууд нь галд автсан үед энэхүү түймэр хөрсний түймрээс оройн түймэр болох аюултай нөхцөл бий болгодог,

540.4. Залуу шилмүүст модтой газар түймэр унтрааж байх үед гэнэт хүчтэй салхи гарсан үед түймрийн чиглэл огцом өөрчлөгдөх аюулыг бий болгодог,

540.5. Уулын налуу газар түймэр унтрааж байх үед шатамхай болон галтай аргал, хомоол гэх мэт зүйлс уулын уруу унаж доод талд дахин түймрийн голомт үүсгэх аюултай,

540.6. Түймрийг унтрааж байх явцад салхи, газрын гадаргуугийн нөхцөл байдлаас шалтгаалан түймэр бүслэх аюултай нөхцөл бий болно.

541. Алба хаагчид их ядарсан үед ойрхон байх түймрийн захыг анхааралтай ажиглаж байх.

542. Хүчтэй дуу цахилгаантай бороо орох үед холбоо /радиостанц/-уудыг унтраах, антenuудыг газардуулах, металл хийц болон машин механизмаас хол байлгах хэрэгтэй.

543. Алба хаагчид аюулгүй газрын байрлалыг сонгохдоо мод хоорондох зай нь 20-25 метр, налуу газрын толгод дээр байрлах хэрэгтэй.

544. Хүчтэй дуу цахилгаантай бороо орж байх үед албан хаагчид сондгой ганц модны доор, геодезийн болон ажиглалтын цамхгийн хажууд, цахилгаан болон холбооны дамжуулах шугамын шонгийн доор зогсохыг хориглоно.

545. Алба хаагчид боломжтой бол байшинд байрлах, харин машин механизмыг хүмүүсээс доод тал нь 10 метрээс доошгүй зайд байрлуулах.

546. Эрсдэлтэй нөхцөл үүссэн үед гал түймэр унтраах удирдагч бүх хүмүүсийг аюулгүй газар шилжүүлэн байрлуулах ёстой. Энэ үед гал түймэр унтраах удирдагч болон алба хаагчид хурдан шуурхай, сандралгүй гүйцэтгэх ёстой.

547. Нэрвэгдэгчдэд эрүүл мэндийн анхны тусламж үзүүлж, эмнэлгийн байгууллагад хүргэх ажлыг зохион байгуулна. Дээд шатны удирдлагад үүссэн нөхцөл байдлыг мэдэгдэнэ.

548. Ажиллагаа дууссаны дараа тавигдах аюулгүй ажиллагааны шаардлага

549. Ажиллагааны дараа гал түймэр унтраах удирдагч түймэр унтраахаар оролцсон бүх алба хаагчдыг цуглуулан нэрсийн жагсаалтын дагуу бүрэн байгаа эсэхийг шалгана.

550. Алба хаагч шалтгаангүйгээр байхгүй тохиолдолд нэн даруй эрлийн ажлыг зохион байгуулна.

551. Алба хаагчид нь гал түймэр унтраах /ажиллагааны/ удирдагчийн зөвшөөрөлгүй усанд орох, загас барих, суурин газар луу явахыг хориглоно.

552. Байнгын байрлал руу буцах үед гал унтраах багаж хэрэгслийг даргын зааврын дагуу түүний хяналтын доор тээвэрлэнэ.

553. Бензин, дизелийн түлшээр ажилладаг багаж хэрэгслийн бүх шатах тослох материалыг зөөврийн сав руу бүрэн юүлнэ.

554. Байнгын байрлалд ирсэн даруй түймэр унтраах багаж хэрэгслийг цэвэрлэн журам зааврын дагуу хадгалалтад шилжүүлнэ. Ой, хээрийн гал түймрээс хамгаалах хувцас, гутлыг тайлан цэвэрлэж хадгалалтад шилжүүлнэ. Алба хаагчдыг эрүүл ахуйн шаардлагыг хангуулна.

555. Бүлгийн дарга ХАБЭА-н зааварчилгааны тайланг захирагч, даргад бичгээр танилцуулна.

Хээрийн гал түймэр унтраах үеийн аюулгүй ажиллагаа

Ажиллагааны үед тавигдах аюулгүй ажиллагааны шаардлага

556. Хээрийн гал түймэр унтраах ажиллагааны удирдагчаар тусгайлан бэлтгэгдсэн, гал түймэр унтраах арга тактикт суралцсан, зохион байгуулах чадвартай, газар орныг байдлыг үнэлж чаддаг, зүг чиг сайн баримжаалж сурсан алба хаагчийг томилон ажиллуулна.

557. Хээрийн гал түймрийг унтраахаас өмнө ажиллагааны удирдагч тандалтыг зохион байгуулж түймрийн хил, тархалтын хурд, чиглэлд хот суурин, айл өрх бусад байгалийн саад байгаа эсэхийг тодорхойлж унтраах аргыг сонгоно.

558. Гал түймэр унтраах /ажиллагааны/ удирдагч тандалтын мэдээг үндэслэн түймэр унтраах газар орон дээр албан хаагчдад дараах зааварчилгааг өгнө. Үүнд:

558.1. Түймрийн үед байрлах аюулгүй газар (хорогдох газар), буцах замыг зааж өгөх, байрлалаа солих үеийн хөтчийг томилно.

558.2. Амрах болон хоноглох газрыг зааж өгнө. Бие бүрэлдэхүүнд газар орон дээр болон байр зүйн зураг дээр түймрийн байрлал, баримжаалал, хамгийн ойрхон

байгаа суурин газар, автомашины зам тэдгээрийн шинж чанар, түймрийг унтраах хамгийн үр дүнтэй арга, хугацаа, хэрэгжилт зэргийг тодорхой тайлбарлан зааж өгнө.

558.3. Албан хаагчдад тэдний үүрэг, түймрийг унтраах аргыг зааж өгнө.

558.4. Бие бүрэлдэхүүний амрах, хооллох, ээлж солигдох журмыг тогтоож өгнө.

558.5. Гэнэтийн эрсдэлтэй нөхцөл байдал үүссэн үед хэрхэн ажиллах талаар зааварчилгааг өгнө.

559. Холбоо харилцаа, мэдээлэл солилцох хугацааг тогтоож өгнө.

560. Гал түймрийг унтраах ажиллагаанд оролцохдоо нүдний линз /Нүдний болорт наалдуулан тогтоодог харааны хэрэгсэл/ хэрэглэхийг хориглох.

Түймрийн захад ажиллах аюулгүй ажиллагаа

561. Харагдах нөхцөл сайтай үед хоёр алба хаагчдын аюулгүйн хоорондох зай нь 15 метрээс илүүгүй байна.

562. Зэрэгцээ ажиллаж байгаа алба хаагчдын хөдөлгөөнд байнга хяналт тавина.

563. Эрсдэл учирсан үед ахлах даргад нэн даруй мэдэгдэх.

564. Түймрийн захыг тойрч гарах, ухрах үед ахлах даргад нэн даруй мэдэгдэнэ.

565. Аюултай нөхцөл үүссэн үед ойр байрлан ажиллаж байгаа алба хаагчдад заавал мэдэгдэнэ.

566. Түймэр унтраах явцад ахлах даргын зөвшөөрөлгүй ажлыг байрыг дур мэдэн орхиж болохгүй. Гэмтсэн, утаанд угаартсан, эрүүл мэндэд ноцтой хохирол учирсан үед зэргэлдээх алба хаагч болон ахлах даргад мэдэгдэнэ.

567. Түймрийн захад байгаа хуурай ургамал, аргал, хомоол, хоргол зэргийг өнхрөх, хийсэж гарахаас сэргийлж байнга хяналт тавьж, цэвэрлэгээ хийхдээ тэдгээрийг түймрийн дотогш оруулан цэвэрлэнэ.

568. Алба хаагч нь тусгай хамгаалалтын хувцаснаас гадна хамгаалалтын малгай болон тоос, утаанаас хамгаалах амны хаалт, амьсгалын эрхтэн хамгаалах утаа шүүгч, харах эрхтэн хамгаалах хэрэгсэлтэй байна.

569. Өндөр хэм болон утаатай орчинд удаан хугацаанд ажиллах тохиолдолд алба хаагчдыг богино хугацаанд сэлгэн амраасны дараа дахин ажиллагаанд оруулна.

Ажиллагааны удирдагч /цурав/ угтуулан гал тавих үед

570. Цурав тавих зурвасыг байгуулахдаа салхины хурд, түймрийн тархалтын чиглэл, хурдыг тооцоолно.

571. Цурав тавих талбайд хүн болон техник хэрэгсэл байгаа эсэхийг шалгасны дараа цурав тавих дохиог өгнө. Цурав тавьсан зурвасыг түймэр давж гарахаас сэргийлж, байнга хяналт тавина.

572. Цурвыг цаг агаар бусад хүчин зүйлсээс хамаарч түймрийн тархалтын хурд, төөнөлт нь багассан үед тавина.

573. Түймрийг газар хагалагч /анжис/ ашиглан хамгаалалтын зурвас татах үед /анжис/ эргэх тойрогт байрлаж болохгүй.

574. Гал түймэр унтраах удирдагч түймрээс хамгаалах зурвас татах өргөн, чиглэлийг тогтоож, бүлгийг 3-аас доошгүй хүнтэй томилно.

575. Цурав тавих бүлэг нь цуравдагч, үүргийн гал унтраагуур, үлээгч аппараттай ажиллаж, салхины хурд, чиглэлд байнга хяналт тавин аюулгүй байдлыг хангана.

576. Амрах болон хоноглох газар нь түймрийн захаас 500 метрээс багагүй зайд, салхины дээр эсвэл цурван дотроо байна. Хоноглох газрыг тойруулан 2 метрийн өргөнтэй хамгаалалтын зурвас хийсэн байна. Түймрийн хамгаалалтын зурвасыг давж болзошгүй үед нэмэгдэл зурвас байгуулж болно. Хоноглох газрын 50 метрийн тойрогт байгаа шатамхай хуурай ургамал, бут, аргал, хомоол, хоргол зэргийг өнхрөх, хийсэхээс сэргийлэн цэвэрлэнэ. Амралтын үед жижүүрийг томилон ажиллуулна. Харин том хэмжээний түймэртэй үед 24 цагаар байнгын жижүүрийг томилон түймрийн тархалтын чиглэл болон салхины хурдыг хянана.

Гал түймэр унтраах удирдагчийн авч хэрэгжүүлэх арга хэмжээ

577. Хоноглох газар (штаб)-ыг сонгохдоо хуурай, усны эх үүсвэртэй, харилцаа холбоо тогтоох, тээврийн хэрэгсэл очих боломжтой зам дагуу (агаарын хөлөг буух талбайтай) байвал зохино.

578. Хоноглох газрыг гал түймэр унтраах удирдагч сонгоно.

579. Хоноглох газрыг дараах газар байрлуулахыг хориглоно.

579.1. Голын усны түвшин нэмэгдэж болзошгүй болон нам доор газар,

579.2. Цахилгаан, нефть, байгалийн хий дамжуулах шугамын ойролцоо,

579.3. Усанд автаж болзошгүй арал, голын эрэг, гуу жалга,

579.4. Араатан амьтан, бичил биет шавж, бусад болзошгүй аюулаас урьдчилан сэргийлж, агаараас харах боломжтой ил задгай газар байвал зохино.

580. Түймрийн голомтод 25-аас дээш бүрэлдэхүүн ажиллах үед эмнэлгийн тусгай хэрэгсэлтэй 1 эмч томилон ажиллуулна.

581. Уулын налуу, хавцал, хад асган дунд ажиллах бүлгийг 5-аас доошгүй хүний бүрэлдэхүүнтэй томилж аюулгүй ажиллагааны зааварчилгааг заавал өгнө.

582. Хүчтэй дуу цахилгаантай бороо орох үед холбоо /радиостанц/-уудыг унтраах, антенуудыг газардуулах, металл хийц болон машин механизмаас хол байлгана.

583. Алба хаагчид боломжтой бол байшинд байрлах, харин машин механизмыг хүмүүсээс доод тал нь 10 метрээс багагүй зайд байрлуулах.

584. Түймэрт ажиллах бие бүрэлдэхүүн байршлаа мэдээлэх, галт зэвсэг, дуут дохио, гэрэлт пуужин, дуурайлган үзүүлэх хэрэгсэл (утаат шашки), сансрын холбооны хөдөлгөөнт утас (иридиум)-тай байна.

585. Цаг агаарын болзошгүй аюул, цасан болон шороон шуурга, үер, аянга, дуу цахилгаантай бороо орох үед алба хаагчдад урьдчилан мэдээлж аюулгүй байдлыг хангана.

586. Гал түймрийн цурмын дотуур зам товчилж явах, хөрсний гүний гал түймрийн хил хязгаарыг урьдчилан тогтоосон тэмдэглэгээнээс дотогш нэвтэрхийг хориглоно.

587. Гал түймэр унтраах удирдагчийн зөвшөөрөлгүй ажлын байрыг орхих, шилжилт хөдөлгөөн хийхийг хориглоно.

Ажиллагаа дууссаны дараа тавигдах аюулгүй ажиллагааны шаардлага

588. Ажиллагааны дараа удирдагч түймэр унтраахаар оролцсон бүх алба хаагчдыг цуглуулан нэрийн жагсаалтын дагуу бүртгэнэ.

589. Байнгын байрлал руу буцах үед гал унтраах багаж хэрэгслийг даргын зааврын дагуу түүний хяналтын доор тээвэрлэнэ.

590. Бензин, дизелийн түлшээр ажилладаг багаж хэрэгслийн шатах тослох материалыг багаж хэрэгслээс зөөврийн саванд юүлнэ.

591. Байнгын байрлалд ирмэгц хамгаалалтын хувцас, түймэр унтраах багаж хэрэгслийг цэвэрлэн журам зааврын дагуу хадгалалтад шилжүүлнэ. Алба хаагчдыг эрүүл ахуйн шаардлагыг хангуулна.

592. Удирдах дарга ХАБЭА-н зааварчилгаа, мэдээ, тайланг дарга, захирагчид илтгэх хуудсаар танилцуулна.

Эрэн хайх, аврах ажиллагааны үеийн аюулгүй ажиллагаа

593. Голомтын бүсэд ажиллаж буй аврагч дараах шаардлагыг дагаж мөрдөн ажиллана. Салбар, бүлгийн даргын зааврыг чанд сахин биелүүлж, ажиллагааны үед ашиглаж буй техник хэрэгслийн аюулгүй ажиллагааны дүрэм, зааврын дагуу мөрдөн ажиллах;

594. Тусгай үүрэг даалгавар авсан бүрэлдэхүүн ажлыг гүйцэтгэх аргачлал, аюулгүй ажиллагааг тодорхой бус байвал нэмэгдэл зааварчилгааг тушаал өгсөн удирдлагаас авна. Өгөгдөж байгаа дохио, командыг анхааралтай сонсох, ажиллагааны явцад эвдрэл, гэмтэлтэй механизм, багаж тоног төхөөрөмж, хамгаалах хэрэгсэл ашиглахгүй, туршлагагүй аврагч нар аюулгүйн ажиллагааг хэрхэн мөрдөн ажиллаж байгаад хяналт тавих.

595. Нурсан барилга байгууламжаас эрэн хайх, аврах ажиллагаанд оролцох, бие бүрэлдэхүүн хүн нэг бүрийн тусгай зориулалтын хамгаалах хэрэгсэл, гүйцэтгэх ажлын онцлогоос хамааран хамгаалалтын гутал, хувцас хэрэгслээр хангагдсан байна.

596. Эрэн хайх, аврах ажиллагаанд оролцох бие бүрэлдэхүүнд дараах зүйлсийг хатуу хориглоно.

596.1. Нурах магадлалтай болон цуурсан барилга, байгууламжийн ойролцоо газар зогсох,

596.2. Даргын зөвшөөрөлгүйгээр аюултай бүс рүү орох,

596.3. Даргад мэдэгдэлгүйгээр болон хамгаалалтыг зохион байгуулаагүй тохиолдолд нурсан барилга, байгууламжийн нурангийг цэвэрлэж эхлэх,

596.4. Гэмтэлтэй цахилгааны шугам, тоног төхөөрөмжийг оролдохгүй байх. Газарт байгаа цахилгааны шугам дээр гишгэхгүй байх,

596.5. Тээврийн болон инженерийн хэрэгслийн хөдөлгөөний зам дээр болон өргөх механизмын доор зогсохгүй байх,

596.6. Зөвшөөрөгдөөгүй газар тамхи татах, ил болон түүдэг гал гаргахгүй байх

596.7. Эвдрэл, гэмтэлтэй цахилгааны үүсвэр, тандалт явуулаагүй хонгил, нүхээр хамгаалалтын хувцас хэрэглэлгүй явахыг,

596.8. Хүн нэг бүрийн хамгаалах хэрэгслийг даргын зөвшөөрөлгүйгээр болон тогтоосон бус газар тайлахыг,

596.9. Ажиллагааны өмнө багаж хэрэгсэл, тоног төхөөрөмж, бага оврын механизмыг шалгах болон ажиллагааны үед эвдрэл үүссэн үед аврагч нэн даруй бүлгийн даргад илтгэж түүний зааврын дагуу гүйцэтгэнэ. Эвдэрсэн багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжийг солих, засварын бүлэг рүү илгээх шийдвэрийг ахлах дарга гаргана,

596.10. Ажиллагаанд оролцож буй аврагч нар нэрвэгдэгч ба өөртөө эрүүл мэндийн анхны тусламж үзүүлэх чадвартай байх, хүн нэг бүрийн хувийн боох болон

анхны тусламж үзүүлэх эмийн сантай байна. Шаардлагатай үед нэрвэгдэгчийг эмнэлгийн анхны тусламж үзүүлэх цэг рүү хүргэх буюу хэрхэн зөөвөрлөх аргачлалыг мэддэг байна,

596.11. Эрэн хайх, аврах ажиллагааны хөдөлмөрийн аюулгүй байдлын зааварчилгааг ажиллагааны өмнөх, ажиллагааны үеийн, ажиллагааны дараах гэсэн үндсэн ерөнхий зааварчилгааг өгнө. Тусгай үүрэг даалгаврын аюулгүй ажиллагааны зааварчилгааг тусад өгнө. (хими, цацраг идэвхт гэх мэт)

Уулнаас эрэн хайх, аврах ажиллагаа

597. Аврагч-уулчин нь уулчны иж бүрдлийг өөрийн биед тохируулсан байх.

598. Аврагч-уулчин ууланд гаралт, авиралт, дайралт гүйцэтгэхдээ хувийн уулын хэрэгсэл, олсны бүрэн бүтэн байдлыг шалгаж, бэлтгэсэн байх, бэлтгэж дуусаад бүлгийн дарга, аврах ажиллагааны зааварлагчаар заавал шалгуулах шалгаж болсон тохиолдолд аврах ажиллагааг эхлэх.

599. Аврах олсыг шалгахдаа нэг үзүүрээс эхэлж нөгөө тал хүртэл нугалах, татах зэргээр сэмэрсэн, язарсан, гаднаа харагдах хэсэг нь бүтэн дотроо тасарсан, тасарч болзошгүй эсэхийг шалгана.

600. Уулнаас эрэн хайх, аврах ажиллагааны удирдагч аврах олсыг ажиллагаанд болон дууссаны дараа хүлээлгэн өгөхдөө хадгалалт, ашиглалтын тогтоосон үзлэгээр давхар шалгах.

601. Уулнаас эрэн хайх, аврах ажиллагаанд эмийн сан, холбоо, дохионы болон бусад шаардлагатай багаж хэрэгслийг бэлтгэсэн байх.

602. Тухайн газар орон болон гаралт, авиралт, дайралт гүйцэтгэх уул болон цаг агаарын талаарх мэдээллийг авсан байх.

603. Аврагч-уулчин нь ууланд гаралт, авиралт, дайралтыг техникийн дагуу гүйцэтгэх.

604. Ууланд гаралт, авиралт, дайралтын үед хоёр аврагч-уулчны олс хоорондын зай /гаралт болон авиралт 10-15 м, мөсөн голоор 15-30 м, дайралтын үед 6-7 м байхаар 3-5 аврагч нэг хамгаалалтын олсонд орох.

605. Туршлагатай аврагч-уулчин, хөтөч, газарчныг чиглүүлэгчээр томилох.

606. Нэг жим буюу замаар мөр дагаж алхах амрах, зогсохдоо зөвхөн нэг тушаалаар байх.

607. Ууланд гаралт, авиралт, дайралт гүйцэтгэж байгаа үед асга хад, цас нурах үед ажиглаж бусдад дохио өгч мэдээлэх.

608. Ууланд гаралт, авиралт, дайралт гүйцэтгэж байгаа үед шинэ цастай газраар явахдаа цасны доор ан, цав, ангал байж болзошгүйг анхаарах.

609. Аврагч-уулчид нэрвэгдэгсдийг өндөр уулнаас тээвэрлэн буулгаж байгаа үед үндсэн олс болон хамгаалах олсыг бэхэлсэн байх.

610. Ууланд гаралт, авиралт, дайралтын үед хад, асга цуулах, дуу чимээ үүсгэх, ан амьтан үргээх, мод, ургамал таслах, хог хаягдал, гал асааж орхих зэрэг үйлдлийг хориглоно.

Барилгаас эрэн хайх, аврах ажиллагаа

611. Эрэн хайх, аврах ажиллагаанд оролцох бие бүрэлдэхүүн нь аврах ажиллагааны удирдагчаас аюулгүй ажиллагааны талаар зааварчилгаа авна.

612. Эрэн хайх, аврах ажиллагаа явуулах бие бүрэлдэхүүн нь холбоо, иж бүрэн хамгаалах тусгай хувцас, зориулалтын техник, багаж хэрэгслээр хангагдана.

613. Эрэн хайх, аврах ажиллагаа явуулах газрын орчинд болон орох, гарах хэсэгт анхааруулах, хориглох тэмдэг тавих, аюултай хэсэгт хашлага хийх, хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахын тулд замын хөдөлгөөний зохицуулагч томилно.

614. Барилга, байгууламжийн нурах аюултай хийцүүдийг бэхлэх буюу нураах арга хэмжээ авна.

615. Хийц, хэсгүүд нь нурах буюу гулсах аюул тулгарсан үед аврагчдыг аюулгүй газар нэн даруй гаргана.

616. Нуранги, нурж эвдэрсэн барилга, байгууламж, хонгилд улаан гэрэлтэй анхааруулах дохио, /хөдөлгөөн мэдрэгч дуут дохио/ өндөрт ажил үүрэг гүйцэтгэх үед аврах бүс, олс хэрэглэнэ.

617. Газар доорх байгууламж руу орох, гарах үед олсыг ашиглах бөгөөд аврагчаар олсны нэг үзүүрийг бэхэлж, нөгөө үзүүрийг бат бөх зүйлээс сайтар уяж бэхэлнэ.

618. Үзэгдэх орчин хязгаарлагдмал буюу шөнийн нөхцөлд ажиллах газар, гол зам, гарцыг гэрэлтүүлнэ.

619. Эрэн хайх, аврах ажиллагаа явуулах үед өндөр даралтын хий шахагчийг тэгш газар байрлуулж, гарцыг гэрэлтүүлнэ.

620. Нурангийн том хэсгийг өргөхдөө өргөгчийг тогтвортой байрлуулна.

621. Нурангийг түрж зайлуулахдаа тухайн хэсгийн цахилгаан, дулааны шугам сүлжээг урьдчилан салгана.

622. Барилгын дээд давхруудаас нэрвэгдэгсдийг аврахдаа шатыг шалгаж, эвдэрсэн хэсгийг засах буюу гүүрэн шат тавьж, найдвартай бэхэлнэ.

623. Түр гарцын аюулгүй байдлыг хангах зорилгоор дамнуурга, гүүрэн дээр 0.9-1.2 м-ийн өндөртэй хашлагыг олс буюу ган татлагаар хийнэ.

624. Аврах олсны гогцоог нэрвэгдэгсдийн далнаас доогуур байрлуулна.

625. Аврах бүсний буулгах олсыг элэгдэлтийн байдлаас шалтгаалан солино.

626. Аврах шуудгийн татуургыг бат бэх зүйлд найдвартай бэхэлнэ.

627. Аврах ажилд автомеханик шат хэрэглэх бол энэ дүрмийн дөрөвдүгээр бүлгийн 2 дугаар зүйлийг баримтална.

628. Эрэн хайх, аврах ажиллагаа явуулахад хориглох зүйлс.

629. Тусгай бэхэлгээ хийхгүйгээр нурангийн доогуур гарц гаргах.

630. Нурсан барилга, байгууламжийн доторх өрөө тасалгаа, хонгилд хий үнэртэж байгаа үед тусгаарлагч баггүй ажиллах, гал гаргах, тамхи татах.

631. Үзэгдэх орчин хязгаарлагдмал буюу шөнийн нөхцөлд гэрэлтүүлэх хэрэгслийг эвдэрч гэмтсэн барилга, байгууламжийн цахилгаан шугамаас тэжээх.

632. Цахилгаан шугамыг солих, шалгах үед тусгаарлагч багаж, резин бээлий, гуталгүй ажиллах.

633. Өргүүрийн даацыг хэтрүүлэн ачаа өргөх, шатаж байгаа барилга, байгууламжийн өрөө, тасалгааны хаалгыг гэнэт онгойлгох.

634. Барилга байгууламжийн нурж болзошгүй хийцийн дэргэд олон хүн цуглуулж байрлуулах.

635. Нурж болзошгүй хийцийг бэхэлж байгаа үед түүний ойролцоо автомашин, механизмаар ажиллах, хөдөлгөөн үйлдэх.

636. Салхины хурд 20 м/с-ээс дээш байх үед автомеханик шат ашиглах.

637. Аврах багаж хэрэгслийг -20-оос +35 градуст хадгална.

638. Өндөр даралтын шахуургын ажиллагаатай багаж хэрэгслийг сард 2-оос доошгүй удаа бүрэн ажиллуулж шалган бүртгэл хөтөлнө.

Нурангид эрэн хайх, аврах ажиллагаа

639. Цахилгаан болон шатдаг хийн шугам сүлжээг таслах буюу хаах барилгын даацын үндсэн хана нурах аюултай хийцүүдийг шалган үзэх, доторх өрөө тасалгаануудыг шалгах.

640. Тэсэрч дэлбэрэх, бодис байгаа эсэх, хүн байгаа газруудыг тодорхойлох.

641. Нэрвэгдэгсдийг аюулд учруулахгүйгээр шилжүүлэх аргыг сонгох.

642. Нурах аюултай хийцүүдэд хяналт тогтоогоогүй буюу буруу үйлдлээс үүссэн нуралтаас.

643. Хаалт таглаагүй хучилт, онгорхой, цоорхой нүх рүү унах.

644. Хүнд техник, багаж, хэрэгсэл ажиллуулах үед анхаарлаа сарниулах Хамгаалалтын хэрэгсэл болох ажлын хувцас / бүх биеийг халхлах/, мөн дуулга, хатуу /хамгаалах/ ултай гутал, ажлын бээлий өмсөөгүйгээс түлэгдэх, эсгэгдэх, цохигдох гэх мэт.

645. Шаардлагагүй үед эвдэрсэн барилга руу орох, нуранги дундуур сэлгүүцэх нурах аюултай барилгын дэргэд удаан байх.

646. Нягт сүлжмэл эдээр хийсэн хувцас, битүү гутал, хамгаалалтын гутал, бээлий, амьсгалын эрхтнийг тоосонцроос хамгаалах амны даавуун хаалт, тоосонцроос хамгаалах шүүгчтэй багтай ажиллах.

647. Гамшгийн бүсэд ажиллаж буй аврагч дараах шаардлагыг дагаж мөрдөн ажиллана. Салбар, бүлгийн даргын зааврыг чанд биелүүлж, ажиллагааны үед ашиглаж буй техник хэрэгслийн аюулгүй ажиллагааны дүрэм, зааврын дагуу чанд мөрдөн ажиллах.

648. Тусгай үүрэг даалгавар авсан бүрэлдэхүүн ажлыг гүйцэтгэх аргачлал, аюулгүй ажиллагааг тодорхой бус байвал нэмэгдэл зааварчилгааг тушаал өгсөн удирдлагаас авна. Өгөгдөж байгаа дохио, командыг анхааралтай сонсох, ажиллагааны явцад эвдрэлтэй болон шалгаагүй механизм, багаж тоног төхөөрөмж, хамгаалах хэрэгсэл ашиглахгүй байх, тухайн нөхцөлд хангалтай туршлагагүй аврагч нар аюулгүйн ажиллагааг хэрхэн мөрдөн ажиллаж байгаа байнга хяналт тавих.

649. Нурсан барилга байгууламжаас эрэн хайх, аврах ажиллагаанд оролцож буй бие бүрэлдэхүүн хүн нэг бүрийн тусгай зориулалтын хамгаалах хэрэгсэл, гүйцэтгэж буй ажлын онцлогоос хамааран хамгаалалтын гутал, хувцас хэрэгслээр хангагдсан байна.

650. Эрэн хайх, аврах ажиллагаанд оролцож буй бие бүрэлдэхүүнд дараах зүйлсийг хатуу хориглоно.

651. Нурах магадлалтай болон цуурсан барилга, байгууламжийн ойролцоо зогсох.

652. Даргын зөвшөөрөлгүйгээр аюултай бүс рүү орох.

653. Даргад мэдэгдэлгүйгээр болон хамгаалалтыг зохион байгуулаагүй тохиолдолд нурсан барилга, байгууламжийн нурангийг цэвэрлэж эхлэх.

654. Гэмтсэн цахилгааны шугам, тоног төхөөрөмжтэй оролдохгүй байх. Газар хэвтэж буй цахилгааны шугам дээр гишгэхгүй байх.

655. Тээврийн болон инженерийн хэрэгслийн хөдөлгөөний зам дээр болон өргөх механизмын доор зогсохгүй байх.

656. Зориулалтын бус газар тамхи татах, ил болон түүдэг гал гаргахгүй байх

657. Эвдрэлтэй цахилгааны үүсвэр, тандалт явуулаагүй хонгил, нүхээр хамгаалалтын хувцас хэрэглэлгүй явахыг.

658. Хүн нэг бүрийн хамгаалах хэрэгслийг даргын зөвшөөрөлгүйгээр болон тогтоосон бус газар тайлахыг.

659. Хүн нэг бүрийн цасан нурангид ашиглагдах багаж (мөсний сүх, олс, хударга, GPS, хамгаалалтын хар нүдний шил), аврагч бүр тэмтрүүл бүхий сунадаг таягтай (1-1.5м) байна.

660. Гишгэлтийн талбайг ихэсгэх цасны тавчигчтай байх.

661. Аврагчид хорондоо олсоор холбогдож явах.

662. Эрэл хайгуулын талбайг жигд хувааж.

663. Хөдөлгөөн үйлдэх гадаргуу 25 хэмээс дээш налуу тохиолдолд.

664. Эрэн хайх, аврах ажиллагаанд оролцох бие бүрэлдэхүүн нь аврах ажиллагааны удирдагчаас аюулгүй ажиллагааны талаар тодорхой зааварчилгаа авна.

665. Эрэн хайх, аврах ажиллагаа явуулах бие бүрэлдэхүүн нь холбоо, иж бүрэн хамгаалах тусгай хувцас, зориулалтын техник, багаж хэрэгслээр хангагдана.

666. Эрэн хайх, аврах ажиллагаа явуулах газрын орчинд болон орох, гарах хэсэгт анхааруулах, хориглох тэмдэг тавих, аюултай хэсэгт хашлага хийх, хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахын тулд замын хөдөлгөөний зохицуулагч томилно.

667. Барилга, байгууламжийн нурах аюултай хийцүүдийг бэхлэх буюу нураах арга хэмжээ авна.

668. Хийц, хэсгүүд нь нурах буюу гулсах аюул тулгарсан үед аврагчдыг аюулгүй газар нэн даруй гаргана.

669. Нуранги, нурж эвдэрсэн барилга, байгууламж, хонгилд улаан гэрэлтэй анхааруулах дохио, /хөдөлгөөн мэдрэгч дуут дохио/ өндөрт ажил үүрэг гүйцэтгэх үед аврах бүс, олс хэрэглэнэ.

670. Газар доорх байгууламж руу орох, гарах үед олсыг ашиглах бөгөөд аврагчаар олсны нэг үзүүрийг бэхэлж, нөгөө үзүүрийг бат бөх зүйлээс сайтар уяж бэхэлнэ.

671. Үзэгдэх орчин хязгаарлагдмал буюу шөнийн нөхцөлд ажиллах газар, гол зам, гарцыг гэрэлтүүлнэ.

672. Эрэн хайх, аврах ажиллагаа явуулах үед өндөр даралтын хий шахагчийг тэгш газар байрлуулж, гарцыг гэрэлтүүлнэ.

673. Нурангийн том хэсгийг өргөхдөө өргөгчийг тогтвортой байрлуулна.

674. Нурангийг түрж зайлуулахдаа тухайн хэсгийн цахилгаан, дулааны шугам сүлжээг урьдчилан салгана.

675. Барилгын дээд давхруудаас нэрвэгдэгсдийг аврахдаа шатыг шалгаж, эвдэрсэн хэсгийг засах буюу гүүрэн шат тавьж, найдвартай бэхэлнэ.

676. Түр гарцын аюулгүй байдлыг хангах зорилгоор дамнуурга, гүүрэн дээр 0.9-1.2 м-ийн өндөртэй хашлагыг олс буюу ган татлагаар хийнэ.
677. Аврах олсны гогцоог нэрвэгдэгсдийн далнаас доогуур байрлуулна.
678. Аврах бүсний буулгах олсыг элэгдэлтийн байдлаас шалтгаалан солино.
679. Аврах шуудгийн татуургыг бат бэх зүйлд найдвартай бэхэлнэ.
680. Аврах ажилд автомеханик шат хэрэглэх бол энэ дүрмийн гуравдугаар бүлгийн 5 дах заалтыг баримтална.
681. Эрэн хайх, аврах ажиллагаа явуулахад хориглох зүйлс.
682. Тусгай бэхэлгээ хийхгүйгээр нурангийн доогуур гарц гаргах.
683. Нурсан барилга, байгууламжийн доторх өрөө тасалгаа, хонгилд хий үнэртэж байгаа үед тусгаарлагч баггүй ажиллах, гал гаргах, тамхи татах
684. Үзэгдэх орчин хязгаарлагдмал буюу шөнийн нөхцөлд гэрэлтүүлэх хэрэгслийг эвдэрч гэмтсэн барилга, байгууламжийн цахилгаан шугамаас тэжээх
685. Цахилгаан шугамыг солих, шалгах үед тусгаарлагч багаж, резин бээлий, гуталгүй ажиллах
686. Өргүүрийн даацыг хэтрүүлэн ачаа өргөх, шатаж байгаа барилга, байгууламжийн өрөө, тасалгааны хаалгыг гэнэт онгойлгох
687. Барилга байгууламжийн нурж болзошгүй хийцийн дэргэд олон хүн цуглуулж байрлуулах
688. Нурж болзошгүй хийцийг бэхэлж байгаа үед түүний ойролцоо автомашин, механизмаар ажиллах, хөдөлгөөн үйлдэх
689. Салхины хурд 20 м/с-ээс дээш байх үед автомеханик шат ашиглах.
690. Аврах багаж хэрэгслийг -20-оос +35 хэмд хадгална.
691. Өндөр даралтын шахуургын ажиллагаатай багаж хэрэгслийг сард 2-оос доошгүй удаа бүрэн ажиллуулж шалган бүртгэл хөтөлнө.
692. Аврах бүлэг дуудлагаар хүрэлцэж ирээд барилгын эрсдэлийг тооцож, хагарч цуурах эрсдэлтэй хэсгүүд дээр тэмдэг, тэмдэглэгээ тавина.

Зам тээврийн ослын үед аврах ажиллагаа явуулах үеийн аюулгүй ажиллагаа

693. Ослын нөхцөл байдлыг үнэлнэ. Үүнд:
- 693.1. Мөргөлдсөн байдал (урд, хажуу, шүргэлдсэн, саадыг мөргөсөн, тээврийн хэрэгслийн байрлал гэх мэт),
- 693.2. Нэрвэгдэгсдийн биеийн байдал,
- 693.3. Түлш, шатахуун болон химийн аюултай бодис алдагдсан эсэх,
- 693.4. Болзошгүй гал түймрийн эрсдэл байгаа эсэх.
694. Аврах ажиллагаа эхлэхийн өмнө осолдсон тээврийн хэрэгслийн хөдөлгүүрийг унтрааж, автомашины аккумуляторыг салгана. Шаардлагатай бол тэлэгч, механик ажиллагаатай багаж ашиглана. Аккумуляторыг салгахаас өмнө автомашины цонхыг онгойлгон суудлын байрлалыг өөрчилж хаалганы түгжээг салгана.
695. Автомашины зай хураагуурыг салгах боломжгүй тохиолдолд тэжээлийн залгуурын ойр орчмын цахилгааны утсыг тасална. Зай хураагуурыг салгах үед гал унтраагуурыг бэлэн байдалд байлгана.
696. Автомашиныг тогтворжуулахын тулд тусгай бэхэлгээний багаж хэрэгсэл, тулгуур, ивүүр, өргөгч, тулгуур хөл зэргийг ашиглана.

697. Зориулалтын бэхэлгээний хэрэгсэл байхгүй тохиолдолд гарын доорх материал (блок, тоосго, шургааг)-ыг ашиглаж болно.

Аврах ажиллагааны үеийн аюулгүй байдал

698. Нэрвэгдэгчийн амь насанд шууд аюул учруулахгүй байхын тулд тэдгээрт анхны тусламж үзүүлж ойр орчмын хог хаягдал болон машины эд ангийг холдуулсан дараа нэрвэгдэгчийг гаргана.

699. Аюулгүйн дэр ажиллагаас урьдчилан сэргийлэхийн тулд эхлээд дэр мэдрэгч дотор байрласан бие даасан тэжээлийн эх үүсвэрээс утсыг салгана.

700. Тоног төхөөрөмжийн ажиллагаа бүрэн бус аврах багаж, техник хэрэгсэл ашиглан ажиллагаа явуулахыг хориглоно.

701. Аврагч хүн нэг бүрийн тусгай зориулалтын хамгаалах хувцас хэрэглэлийг бүрэн гүйцэд зөв өмссөн байна.

702. Багаж хэрэгслийг зөвхөн зориулалт, техникийн үзүүлэлтэд нь тохируулан ажиллуулна.

703. Багаж хэрэгслийг тээврийн хэрэгслийн эд ангиудыг задлахад хөшүүрэг болгон ашиглахыг хориглоно.

704. Нэрвэгдэгчийг тээврийн хэрэгслээс гаргахын тулд хүч хэрэглэхийг хориглох бөгөөд эд ангийг бүрэн цэвэрлэсний дараа гаргана.

705. Осолдсон автомашиныг тогтворжуулах ажлыг гүйцэтгэхдээ дараах аюулгүй байдлыг мөрдөнө. Үүнд:

705.1. Осолдсон тээврийн хэрэгсэлд зөвхөн аврах ажиллагааны удирдагчийн заасан аюул багатай талаас очно.

705.2. Тээврийн хэрэгслийн тогтворгүй байдлыг алдагдуулах ивүүр тулгуурыг хөдөлгөхийг хатуу хориглоно.

705.3. Тогтворжуулах явцад аюулгүй байдлыг чанд мөрдөж тээврийн хэрэгслийг гэнэт хөдөлгөх, тогтвортой байдал алдагдахаас урьдчилан сэргийлнэ.

706. Аврах ажиллагааны үед аврагч боломжтой бол бусад шаардлагатай арга хэмжээг авахад (анхны тусламж үзүүлэх, химийн аюултай бодисын асгаралтыг зогсоох гэх мэт) бусдад саад болохгүй байхаар байрлаж ажиллана.

707. Ажиллагаа эхлэхээс өмнө ойр орчмын хүмүүст аюултай байж болзошгүй тул тэдгээрийн талаар урьдчилан сэрэмжлүүлэх мэдээллийг хүргэнэ.

708. Тусгай зориулалтын багаж хэрэгсэлтэй ажиллах үед дараах зааврыг дагаж мөрдөнө. Үүнд:

708.1. Аврагч бүр тусгай зориулалтын бээлий, нүдний шил, дуулга зэргийг өмсөж зүүсэн байна,

708.2. Багаж болон зүсэлт хийж байгаа объектын хооронд зогсохыг хориглоно,

708.3. Тээврийн хэрэгслийн тогтвортой байдалд тогтмол хяналт тавина,

708.4. Багажийн ажиллагаа болон түүний хөдөлгөөнд тогтмол хяналт тавина,

708.5. Хэрвээ таслагч аврагч болон бусдад аюултай чиглэлд хөдөлж байвал нэн даруй зогсоож анхны байрлалд нь буцааж, өөр газраас зүснэ,

708.6. Ихээхэн хэмжээний ган төмөр эсвэл бетон зүсэх тохиолдолд ирний тусгай зориулалтын хамгаалалттай байна,

708.7. Тээврийн хэрэгслийн дээвэр болон бусад хэсгүүдийн тулгуурыг тасалсан тохиолдолд зайлшгүй бэхэлгээ хийнэ,

708.8. Аврах ажиллагааны үед үүссэн нөхцөл байдал болон нэрвэгдэгчийн биеийн байдалд тогтмол хяналт тавьж ажиллана,

708.9. Тээврийн хэрэгслийн зүсэгдсэн төмөр хийцийн хурц ирмэг, шилний хагархайд зүсэгдэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор бүтээлэг тавина,

708.10. Багаж хэрэгслийг зөөвөрлөхдөө холболтын хоолой хэсгээс барихыг хориглоно.

Өндөр барилга, байгууламжаас аврах ажиллагаа зохион байгуулах үеийн аюулгүй ажиллагаа

709. Аврах дайралт хийхэд шаардлагатай хийцийг тодорхойлж барилга байгууламжид бэхэлгээ хийнэ.

710. Эрсдэгчийн байрлалын харалдаа аврах тавцанг бэлтгэж хашлага, хашаа, автомашин зэргийг холдуулах ажлыг цагдаагийн алба хаагчтай хамтран зохион байгуулна.

711. Бүлгийн даргын заавраар аврагчид хуваарьт байрлалаа эзэлж цагдаагийн алба хаагч эрсдэгчтэй ярилцлага эхлүүлээгүй тохиолдолд томилгоот аврагч ярилцлагыг эхлүүлнэ. Энэ үед аврагч болон ярилцагчийн хамгаалалтын бэхэлгээг бэлэн болгосон байна.

712. Ажиллагааны удирдагч аврах ажиллагааг бүрэн хяналтдаа авч, хяналт тавих, удирдан чиглүүлэх, биет дохио өгөх боломжит байршлыг эзэлж ажиллагааг удирдана.

713. Аврах ажиллагаа эхэлснээс хойш гар утасны дууг хаах бөгөөд ямар нэгэн гадны дуудлагад хариу өгөхийг хориглоно.

714. Цагдаагийн болон бусад холбогдох албан тушаалтантай хамтран аврах тавцанг ажиллагаанд бэлтгэж дэлгэх талбайн саадыг арилгана.

715. Цагдаагийн алба хаагчтай хамтран тогтоосон аврах ажиллагааны бүсэд хамгаалалт авхуулж, автомашины хөдөлгөөнд хяналт тавиулна.

716. Аврах шуудаг, 8-ийн тоо, карабин 6 ш, жумар 1 хос, гри гри, аврах олс 30 м 2 ш, баавгайн савар, олсны хамгаалалт, дан, цуваа ролик, хос ролик болон хүн нэг бүрийн хамгаалах хэрэгслийг биед тохируулан өмссөн байна.

717. Аврах ажиллагааны хамгаалалт бэхэлгээг хийж гүйцэтгэсний дараа бүлгийн даргын тушаалаар дайралтыг хийж, эрсдэгчид учрах аюулыг арилгана.

718. Өндөр барилга, байгууламжаас аврах ажиллагаа зохион байгуулах явцад аврагч бүлгийн даргын зөвшөөрөлгүй ямар нэгэн ажиллагаа хийхийг хориглоно.

Хүйтний улиралд гүний шумбалтын дадлага сургалт, цооног гаргах үеийн аюулгүй ажиллагаа

719. Дадлага, сургалт, аврах ажиллагаа хийх үед нуурын мөсний зузааныг сайтар шалгаж, хэмжилт хийх.

720. Мөсний хөрөөг ажиллуулахдаа зориулалтын хамгаалах хэрэгсэл /хамгаалалтын малгай, нүд хамгаалах хэрэгсэл, гар хамгаалах хэрэгсэл/ ашиглана.

721. Мөсний хөрөөг ажиллуулахдаа зориулалтын бус хэсгээс барихыг хориглоно.

722. Мөсний хөрөөний гинж тасрах болон шугам төмрийг давах эрсдэлээс сэргийлж, тогтмол үзлэг шалгалт хийх.

723. Мөсний хөрөөг ажиллуулахдаа хамгаалах тусгай хувцас, аврах хантаазыг зайлшгүй өмссөн байна.

724. Шумбалт хийхийн тулд 3х3 метрийн хэмжээтэй гурвалжин цооног бэлтгэж, хатуу мод, модон материалаар хашлага, хүрээг сайтар хийж бэхэлсэн байна.

725. Цооногт 2-оос илүүгүй алба хаагч ажиллана.

726. Мөсийг хөрөөдөж шоо хэлбэртэй татаж гаргана.

727. Цооногоос мөсийг гаргах үед алба хаагчид аюулгүй байдлыг бүрэн хангаж, аврагчид бэхэлгээ хийсэн байна.

728. Мөсийг хөрөөдөж дуусмагц хөрөөг бүрэн унтраасны дараа, дараагийн ажиллагаанд шилжих.

729. Цооногийн ирмэгээс 2 метр дотор аврах хантаазгүй алба хаагчид явахыг хориглоно.

730. Гүний шумбалтын дадлага сургалт, аврах ажиллагаа явагдаж дууссаны дараа цооногийг тойруулан аюулгүйн зурвас татаж, анхааруулах тэмдэг байршуулах

731. Мөсний хөрөөг зориулалтын бус зүйлд ашиглахыг хориглоно.

Их цас, зуд, хүчтэй салхи, шуурганы үед ажиллах аюулгүй ажиллагаа

732. Холбооны болон гэрэлтүүлэх хэрэгсэл, орон байр, дулаан хувцас, эм багаж хэрэгсэл, хоол хүнс, түлш зэрэг шаардлагатай бусад зүйлийг бэлтгэсэн байна.

733. Ажил үүрэг гүйцэтгэж байгаа бие бүрэлдэхүүн нь цаг агаарын мэдээг хүлээн авч үйл ажиллагаандаа мөрдлөг болгоно.

734. Цасанд дарагдсан газар орны байдлыг урьдчилан судалж, зам гарц гаргах, явах чиглэлийг заах, аюултай газрыг тэмдэглэнэ.

735. Хүчтэй салхи, цасан болон шороон шуургатай үед ажиллаж байгаа бие бүрэлдэхүүн нь салхинд хийсэх, төөрөхөөс болгоомжилж, тусгайлан бэлтгэсэн уяа, бэхэлгээг хэрэглэхээс гадна холбоо, дохиоллын хэрэгслийг ашиглана.

736. Хүчтэй салхи, шуургатай үед гэр, хашаа, саравч, барилга байгууламж нурж эвдэрснээс мод, чулуу, тоосгонд цохиулан гэмтэж бэртэхээс сэргийлж, байрлах газраа зөв сонгож авна.

Үер, усны аюулын үед ажиллах аюулгүй ажиллагаа

737. Үер, усны аюулын үед ашиглах, аврах цагариг, аврах хантааз, усны олс, ~~саваа~~, усны нүдний шил, усны хувцас, хөлийн нэмэлт сэлүүр, бортого зэрэг уснаас эрэн хайх, аврах ажиллагааны тоног төхөөрөмж, багаж, хамгаалах тусгай хувцас хэрэгслийг мэргэжлийн байгууллагаар шалгуулан баталгаажуулсан байна.

738. Ажил үүрэг гүйцэтгэхийн өмнө усчин-аврагчид нь эмчийн үзлэгээр орж, биеийн эрүүл мэндийн талаар дүгнэлт гаргуулсан байна.

739. Аврах ажил эхлэхийн өмнө тухайн гол мөрөн, нуур цөөрмийн усны түвшин, гүн, хэм, урсгалын хурд, усны таталт, эргүүлэг, эрэг орчмын байдал, цаг агаарын нөхцөлийг сайтар судална.

740. Усан доторх мод, чулуу, лаг зэргийг шалгаж судлах.

741. Уснаас аврах ажиллагааг 3-аас доошгүй хүнтэй багаар бүрдүүлж нэг нь усанд эрэл хийж байхад үлдсэн хүмүүс нь аврагчийн аюулгүй байдлыг хангаж ажиллана.

742. Уснаас аврах эрэл хийж байгаа аврагчид нь нэг ээлжид хоёроос гурван удаа 3-5 метрийн гүнд шумбах эсвэл 10-15 метрийн зайд усан доогуур сэлэлт хийсний дараа 20-30 минут амарч, дулаацаж болно.

743. Бортого бүрэн цэнэгтэй, хангалттай агаар байгаа эсэхийг даралтын заалтаар шалган амьсгалын бие даасан төхөөрөмж хэвийн ажиллах даралтыг зөв хуваарилж байгаа эсэхийг усанд орохын өмнө шалгана.

744. Бортогыг цэнэглэхдээ даралтын дээд хэмжээнд хүргэхгүй, бага зэрэг дутуу цэнэглэх ба ашиглах цаг хугацааг минутаар тогтоон, усан дор ажилласан хугацааг тооцож, бортогыг 4-8 минут ажиллуулах агаарын нөөцтэй байлгаж дахин цэнэглэнэ.

745. Усны хувцсыг усны хэм 0-ээс +22 байхад хэрэглэнэ.

746. Аврах сэлэлт хийх тохиолдолд усны хэмээс шалтгаалж усанд байх хугацааг тогтооно. Үүнд:

Усны градус	Усанд байх хугацаа / мин/
+5	1-2
+10	2-4
+15	4-6
+20	6-12
+25	12-30

747. Усны хувцастай шумбах үед усны хэмээс шалтгаалан усанд байх хугацааг өөрөө тогтоож, даарч эхлэх шинж тэмдэг мэдэгдвэл уснаас гарна.

748. Мөстэй ус буюу мөс цөмөрсөн үед урт модон шат, банз, шургааг зэрэг аль болох талбай ихтэй, даралт багатай зүйлийг ашиглан аврагч нь хэвтээгээр буюу мөлхөөгөөр дөхөн очиж хөвөгч цагариг, аврах олс, саваа модыг өгнө. Талбай ихэсгэх зүйл олдохгүй тохиолдолд хэвтээгээр мөлхөн хөл, гараа аль болох алдлан тенийлгэж дарах талбайг ихэсгэнэ.

749. Тогтмол ус, нуур, цөөрөмд унасан хүн ёроолд нь байгаа тохиолдолд талбай ихтэй аврах хэрэгсэл, усны хувцас, бортого, нүүрэвч хэрэглэн аврагчийг аврах олсоор бэхлэн оруулан аврах ажлыг гүйцэтгэнэ.

750. Аврах ажлын дараа өмсөх дулаан хувцас, дулаацах гэр, майхан, халуун хоол, цай зэрэг зүйлийг бэлтгэсэн байна.

751. Усчин аврагчдыг бэлтгэх дадлага, сургуулийг хийхдээ дор дурдсан журмыг баримтална.

752. Гол, нуур, цөөрмийн усанд тусгайлан бэлтгэсэн хэсэгт усанд сэлэх дадлага, сургуулийг хийнэ.

753. Сургууль, дадлага хийх үед 2-3 хүнийг жижүүрээр томилох ба аврах хэрэгсэл, завиар хангана.

754. Усанд сэлэх дадлагыг зуны улиралд явуулах бөгөөд агаарын дулаан +20 хэмээс доошгүй байвал зохино.

755. Усны мандал дээгүүр олсон буюу ган татлага татаж голын эрэгт бэхэлсэн байна.

756. Усанд сэлж байгаа үед ухаан балартах хөл гарын булчин зангирч татах шинж тэмдэг илэрвэл нэн даруй эрэг рүү буцах буюу тусламж дуудна.

757. Дадлага сургууль хийж сэлж байгаа үед 1 аврагч аюулгүй байдлыг нь ханган давхар сэлнэ.

758. Хэсэг бүлгийн даргын өгсөн үүрэг, тогтоосон замаас гажих, завины даац хэтрүүлэх, тусгай зориулалтын хувцас, багаж хэрэгсэлгүйгээр усан орчинд ажиллахыг хориглоно.

759. Аврах ажиллагаанд цоорхой завь, богино олс, урагдаж гэмтсэн хөвөгч хантааз зэрэг шаардлага хангахгүй хэрэгсэл ашиглахыг хориглоно.

760. Урагдаж цоорсон усны хувцас өмсөхийг хориглоно.

761. Эрэн хайх ажиллагааны үед аль нэг багаж хэрэгсэл гэмтэх, биеийн байдалд ямар нэгэн өөрчлөлт орох үед аврах ажиллагааг даруй зогсоож яаралтай арга хэмжээ авна.

762. Бортогоны даралт унах, амьсгалын тэжээгч дутуу ажиллах, хийн тохиргоо алдагдах зэрэг гэмтэл гарвал уг бортогыг ашиглахыг хориглоно.

763. Шумбалт хийж байгаа үед бортогоны даралт унах, амьсгалын тэжээгч дутуу ажиллах үед уснаас шууд гарах.

764. Гол мөрний мөс цөмөрч усанд унасан хүний хойноос мөсөн доогуур орж аврах ажил хийхийг хориглоно.

765. Аврагч завинд үсэрч сууж болохгүй ба нэг нэгээрээ орж жигд тарж суух бөгөөд явж байгаа үед зогсож явахыг хориглоно.

Хүн, малын гоц халдварт өвчин гарсан үед ажиллах аюулгүй ажиллагаа

766. Бие бүрэлдэхүүн нь ажил үүрэг гүйцэтгэх үедээ хорио цээрийн бүсэд тогтоосон горимыг дагаж мөрдөнө.

767. Хүн, малын гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх эм уух буюу тарилга хийлгэнэ.

768. Халдварын голомтод үүрэг гүйцэтгэх үедээ нэг бүрийн хамгаалах хэрэгсэл, тусгай зориулалтын өмсгөлтэй ажиллана.

769. Ажил дууссаны дараа тусгайлан бэлтгэсэн буюу ажлын байрыг халдваргүйжүүлсний дараа хамгаалах хувцас, өмсгөлийг тогтоосон дарааллыг баримтлан тайлж, ариутгах уусмалаар цэвэрлэнэ.

770. Халдварын голомтод ажиллах үед болон түүний дараа хувийн ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлагыг өдөр бүр нарийн чанд сахина.

771. Хүн, мал амьтныг эмчлэх халдвар бүхий мал түүний сэг зэмийг устгах, нас барсан хүний шарилыг оршуулах, ачиж буулгах зэрэг ажилд оролцох үед хамгаалах хувцас өмсгөл хэрэглэх, ариутгал халдваргүйжүүлэлтийг дууссаны дараа хамгаалах хувцас хэрэгслийг мэргэжлийн байгууллагын зааврын дагуу устгал хийж тусгайлан бэлтгэсэн байр талбайд халдваргүйжүүлэлт хийлгэнэ.

772. Хамгаалах хувцас, өмсгөлгүйгээр хүн, малын гоц халдварт өвчний сэжигтэй буюу нас барсан хүн, ялаа, шумуул, шавж, мэрэгч амьтад, малын сэг зэмд гар хүрэх, оролдох, малын арьс, махыг хүнсэнд хэрэглэхийг хориглоно.

773. Бохирлогдсон тусгай зориулалтын өмсгөл, хүн нэг бүрийн хамгаалах хэрэгсэл болон багаж, техник, тоног төхөөрөмжийг дахин ашиглах, ариутгалгүйгээр орхих, зориулалтын битүү саванд хадгалаагүй эм, бэлдмэл, ороох боох материал хэрэглэхийг хориглоно.

774. Ажиглалт, хорио цээрийн бүсэд байгаа усны эх булаг, бүх төрлийн хүнсний бүтээгдэхүүнийг бактериологийн шинжилгээгүйгээр хэрэглэхийг хориглоно.

Цацрагийн ослын үед ажиллах аюулгүй ажиллагааны зааварчилгаа

775. Цацрагийн ослын үед ослын голомтод үүрэг гүйцэтгэх бие бүрэлдэхүүнд тухайн цацраг идэвхт бодисын шинж чанар, зөвшөөрөгдөх хэмжээ, хамгаалах арга, хор уршгийг арилгах үйл ажиллагааны тухай мэдээллийг танилцуулсан байна.

776. Цацрагийн ослын голомтод үүрэг гүйцэтгэх бие бүрэлдэхүүний аюулгүй байдлыг хангах төлөвлөгөөг боловсруулан ажиллах хугацаа, цацраг идэвхт материалтай харьцах зай, ээлж солих дарааллыг мэргэжлийн байгууллагаар тогтоолгосон байна.

777. Ослын голомтод үүрэг гүйцэтгэхийн өмнө ашиглах багаж хэрэгсэл, цэвэрлэгээ ариутгалын бодис, уусмал, хамгаалах хэрэгслийн иж бүрдэл, бэлэн байдлыг шалгана.

778. Цацрагийн ослын цагийн байдлыг үнэлж хязгаарлалтын бүс тогтоож анхааруулах тэмдэг тавих ба цацрагийн ослын голомтод 2-оос дээш хүн ажиллах бөгөөд хордолтын бүсийн гадна байгаа хүнтэй харилцах холбоо, дохиог тогтоосон байна.

779. Цацраг идэвхт материалтай харьцаж ажиллахад зориулалтын хүн нэг бүрийн хамгаалах хэрэгслийг зааврын дагуу бүрэн хэрэглэсэн байх.

780. Багаж тоног төхөөрөмж, техник хэрэгслийн бэлэн байдал, бүлгийн бие бүрэлдэхүүний үүрэг гүйцэтгэх ажиллагааг тухайн ажиллагааны удирдагч нэг бүрчлэн хянаж шалгана.

781. Хувийн дозиметрийг тогтмол зүүж, цацрагийн бохирдолтой бүсэд ажилласан цагийн бүртгэлийг тогтмол хөтөлнө.

782. Дозиметрийг хэрэглэхдээ дараах зааврын дагуу хэрэглэнэ.

783. Тусгай цэвэрлэгээний бүлгийн бие бүрэлдэхүүн мэргэжлийн байгууллагаас баталгаажуулсан бүртгэл бүхий дозиметрийг, зориулалтын дагуу хэрэглэх

784. Дозиметрийн код бүхий нүүрийг бие рүүгээ харуулан хэрэглэх

785. Дозиметрийг хор уршгийг арилгах ажиллагааны туршид шарлагад их хэмжээгээр өртөж болзошгүй биеийн хэсэгт зүүх

786. Хүн нэг бүрийн хамгаалах хувцас хэрэглэсэн тохиолдолд дозиметрийг хамгаалах хувцасны дотор талд зүүж хэрэглэх

787. Дозиметрийг бусдад шилжүүлэх, бохирдолтой бүсээс бусад орчинд хэрэглэхийг хориглох

788. Ослын голомтод хүн нэг бүрийн хамгаалах хувцас хэрэглэлгүй нэвтрэхийг хориглоно.

789. Хүн нэг бүрийн хамгаалах хувцас хэрэглэлийг зөвшөөрөлгүй, зориулалтын бус газар тайлахыг хориглоно.

790. Цацрагийн дотоод шарлагаас сэргийлж цацрагийн бохирдолттой орчинд хоол хүнс, тамхи, гоо сайхны зүйлс болон ажилд хамаарахгүй бусад зүйлс хэрэглэхийг хориглоно.

791. Цацрагийн хяналтын ажилтны зөвшөөрөлгүй тогтоосон бүсэд нэвтрэх, бүсээс гарахыг хориглох.

792. Ажиллагааны удирдамжид тусгаагүй бол бусад дээж, эд зүйлс, багаж тоног төхөөрөмжид хүрэхийг хориглох.

793. Тогтоосон бүсээс гарах зайлшгүй тохиолдолд цацрагийн хэмжилт хийлгэх.

794. Цацрагийн ослын голомтод ажилласан алба хаагч хязгаарлах бүсээс гарахдаа хүн нэг бүрийн хамгаалах хэрэгслийг тайлахдаа дараах дарааллыг баримтална.

794.1. Хамгаалах бээлийг дотор талыг эргүүлэх хэлбэрээр тайлах,

794.2. Хамгаалах цээж өмсгөлийг дотор талыг эргүүлж сэгсрэхгүйгээр тайлах,

794.3. Хамгаалах өмдийг тайлах,

794.4. Амьсгал хамгаалах хэрэгслийг тайлах,

794.5. Бохирдсон хамгаалах хувцас хэрэгслийг тусгай саванд хийж битүүмжлэх,

794.6. Хамгаалах оймс, гутлыг ээлжлэн тайлж, цацрагийн хэмжилт хийлгэх,

794.7. Цацрагийн бохирдол илрээгүй тохиолдолд хязгаарлах бүсээс гарах.

Химийн ослын үеийн аюулгүй ажиллагаа

795. Химийн ослын үед ослын голомтод үүрэг гүйцэтгэх бие бүрэлдэхүүнд тухайн тухайн химийн бодисын хими, физикийн шинж чанар, хүнд үзүүлэх сөрөг нөлөө, зөвшөөрөгдөх хэмжээ, хамгаалах арга, хор уршгийг арилгах үйл ажиллагааны тухай мэдээллийг танилцуулна.

796. Химийн ослын тохиолдсон газар орны байршил, цаг агаарын нөхцөл байдал, химийн хорт болон аюултай бодисын төрөл, тархалтын байдлыг тодорхойлж, тусгай цэвэрлэгээний бүлгийн даргаас ямар хамгаалах хэрэгсэлтэй, хэдий хугацаанд үүрэг гүйцэтгэх, ээлж солих дарааллын талаар тогтоосон журмыг баримтлан ажиллана.

797. Химийн ослын дуудлага хүлээн авмагц тусгай цэвэрлэгээний бүлгийн дарга, ахлах даргын өгсөн үүргийн дагуу бүлгийн бие бүрэлдэхүүний нэг бүрийн хамгаалах хувцас, хэрэгсэл, тусгай зориулалтын багаж, техникт үзлэг, шалгалт хийж бэлэн байдлыг хангана.

798. Химийн ослын үед тохиолдож болзошгүй гэнэтийн аюулаас урьдчилан сэргийлэх аюулгүй байдлыг хангах зорилгоор явганаар болон автомашинтай эргүүлийг тодорхой маршрутаар, аюулгүйн бүсүүдэд орох, гарах замд шалган нэвтрүүлэгчийг томилон ажиллуулна. Шалган нэвтрүүлэгч, эргүүлийн тоо, эргүүл хийх цэг, хөдөлгөөн үйлдэх маршрут, хоорондын зай, хугацааг тусгай цэвэрлэгээний бүлгийн дарга тогтооно.

799. Химийн ослын хор уршгийг арилгах ажиллагааны үед өдөр, шөнийн цагт харагдахуйц зөөврийн анхааруулах, сэрэмжлүүлэх тэмдэг, тэмдэглэгээг аюулын бүсэд байршуулсан байна.

800. Химийн хорт болон аюултай бодистой харьцах, ослын голомтод хор уршгийг арилгах ажиллагаанд оролцохын өмнө аюулгүйн ажиллагааны заавартай танилцаж, гарын үсэг зурсан байна.

801. Химийн ослын голомтод үүрэг гүйцэтгэх, химийн бодистой харьцаж ажиллахад хүн нэг бүрийн хамгаалах хэрэгслийг зааврын дагуу бүрэн хэрэглэсэн байна.

802. Үзэгдэх орчин хязгаарлагдмал, агааргүй, хорт хийтэй орчинд аврах, хор уршгийг арилгах үйл ажиллагаа явуулахдаа тусгаарлагч багтай 4-оос доошгүй хүний бүрэлдэхүүнтэй хэсгийг ажиллуулна.

803. Хэт өндөр халуун, чийгшил ихтэй нөхцөлд аврах, хор уршгийг арилгах үйл ажиллагаа явуулах үед чийглэг, градусыг бууруулах, алба хаагчдыг дулаанаас хамгаалах хувцас хэрэгслээр хангана.

804. Хэт хүйтэн нөхцөлд аврах, хор уршгийг арилгах үйл ажиллагаа явуулах үед тоног төхөөрөмжийн хэвийн үйл ажиллагааг хангах, алба хаагчдыг хүйтнээс хамгаалах хувцас хэрэгслээр хангана.

805. Амьсгалын бие даасан төхөөрөмжийн агаар хадгалах сав дүүрэн цэнэгтэй байна. Аврагч-химичдийн тусгаарлагч багтай ээлжид ажиллах хугацаа нь багны хүчин чадлаас шалтгаалах бөгөөд үүрэг гүйцэтгэх хугацааг хамгийн багаар тооцно.

806. Амьсгалын бие даасан төхөөрөмжтэй алба хаагч тус бүр нэг нөөц шүүгч багийг биедээ авч явна.

807. Аврагчийг ослын голомтод нэвтрэхээс өмнө нэг бүрийн хамгаалах хэрэгслийн бүрэн бүтэн байдал, зааврын дагуу зөв өмссөн эсэхийг шалгаж ослын голомтод орсон цаг, гарах цагийг тэмдэглэн бүлгийн даргаас тогтоосон хугацаа болон амьсгалын бие даасан төхөөрөмжийн хүчилтөрөгчийн нөөц дуусахаас өмнө алба хаагчийг ослын голомтоос гаргана.

808. Үүрэг гүйцэтгэх явцад хордолтын шинж тэмдэг илрэх, багаж хамгаалах хэрэгсэл эвдрэх, гэмтсэн тохиолдолд бүлгийн ахлагчид мэдэгдэж хордолтын бүсээс гарна.

809. Хордолтын бүсээс гарч тухайн орчинд химийн бодисын хордолтыг шалгасны дараа тусгайлан заасан газар хамгаалах хэрэгсэл, багажийг цэвэрлэн ариутгаж, шалгаж зохих журмын дагуу тайлна.

810. Химийн хорт болон аюултай бодисыг ачих, буулгах, тээвэрлэх үйл ажиллагааг гүйцэтгэх алба хаагч тухайн химийн бодисын шинж чанар, хор аюулын лавлах мэдээлэлд үндэслэн хэрхэн харьцах талаар зааварчилгаа авч, хүн нэг бүрийн хамгаалах хэрэгслээр хангагдсан байна.

811. Химийн бодис тээвэрлэх тээврийн хэрэгсэл дээр “химийн хорт болон аюултай бодисын шошго, анхааруулах тэмдэг” стандартад заасан анхааруулах тэмдгийг стандартад заасан байрлалд байрлуулсан байна.

812. Химийн бодисыг хүн, мал, амьтан болон өөр бүтээгдэхүүнтэй хамт тээвэрлэхийг хориглоно.

813. Химийн бодис тээвэрлэсэн тээврийн хэрэгслийг сайтар цэвэрлэнэ.

814. Химийн бодисыг тээврийн хэрэгсэлд ачихад дараах шаардлагыг мөрдөнө.
Үүнд:

814.1. Тээвэрлэлтийн явцад сав баглаа боодолтой бодисын байрлал өөрчлөгдөж унаж, асгарахгүй байхаар савлагдаж бэхлэгдсэн, жигд тархалттайгаар байршсан байна.

814.2. Том овортой сав баглаа боодолтой бодисыг тээврийн хэрэгсэлтэй бат бөх бэхэлсэн байх ба шингэн бодисын хувьд хазайх, тойрох үед тэнцвэр хадгалагдаж байхаар савлагааны дүүргэлтийг тохируулсан байна

814.3. Химийн бодисыг ачихдаа хэрэв чиглэл заасан тэмдэглэгээтэй бол уг тэмдэглэгээний сумны чиглэлийг дээш нь харуулж, хэрэв байхгүй бол амыг дээш харуулж байрлуулна.

814.4. Химийн бодисыг хор аюулын лавлах мэдээлэлд заасан нөхцөлд тээвэрлэх ба хамт хадгалж болохгүй бодистой хамт тээвэрлэхийг хориглоно.

814.5. Агаар хадгалах цэнэгтэй савыг хөдөлгөөнгүй бэхэлж тээвэрлэх ба тээвэрлэлтийн үед бортогоны хавхлаг гэмтэхгүй, нарны гэрэл шууд тусаж халахгүй байх нөхцөлийг хангасан байна.

814.6. Өөрөө урвалд ордог бодис, органик хэт ислийг ачааны чингэлэг эсвэл битүү чингэлэгтэй тээврийн хэрэгслээр, нарны гэрэл шууд тусахгүй, аливаа халалтын эх үүсвэрээс хол, сайн агааржуулалттай нөхцөлд тээвэрлэнэ.

814.7. Гэмтсэн, бүрэн бус ажиллагаатай сав баглаа, боодол бүхий химийн хорт болон аюултай бодисыг дур мэдэн засварлах, оролдох, ачих, тээвэрлэхийг хориглоно.

814.8. Зөөх, ачих буулгахдаа 2 дугуйтай зориулалтын тэргэнцэр буюу дамнуурга ашиглах, доргиох, зайлагдах зэрэг эсрэг үйлчилгээ үзүүлж болохгүй.

815. Тээвэрлэлтийг зөвхөн өдрийн цагаар хийх бөгөөд химийн бодис тээвэрлэгч тээврийн хэрэгслийн хурдыг 50 км/цаг-аас хэтрүүлэхгүй.

816. Химийн бодисыг цуваагаар тээвэрлэх тохиолдолд тээврийн хэрэгслийн хоорондын зай 50 метрээс багагүй байна.

817. Химийн хорт болон аюултай бодис ачсан тээврийн хэрэгслийн жолооч бүлгийн даргын өгсөн зааврын дагуу тодорхой хугацаанд эсвэл тодорхой зайнд ачааны бүрэн бүтэн байдлыг шалгана.

818. Химийн бодис ачсан тээврийн хэрэгсэлд хүн нэг бүрийн хамгаалах хэрэгсэлтэй 1-2 хүн сууж явах ба тамхи татах, гал гаргахыг хориглоно.

Тэсэлгээний ажлыг гүйцэтгэх үеийн аюулгүй ажиллагаа

819. Тэсэрч, дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэлтэй, тэсэлгээний ажил хийх, ослын үр дагаврыг арилгаж байгаа алба хаагч дараах зүйлийг хийх шаардлагатай.

819.1. Тэсэрч, дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн тухай онолын болон дадлага, сургалт зохион байгуулсан байх.

819.2. Тэсэрч, дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэлтэй харьцах дадлага, сургалтад хамрагдаагүй, мэргэжлийн бус алба хаагчаар тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгсэлтэй харьцах, тэсэлгээний ажил хийх ажил хийлгэхгүй байх.

819.3. Тэсэрч, дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэлтэй харьцах, тэсэлгээний ажил хийх, ослын үр дагаврыг арилгахын өмнө аюулгүйн ажиллагааны заавар танилцуулж гарын үсэг зуруулсан байх.

819.4. Тэсэрч, дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэлтэй харьцах, тэсэлгээний ажил хийх үед энэхүү зааврыг чанд сахиж, гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх шаардлагатай арга хэмжээ авсан байх.

819.5. Тэсэрч, дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэлтэй харьцаж байгаа алба хаагчид аюулгүйн зай хэмжээг сайтар мэдсэн байх.

819.6. Тэсэрч, дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэлтэй харьцах, ослын үр дагаврыг арилгах үед өдөр, шөнийн цагт харагдахуйц зөөврийн тэмдэг, тэмдэглэгээг аюулгүйн бүсэд байршуулсан байх.

819.7. Тэсэрч, дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэлтэй харьцах, тэсэлгээний ажил хийх, ослын үр дагаврыг арилгах үед тохиолдож болзошгүй аюулаас урьдчилан сэргийлэхийн тулд харуулыг тухайн газар оронд зохион байгуулах.

819.8. Харуул байрлуулах газар, тэдгээрийн зай, хугацаа, буулгах шийдвэрийг удирдагчаас тогтоосон байх.

819.9. Харуул нь үйл ажиллагаа явагдаж байгаа газарт удирдагчийн зөвшөөрөлгүйгээр хүн, автомашин, техникийг нэвтрүүлэхгүй байх.

819.10. Тэсэлгээний ажил хийх үед тэсрэлтээс ялгарах хорт хий, тоосноос хүн хордохоос урьдчилан сэргийлэх арга хэмжээ авсан байх.

819.11. Тэсэрч, дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэлтэй харьцах, тэсэлгээний ажил хийх, ослын үр дагаврыг арилгасны дараа нотломж үйлдэх.

819.12. Тэсэрч, дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн үзлэг, хайгуул хийсний дараа нотломж үйлдэх.

820. Тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгсэлтэй харьцах, тэсэлгээний ажил хийх, ослын үр дагаврыг арилгах үед дараах зүйлсийг хориглоно.

820.1. Аюулгүй байдлыг хангахгүйгээр тэсэлгээний ажил явуулах,

820.2. Тэсрэх материал хадгалах байранд гаднын хүн нэвтрэх,

820.3. Тэсэрч, дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэлтэй харьцаж байгаа газраас 100 метрээс дотогш зайд ил гал гаргах, тамхи татах,

820.4. Тэсэрч, дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэлтэй харьцахдаа чүдэнз болон бусад оч үүсгэх хэрэгсэл авч явах,

820.5. Тэсэрч, дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн хайрцаг савыг ачиж, буулгахдаа цохиж доргиох, шидэх,

820.6. Тэсэлгээний хэрэгслийг халаасанд хийж явах,

820.7. Тэсэлгээний хэрэгслийг тэсэрч, дэлбэрэх бодистой хамт хадгалах болон тээвэрлэх,

820.8. Цахилгаан тэсрүүлэгч (электрон-детанатор)-тэй харьцах үед түүний утаснаас татах,

820.9. Тэсэлгээний хэрэгсэл (Капсюль-детанатор)-ийн үүрэнд хадаас болон иртэй зүйл хийх,

820.10. Тэсэлгээний хэрэгсэл (Капсюль-детанатор)-ийг салхины өөдөөс харуулах,

820.11. Дарь хадгалж байгаа агуулах, байранд төмөр ул, өсгий, тах, хадаастай гуталтай явах,

820.12. Тэсэрч, дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийг дур мэдэн оролдох, бусдад дамжуулах, өөр зорилгоор ашиглах, нуун дарагдуулах,

820.13. Харуулд гарсан алба хаагчид давхар ажил хариуцуулах,

820.14. Дуу цахилгаантай бороотой үед галаар болон цахилгаанаар тэсэлгээ хийх.

Тэсэрч, дэлбэрэх бодисын агуулахад гарсан ослын үед авч хэрэгжүүлэх аюулгүйн ажиллагаа

821. Тэсрэх материалын агуулахад орохдоо зориулалтын хувцас, амьсгалын бие даасан төхөөрөмж хэрэглэнэ.

822. Аюултай бүсийн ойр орчимд байгаа хүн, мал, автомашин, техник, эд зүйлсийг гаргаж гаднаас ирэх хөдөлгөөнийг хязгаарлана.

823. Ослын голомтод ойр, зэрэгцээ агуулахаас тэсрэх бодис болон тэсэлгээний хэрэгслийг аюулгүй болгож зөөвөрлөх үед тэдгээртэй болгоомжтой харьцаж шидэх, унагах, цохиж, болохгүй.

824. Хор хөнөөлийн хүчин чадлыг бууруулах ажлыг гүйцэтгэж байгаа алба хаагчдаас бусад шаардлагагүй хүмүүсийг аюултай бүсэд нэвтрүүлэхгүй.

Тэсэлгээний ажил хийх үеийн аюулгүйн ажиллагаа

825. Тэсэлгээний ажил хийхийн өмнөх үед:

826. Тэсэлгээний бүх үйл ажиллагаа нь тэсэлгээний ажлын удирдагч (цаашид “Удирдагч” гэх)- ийн нэгдсэн дохиогоор зохион байгуулалттай хийгдэнэ.

827. Удирдагч нь тэсэлгээ хийх газрын байрлалыг урьдчилан сонгоно.

828. Аюулгүй ажиллагааны зааврын шаардлагыг хангасан газар, нөхцөлд тэсэлгээний ажил хийнэ.

829. Тэсэлгээний ажил хийх газарт тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл хадгалах түр агуулах тус тусад нь байгуулна.

830. Хээрийн түр агуулахад тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгслийг гүнзгий ухсан нүхэнд хадгалах ба дээгүүр нь хучлага хийнэ. Шороон далангийн зузаан нь 20-25см байна.

831. Удирдагч нь тэсэрч, дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийг олгоход өөрийн биеэр хяналт тавина.

832. Гал дамжуулах шижмийг мушгихыг хориглоно.

833. Тэсэлгээний хэрэгслийг үйлдвэрийн сав, баглаа, боодолтой, эсхүл тусгай зориулалтын тэсэлгээчний цүнхэнд хийж авч явна.

834. Тэсэрч, дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийг түр агуулахаас тэсэлгээ хийх газарт удирдагчийн хяналт дор аюулгүйн арга хэмжээг сахиж зөөнө.

835. Хэрэв задгай талбай дээр тэслэх бол түүний цохилтын долгионы үйлчилгээ, хэлтэрхий шидэгдэх аюулгүй зайг тодорхойлно.

836. Тэсэлгээний ажил хийх үед байгалийн далдлалт байхгүй тохиолдолд аюулгүйн нуувч бэлтгэнэ.

837. Тэсэлгээ хийх үед анхааруулах дуут болон гэрлэн дохио заавал өгнө.

838. Харуул нь тэсэлгээ хийж байгаа газарт хүн, мал, автомашин, техник харагдсан тохиолдолд тэсэлгээний удирдагчтай шуурхай холбоонд орж тэсэлгээний ажлыг зогсооно.

Галын аргаар тэсэлгээ хийх үед

839. Удирдагчаас гал дамжуулах шижмийг хүлээн авмагц түүний асалтын хэвийн хурдыг шалгаж хугацааг тодорхойлно.

840. Удирдагчаас өгсөн тусгай дохио, шийдвэрээр гүйцэтгэнэ. Галын аргаар цэнэгүүдийг дэлбэлэхдээ дараах дохиог хэрэглэнэ. Үүнд:

840.1. “Бэлтгээд” дохиогоор тэсэлгээ хийхээр томилогдсон тэсэлгээчин цэнэгийн дэргэд зогсож шатаах яндангийн чөлөөтэй үзүүрийг асаахад бэлтгэнэ. Удирдагч нь энэ дохиог өгөхийн өмнө тэсэлгээний орчинд томилогдсон харуулыг байрандаа байгаа эсэхийг шалгана.

840.2. “Галла” дохиогоор тэсэлгээчин шатаах янданг асаана.

840.3. “Зайлаад” дохиогоор тэсэлгээчин тэсэлгээний талбайгаас яаралтай зайлна.

840.4. “Дуусгаад” дохиог удирдагч нь тэсэлгээ хийсэн газрыг шалгасны дараа өгнө.

841. Тэсэрч, дэлбэрэх бодис ба асаах янданг тусад нь зөөвөрлөнө.

842. Тэсрүүлэгч (капсюль-детенатор)-ийн амсрыг салхины өөдөөс харуулахыг хориглоно.

843. Асаах янданг зөвхөн цэнэгт тавихын өмнө тэсэлгээчинд олгоно.

844. Ил цэнэг буюу цочир дамжуулах шижмийг чулуу, хайрга зэрэг хүнд зүйлээр дарж хучихыг хориглоно.

845. Баарсан цэнэг байгаа эсэхийг шалгахын тулд дэлбэрэлтийн тооцоог нарийн хөтөлнө. Тэсэлгээчин тэсэрч байгаа цэнэгийг тоолно.

846. Тооцоо ёсоор дэлбэрэлт болоогүй бол 15 минутын дараа тэсэлгээ хийсэн талбайд очно.

847. Баарсан цэнэгийг очиж шалгахдаа гал дамжуулах шижим нь асаж байгаа эсэхийг алсаас хянана.

848. Асаах яндангаар цэнэгийг дэлбэлэхдээ хоорондын зай, холдох зайг сайтар мэдэх.

849. Ассан боловч гүйцэд шатаагүй гал дамжуулах шижмийг дахин асаахыг хориглоно.

850. Тэсэлгээний үед бусад хүмүүсийг аюулгүйн бүсэд гаргасан байна.

Цахилгааны аргаар тэсэлгээ хийх үед

851. Цахилгаан тэсрүүлэгчтэй харьцаж байгаа хүний хувцас нь цахилгаан цэнэг хуримтлуулдаггүй материалаар хийгдсэн байна.

852. Тэсрэх бодис, цахилгаан тэсрүүлэгч (электрон-детонатор)-ыг тус тусад нь авч явна.

853. Цэнэгүүдэд цахилгаан тэсрүүлэгч (электрон-детонатор) тавих ажил дуусаагүй, хүмүүсийг аюулгүйн бүсэд гарч далдлалтад орохоос өмнө цахилгаан гүйдэл үүсгэгчид цахилгаан дамжуулах утсыг холбохыг хориглоно.

854. Цахилгаан дамжуулах утсыг өндөр хүчдэлийн шугам, цахилгаан станц, тэдгээрийн дэд станцуудад ойр байрлуулахыг хориглоно.

855. Цахилгаан дамжуулагч утасны үзүүрийг зөвхөн зориулалтын бахиар үзүүрлэнэ.

856. Тэсэлгээний машины түлхүүрийг удирдагч өөртөө байлгах ба тэсэлгээ хийхийн өмнө тэсэлгээчинд олгоно.

857. Тэсэлгээний цахилгааны сүлжээг байрлуулсан газраас бүх хүмүүс гарсны дараа шалгана.

858. Цахилгаан дамжуулах утасны үзүүрийг цахилгаан дамжуулах машины дэргэд тусгаарлагдмал, удирдагчийн хяналт дор байлгана.

859. Тэсэлгээ хийхийн өмнө цахилгааны ерөнхий хэлхээг цахилгаан дамжуулах машинд холбохдоо хоргодох байранд гүйцэтгэнэ.

860. Тэсэлгээний үед бусад хүмүүсийг аюулгүйн бүсэд гаргах ба тэдгээрийн зайг удирдагч тогтооно.

861. Баарсан цэнэг байгааг тэсэлгээний ажил хийсний дараа шалгана. Хэрэв баарсан цэнэг гарвал дэлбэрэлт болсноос хойш 15 минутын дараа уг цэнэгийг тавьсан тэсэлгээчин, удирдагчийн хамт очно. Очихдоо холоос урьдаар сайтар хянана.

862. Тэсэлгээ хийсний дараа хэлхээний утсыг цахилгаан дамжуулах машинаас салгаж үзүүрийг богино холболтоор холбож 15 минутын дараа тэсэлгээчнийг хоргодох байрнаас гарахыг зөвшөөрнө.

863. Тэсэлгээ хийсэн цахилгааны утсаар дахин тэсэлгээ хийх тохиолдолд цахилгааны утасны үзүүрийг шороонд үрэх шаардлагатай. Цахилгааны утсанд цэнэг хуримтлагдсан байж болно.

864. Тэсэлгээ хийсний дараа

865. Тэсэлгээ хийсний дараа бие бүрэлдэхүүн тэсэлгээ хийсэн газар орныг шалгана.

866. Баарсан цэнэг, тэсрэх бодисыг удирдагчийн хяналт дор устгаж аюулгүй болгоно.

867. Тэсэлгээчин зарцуулагдаагүй үлдсэн тэсэрч, дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийг буцааж удирдагчид хураалгана.

868. Зарцуулагдаагүй үлдсэн тэсэрч, дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийг тус тусын хайрцагт хийж савлана.

869. Тэсэлгээ хийсний дараа удирдагч тэсэлгээ хийсэн талбайг нягтлан шалгаж, тэсэлгээ хийсэн бие бүрэлдэхүүнд үзлэг хийнэ.

870. Зарцуулагдаагүй тэсэрч, дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийг автомашинд зөөж байрлуулахдаа болгоомжтой харьцана.

871. Зарцуулагдаагүй үлдсэн тэсэрч, дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийг удирдагч буцааж агуулахад тушаана.

Пиротехникийн хэрэгсэлтэй харьцах үед

872. Пиротехникийн хэрэгсэлтэй харьцаж байгаа алба хаагч орчин тойрны аюулгүй ажиллагааг бүрэн хангасан байна.

873. Пиротехникийн хэрэгслийг аюул учруулах зайгаар нь ангилна.

874. Пиротехникийн хэрэгсэл нь 20 метрээс их зайд аюул учруулах хүч чадалтай бол үзвэрийн ангилалд.

875. 20 метрээс бага зайд аюул учруулах хүч чадалтай бол хэрэглээний ангилалд тус тус хамаарна.

876. Пиротехникийн хэрэгсэл тэсэрсний дараа түүний үлдэгдэл тэсэрч, дэлбэрэх жижиг зүйл үлдсэн эсэхийг шалгах.

877. Пиротехникийн хэрэгсэл баарвал 10 минутын дараа очиж шалгана.

878. Баарсан пиротехникийн хэрэгслийг тээвэрлэхэд зориулсан, аюулгүй ажиллагааг хангасан тээврийн хэрэгсэлтэй байна.

879. Тэсэрч, дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийг зөөж тээвэрлэх.

880. Тэсэлгээний ажлын удирдагчийн хяналтад тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгслийг дор дурдсан нөхцөлийг хангасан тохиолдолд тээвэрлэхийг зөвшөөрнө.

881. Тэсэрч, дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийг тээвэрлэх тээврийн хэрэгсэл техникийн бэлэн байдлыг хангасан байх.

882. Тэсэрч, дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийг тээвэрлэхдээ тээврийн хэрэгсэлд зөв байрлуулж, сайн бэхэлсэн байх.

883. Тэсэрч, дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл нь шаардлага хангасан хайрцагтай байх.

884. Тэсэрч, дэлбэрэх бодис, гал дамжуулах шижим, тэсэлгээний хэрэгсэлтэй хайрцгийг цохилт доргилтоос сайтар хамгаалж ачсан байх.

885. Дарийг тээвэрлэхдээ үйлдвэрийн боодолтой эсхүл тусгай хайрцагт хийсэн байх.

886. Тэсэрч, дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийг зориулалтын тээврийн хэрэгслээр тээвэрлэнэ.

887. Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийг тээвэрлэхдээ галын аюулгүй байдлыг хангасан байна.

888. Тэсрэх материалыг зөөвөрлөхдөө тэсэлгээний ажлын удирдагчаас тогтоосон маршрутын дагуу тэсэлгээчний хяналт дор гүйцэтгэнэ.

889. Тэсэрч, дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийг тээвэрлэж байгаа тээврийн хэрэгслийн хөдөлгөөний хурд автозамын нөхцөл байдлаас шалтгаалан 25-60 км/ц хурдтай байна.

890. Тэсэрч, дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийг тээвэрлэж байгаа тээврийн хэрэгслийг хариуцсан дарга нь жолоочоос тамхины хэрэгслийг хураан авч өөртөө хадгална.

891. Тэсэрч, дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл тээвэрлэж байгаа үед гадны хүн хамт тээвэрлэхийг хориглоно.

892. Аянга, дуу цахилгаантай, цаг агаарын таагүй нөхцөлд тээврийн хэрэгслийн жолооч ганц эд юмсын дэргэд зогсохыг хориглоно.

893. Тэсэрч, дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийг хадгалах.

894. Тэсэрч, дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийг тус тусад нь төрөлжүүлж хадгална.

895. Агуулах доторх тэсэрч, дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн хоорондын зай нь ачиж, буулгах, хяналтын үзлэг явуулах боломжтой байна.

896. Хадгалах байрны дотор талын хэсгүүд нь модоор хийгдсэн ба будагдсан байна.

897. Тэсэрч, дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн агуулах нь агааржуулах системтэй байна.

898. Хадгалах байрны гарц (коридор)-ын зай 1.5 м өргөнтэй байна.

899. Тавиур нь бат бөх байх ба тэсэрч, дэлбэрэх бодисыг 10 см-ын зайтай тэгш байрлуулсан байна.

900. Тэсрэх материалыг борооны ус, нарны шууд тусгал зэргээс хамгаалсан тусгай хайрцаг саванд хийж газраас 20 см өндөр тавиур дээр байрлуулах.

901. Хураалттай тэсрэх материал болон тавиурын өмнө талд хаягжилт хийсэн байна.

902. Дарийг бусад төрлийн тэсэрч, дэлбэрэх бодисоос тусад нь агааржуулалт сайтай, хуурай газар хадгална.

903. Пиротехникийн хэрэгсэл болон дарийг хүчтэй доргиож, шидэхгүй байх дарийг нарны шууд тусгалаас хамгаалах.

904. Гал дамжуулах шижмийн бүрхүүлийг гэмтээх болон чийг, хөгцрөлт, ялзралтаас хамгаална.

905. Агуулахын гадна талбай гэрэлтүүлэг сайтай байна.

906. Агуулах нь гал унтраах анхан шатны хэрэгслээр хангагдсан байна.

907. Агуулахад гадны хүн орохыг хориглоно.

908. Тэсрэх материалын агуулахын таазыг бороо, цасны ус гоожих болон үер, усны аюулаас хамгаалсан байна.

909. Агуулахын гадна талын хучилтын зузаанаас үл хамааран аянгын хамгаалалтыг заавал хийсэн байна.

Уурхай, уулын үйлдвэрийн аврах ажиллагаа

910. Аврах ажиллагаанд оролцох бие бүрэлдэхүүн нь удирдагчаас аюулгүй ажиллагааны талаар тодорхой зааварчилгаа авсан байна.

911. Аврах ажиллагаанд оролцох бүрэлдэхүүн хөдөлмөрийн нөхцөл, ажил үүргийн онцлогт тохирсон ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгслээр хангагдаж, тэдгээрийг бүрэн зөв хэрэглэх үүрэгтэй.

912. Аврах ажиллагаа явуулах бие бүрэлдэхүүн нь холбоо, дохиоллын хэрэгсэл, тусгаарлагч шүүгч баг, уурхай, уулын үйлдвэрийн шаардлага хангасан хувийн хамгаалах хэрэгсэл, зориулалтын техник, тоног төхөөрөмж, багаж хэрэгслээр хангагдсан байна.

913. Аврах ажил явуулах газрын орчинд болон орох, гарах хэсэгт анхааруулах, хориглох тэмдэг тавих, аюултай хэсэгт хашлага хийх, хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахын тулд замын хөдөлгөөний зохицуулагч томилно.

914. Ажлын байр нь аюулгүй байдлыг хангасан эсэхийг аврах ажиллагааны бүрэлдэхүүн ажил эхлэхийн өмнө шалгах ёстой.

915. Аврах ажилд оролцох бүрэлдэхүүн аюулгүй байдалд сөргөөр нөлөөлөх зөрчил илрүүлбэл арилгах, түүнээс сэргийлэх арга хэмжээг нэн даруй авах ёстой ба зөрчлийг арилгах боломжгүй бол ажлаа зогсоож, аюулгүй газар гарч, удирдлагад мэдэгдэх ёстой.

916. Аврах ажиллагаанд оролцох бие бүрэлдэхүүн Уул уурхайн сайд, Хөдөлмөрийн сайдын баталсан “Хүдрийн далд уурхайн аюулгүй байдлын дүрэм”, (2015 он) Үйлдвэр худалдааны сайдын баталсан “Ил уурхайн аюулгүй ажиллагааны нийтлэг дүрэм”, (2003 он)-д заасан аюулгүй ажиллагааны шаардлагуудыг биелүүлж ажиллана.

917. Аврах ажилд оролцох бүрэлдэхүүн газрын гүний уурхайд аврах ажиллагаа явуулах үед “Уурхай, уулын үйлдвэрт тусгаарлагч, шүүгч багтай ажиллах журам”-ыг удирдлага болгоно.

918. Аврах ажиллагаанд оролцох бүрэлдэхүүн газрын гүнд үүрэг гүйцэтгэх тохиолдолд “Уурхай, уулын үйлдвэр, үйлдвэрлэлийн аюултай объектод аврах ажиллагаа зохион байгуулах журам⁶”-ыг удирдлага болгоно.

919. Аврах ажиллагаанд оролцох бүрэлдэхүүн хөдөлмөрийн аюулгүй байдал, аюулгүй ажиллагааны дүрмийн шаардлага хангаагүй ил, далд, бичил уурхайд хүний амь аврахаас (удирдагчийн зөвшөөрөлтэйгөөр аюулгүй ажиллагааг хангаж) өөр тохиолдолд үүрэг гүйцэтгэхийг хориглоно.

920. Аврагчид газрын гүний нөхцөлд өндөрт ажил үүрэг гүйцэтгэх үед аврах бүс, олс, ган татлага хэрэглэж болно. Тэдгээрийн газрын дээрх бэхэлгээг найдвартай хийсний дараа үүрэг гүйцэтгэнэ.

921. Уурхай нурах буюу гулсах аюул тулгарсан үед аврагчдыг нэн даруй аюулгүй газарт гаргана.

922. Уурхайд аюултай, хортой ялгарсан, хийн хэмжээ зөвшөөрөгдөх хэмжээнээс хэтэрсэн тохиолдолд аврагчдыг аюулгүй газарт нэн даруй гаргана.

923. Аврах ажил явуулах үед дараах зүйлийг хориглоно.

923.1. Аюулгүй ажиллагааны зааварчилгаа аваагүй байх,

923.2. Далд уурхайд зориулалтын дуулга, малгайн гэрэл, гэрэлтүүлэх хэрэгсэл гэх зэрэг хувийн хамгаалах хэрэгсэлгүй үүрэг гүйцэтгэх,

⁶ ОБЕГ-ын даргын 2015 он А/272 дугаар тушаалын хавсралт

923.3. Паспортын дагуу тавьсан бэхэлгээ, банзалгаагүй аюултай нөхцөлд үүрэг гүйцэтгэх,

923.4. Агааржуулах системгүй, аюултай, хортой хийн ялгаралтай уурхай, уулын үйлдвэрт үүрэг гүйцэтгэх,

923.5. Далд уурхайн ослын дуудлагын үед тусгаарлагч, шүүгч баггүй ажиллах,

923.6. Далд уурхайд гал гаргах, тамхи татах,

923.7. “Саравч” үүссэн буюу чулуу, хөлдүүс нурах, догол мөргөцгийн хана, ирмэг гулсах зэрэг аюул бүхий хэсгийн дор ажил үүрэг гүйцэтгэх,

923.8. Бүрэн бус, хаалт хамгаалалтгүй техник тоног төхөөрөмж ашиглах,

923.9. Өндөрт (газрын гүнд) хамгаалах хэрэгсэлгүй үүрэг гүйцэтгэх.

Гүний болон ил уурхайд эрэн хайх, аврах ажиллагаа

924. Ажлын байранд үйлдвэрлэлийн явцад үүсэж болзошгүй хими, физик, биологийн хүчин зүйлүүд, ажлын байрны бичил орчны нөлөөллүүд. / үйлдвэрлэлийн тоос, хортой, аюултай хийнүүд, доргион, чичиргээ, шуугиан, цаг уурын нөлөөллүүд, бактери, вирус, мөөгөнцөр гэх мэт/

925. Хүн нэг бүрийн аюулгүй ажиллагааны хамгаалах хэрэгсэл, ажлын тусгай хувцас, аюулгүй ажиллагааны шаардлагын дагуу хэрэглээгүйгээс үүдэн гарах эрсдэлүүдээс далд уурхайн хамгаалалтын тусгай дуулга, малгайн гэрэл, тусгай хамгаалалттай ажлын гутал, ажлын хувцас зэргийг хэрэглэж хамгаална.

926. Тоног төхөөрөмжийн эргэлдэх болон хөдөлгөөнт ангиудын нөлөө, цахилгаан хэлхээний хүчдэлд цохиулахаас хамгаалалт, хаалтыг бүрэн байгаа эсэхэд хяналт тавьж, зориулалтын хувцас хэрэглэлийг зөв хэрэглэж хамгаална.

927. Налуу, эгц босоо, давчуу, халтиргаа гулгаатай орчин нөхцөлд багаж, тоног төхөөрөмж зөөвөрлөх, осолдогсдыг тээвэрлэх, өндөрт ажиллах зэргээс бариултай шат, нэг бүрийн хамгаалалтын хувцас хэрэгслийг хэрэглэнэ.

928. Өрөмдлөг, тэсэлгээний ажлын үеийн аюулуудаас /цохих долгионд өртөх, ойсон чулуулагт цохиулах, чичирхийлэлд өртөх, баарсан цэнэгийн аюулууд г.мэт/ зохих зөвшөөрөл бүхий мэргэжлийн байгууллагаар хийлгэх буюу, зориулалтын хамгаалах хэрэгсэл, дуулга, дохиоллын хэрэглэлүүдтэйгээр нэг бүрийн хамгаалалтын хэрэгсэл бүрэн зөв хэрэглэж, тэсэлгээ хийсний дараа сул чулуулгийг унгаах, баарсан цэнэгийг шалгаж аюулгүй болсон тохиолдолд дараагийн ажил үүрэг гүйцэтгэнэ.

929. Ил, далд уурхайд үүсдэг аюултай, хортой хийн нөлөөллүүдээс хамгаалахдаа зориулалтын багажаар хэмжилт хийж ажил үүрэг гүйцэтгэнэ.

930. Уулын нурал, даралт, усны цөмрөл, тэсрэлт, галын аюул хийн гэнэтийн хаял, агааргүй, халуун, утаатай, үзэгдэх орчин муутай гэх мэт онцгой нөлөөллүүдээс уурхай “Уулын үйлдвэр, үйлдвэрлэлийн аюултай орчинд аврах ажиллагаа зохион байгуулах журам”-д заасны дагуу аюулгүй ажиллагааг хангаж үүрэг гүйцэтгэнэ.

931. Орчноос бүрэн тусгаарлагдсан амьсгалын аппараттай ажиллах, хэвийн нөхцөлөөс өндөр температуртай, сэтгэл санааны онцгой таагүй орчин. /аврагчид бэлтгэл дадлага сургуулилт хийж, бэлтгэгдсэн байх ба аврах ажиллагааны үед багны даралтыг хянаж гэмтэл гарвал цэвэр агаартай орчинд бүрэлдэхүүнээрээ шууд гарна.

932. Үргэлжлэн хэдэн цагаар хүчилтөрөгчөөр амьсгалж, физиологийн системийн хүчил, шүлтийн тэнцвэртэй байдалд нөлөөлөх. /сөрөг үр дагавар/

тусгаарлагч шүүгч баг хэрэглэн үүрэг гүйцэтгэсэн үед тохиромжтой хоол ундаар хангана.

933. Амьсгал авах, гаргахад байнгын нэмэлт эсэргүүцэлтэй тулгарч /100- 300Па буюу 10-30 мм.рт.ст даралт/ хүндрэл учрах тул дадлага сургуулилтыг тогтмол хийх.

934. Багтай ажиллах үед амьсгалж буй агаарын чийглэг 100%, температур нь 39-42 градус, хүрч, амьсгалын замын бүх эрхтэн систем дулаанаа гадагш ялгаруулах боломжгүй, дулааны солилцоо хүндрэх тул хөргүүртэй багтай ажиллана.

935. Биеийн хүчний хүнд ажил хийх үед ялангуяа тусгаарлагч, шүүгч багтай ажиллах зөвшөөрөгдсөн хугацааны төгсгөл рүү нүүрсхүчлийн хийн бүрэн шүүлт саарч амьсгалын замд орох тохиолдол гарах магадлал өндөр тул газар дээр болон газрын гүний баазад сольж дараагийн ажилд орно.

936. Аврах багаж хэрэгслийн жин нь биеийн хүчний хүнд ажлын үед зарцуулах энергийг 25%-27% ихэсгэх, зэрэг аврагчдын онцгой хүндрэлд ажил амралтын горимд шилжүүлнэ.

937. Байнгын зохиомол агаартай, хязгаарлагдмал орчинд байнгын хэмжилт хийнэ.

938. Сэтгэл санааны байнгын таагүй нөхцөл /агааргүй, хортой, аюултай хийтэй, халуун, хасах температуртай гэх мэт хэвийн бус нөхцөл гэх мэт/ зэрэг аюулгүй ажиллагааны сөрөг нөлөөллүүдтэй орчинд уурхайн аврагчид үүрэг гүйцэтгэдэг.

Эрэлч нохойтой аврах ажиллагаа

939. Гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд эрэн хайх, аврах, харуул хамгаалалтын чиглэлээр албаны нохойг дараах зорилгоор ашиглана.

940. Төв, орон нутгийн онцгой байдлын анги, байгууллагын томилгоот эрэн хайх, аврах бүлгийн бүрэлдэхүүнд аврагч нохой, аврагч-нохойн хөтлөгч байна.

941. Аврагч-нохой хөтлөгч нь аврах ажиллагааны арга технологийг эзэмшиж, тоног төхөөрөмж, багаж хэрэгслийг зааврын дагуу ашиглах мэдлэг чадвартай байх ба аврагч нохой ашиглах боломжгүй болсон тохиолдолд аврах ажиллагаанд туслалцаа үзүүлж үүрэг гүйцэтгэнэ.

942. Болзошгүй аюулт үзэгдэл, ослын улмаас тухайн нутаг дэвсгэрт эрэн хайх, аврах чиглэлээр албаны нохойгоор самнан нэгжлэг хийж тогтоох, нэрвэгдэгсдэд анхны тусламж үзүүлнэ.

943. Уул уурхай, үйлдвэр, барилга байгууламж ноцтой эвдрэх, нурах зэрэг ослын үед хүн болон цогцос эрэн хайх, аврах, нэрвэгдэгсдэд анхны тусламж үзүүлэх.

944. Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн аюулаас урьдчилан сэргийлэх зорилгоор байшин барилга, орон байр, агаарын хөлөг, төмөр замын болон нийтийн тээврийн хэрэгсэл болон тогтоосон газарт үзлэг, шалгалт хийх, олж тогтоох.

945. Гамшгаас хамгаалах үйл ажиллагаа болон сургалт, дадлагын үед аврагч-нохой хөтлөгч, албаны нохой тусгай зориулалтын хувцас, тоног төхөөрөмж, багаж хэрэгслээр хангагдана.

946. Албаны нохой эрэн хайх, аврах үйл ажиллагаанд үүрэг гүйцэтгэхэд тусгай зориулалтын цээживчтэй ажиллана.

947. Тусгай зориулалтын цээживчний дагалдах хэрэгсэл:

947.1. Хонх;

947.2. Гэрэлтүүлэг;

947.3. Гар чийдэн;

947.4. Шүгэл;

947.5. Эмийн сан;

947.6. Ус /250 гр/;

948. Мал, амьтны эмч нь гамшгаас хамгаалах үйл ажиллагаа, сургалт, дадлагын үед албаны нохойн аюулгүйн ажиллагаанд хяналт тавьж, заавар, зөвлөмж өгөх, гэмтсэн, бэртсэн, шархадсан, осгосон, түлэгдсэн нохдод яаралтай тусламж, үйлчилгээ үзүүлж ажиллана.

949. Эрэлч нохойг улиралд 1 удаа буюу, гамшиг ослын голомтод үүрэг гүйцэтгэсний дараа үзлэгт хамруулах.

950. Ой, хээр, нурангид эрэн хайх, аврах чиглэлээр албаны нохой ашиглах:

951. Гамшиг, аюулт үзэгдэл, ослын газарт судалгаа хийх, албаны нохойг ашиглах боломжийн талаар үнэлэлт өгөх, нэрвэгдэгсдийн явсан чиглэл, байрлалын талаар мэдээлэл цуглуулах, шуурхай бүлгийн удирдагчтай зөвлөлдөж эрэн хайх бүлгийн урд ямар зайнд ажиллах талаар тодорхой зааварчилгаа авна.

952. Эрэн хайх, аврах үйл ажиллагаанд оролцогсод албаны нохойн анхаарал сарниулах, дуу, чимээ гаргах, нохойн урд явахыг хориглоно.

953. Албаны нохой ашиглах талаар томилгоот шуурхай бүлгийн удирдагчтай зөвлөлдөх, аврагч нохой ашиглах хамгийн тохиромжтой газар, талбайг сонгож нохойг эрэн хайх, аврах ажиллагаанд бэлтгэн ашиглах, нохойн ажилд тогтмол үнэлэлт, дүгнэлт хийх, үр дүнгийн талаар тэмдэглэл үйлдэнэ.

954. Нохойн үйлдэл, түүний зан байдал, нохойн эерэг дохионд анхаарал тавих, зан төрхийн өөрчлөлтийн талаар дүгнэлт хийж тэмдэглэх, шаардлагатай тохиолдолд тэмдэглэж авсан газар, объектод дахин үзлэг, шалгалт хийлгэнэ.

955. Гамшиг, ослын үед нохойн эрүүл мэнд, мэргэшил зэргийг харгалзан эрэн хайх ажилд тасралтгүйгээр нэг удаа 15-20 минутаас дээшгүй хугацаанд ажиллуулна.

956. Үүрэг гүйцэтгэх явцад нохойд ядарсан шинж тэмдэг ажиглагдвал хөтлөгч ажлыг зогсоон сүүлийн шалгасан хэсгийг тэмдэглэн авч, нохойг тайван амарч болох газарт хөтлөн 15 минут орчим амраасны дараа эрлийг үргэлжлүүлнэ.

957. Албаны нохойн эрж хайх идэвхийг сэргээх зорилгоор голомтын бүсэд туслахыг нууж түүнийг нохойгоор хайж олуулах боломжийг аврагч-нохой хөтлөгчид олгоно.

958. Хариуцсан нохой болон тусгай зориулалтын хамгаалах хувцас, хэрэгслийн бэлэн байдлыг хангах, хөдөлмөрийн аюулгүй байдлын зааварчилгааг баримталж ажиллана

959. Эрэн хайх, аврах ажиллагааны үед гарсан алдаа, зөрчил дутагдлын талаар бүлгийн даргад яаралтай мэдэгдэнэ.

Цогцос эрэн хайх чиглэлээр албаны нохой ашиглах

960. Үйлдвэрлэл, технологийн горим зөрчигдсөнөөс тоног төхөөрөмж, барилга байгууламж ноцтой эвдрэх, нурах, сүйрэх, дэлбэрэх зэрэг ослын бүсэд эрэн хайх, аврах чиглэлээр бэлтгэгдсэн албаны нохой ашиглана.

961. Цогцос хайгч нохойг дараах зүйлд ашиглаж болно. Үүнд:

961.1. ой мод, бут сөөг, шавартай газар,

961.2. урсгал гол, нуур, цөөрөм, тогтоол ус,

961.3. уурхай, үйлдвэр, барилга байгууламж,

961.4. байгалийн сүйрэл, тэсэлгээний газар, нурангийн талбар.

962. Самнан нэгжих талбайд байгаа хорт хий болон химийн бодис, цахилгаан хүчдэл, гал түймрийн аюулын нөлөөлөл нь нохойн эрүүл мэндэд аюул учруулах бол албаны нохой хэрэглэхийг хориглоно.

963. Цогцос хайгч нохойг ашиглахад энэ журмыг баримталж нохойг ашиглана.

964. Уснаас эрэн хайх, аврах чиглэлээр албаны нохой ашиглах:

965. Үер, усны эрэн хайх, аврах чиглэлээр бэлтгэгдсэн албаны нохойг ашиглана. Үүнд:

965.1.1. усанд буцалтгүй нэрвэгдэгч /цогцос/ хайх,

965.1.2. үер, усанд урссан, живж буй нэрвэгдэгсдийг аврах.

966. Уснаас эрэн хайх, аврах бүлгийн хамт завьтай эргүүл хийх, үер, усанд урссан, живж буй нэрвэгдэгсдэд албаны нохойгоор аврах цагариг, олсыг хүргүүлэх, татан гаргах ажиллагааг явуулна.

967. Урсгал усанд ажиллагаа явуулахад усны урсгал дээр завийг байрлуулж, завийг тогтсон үед албаны нохойг ашиглана.

968. Албаны нохойг буцалтгүй нэрвэгдэгчийг эрэн хайхад завины урд, эргүүл хийхэд дунд хэсэгт байрлуулж ашиглана.

969. Үерийн аюултай, ширүүн урсацтай үед албаны нохой ашиглахыг хориглоно.

970. Урсгал уснаас эрэн хайх, аврах ажиллагааг гүйцэтгэхдээ аюулгүй ажиллагааны зааврыг баримтлан голын эргийн дагуу үүрэг гүйцэтгэнэ.

971. Албаны нохой ашиглахад зориулалтын хөвөгч хантаазтай ашиглана.

972. Уснаас эрэн хайх, аврах үйл ажиллагаанд оролцож байгаа алба хаагч усчны мандлын хувцас, дуулга, малгай, бээлий, гутал, нүдний шил, усчны хутга, шүгэл, усчны цаг, луужин, гар чийдэн, цүнх, усчны олс, тэмтрүүл зэрэг тоног хэрэгсэлтэй ажил үүрэг гүйцэтгэнэ.

Уул, уурхайд эрэн хайх, аврах чиглэлээр албаны нохой ашиглах

973. Эрэн хайх аврах ажиллагааны удирдагчийн даалгаврын дагуу үүссэн нөхцөл байдал, шуурхай ажиллагааны даалгавартай танилцаж уурхайн малталтын зураглал, явах зам, агааржуулалтын схем, үүссэн нөхцөл байдалд уялдуулан ослын үеийн удирдагчийн заавраар албаны нохой ашиглана.

974. Албаны нохойг агааргүй, үзэгдэх орчингүй, хязгаарлагдмал, хорт хийтэй орчинд ашиглахыг хориглоно.

975. Аврах ажиллагаа явуулж байгаа бүх тохиолдолд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ажиллагааны шаардлагыг хангаж ажиллана.

976. Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл олж илрүүлэх чиглэлээр албаны нохой ашиглах.

977. “Тэсрэх бодис” гэж гадны тодорхой үйлчилгээний нөлөөгөөр өндөр даралт бүхий хүчтэй халаагдсан хийг үүсгэн өөрөө хурдан тархан химийн хувиралд орох чадвартай химийн нэгдэл буюу холимгийг хэлэх ба түүний нэгдэл бодисуудын үнэрт тусгайлан сургасан төрөл мэргэжлийн нохойг ашиглана. Үүнд:

- 977.1. байшин барилга, орон байр,
- 977.2. агаарын хөлөг, төмөр замын болон нийтийн тээврийн хэрэгсэл,
- 977.3. тогтоосон дэвсгэр газар,
- 977.4. илгээмж, ачаа бараа,
- 977.5. гар тээш, хувийн эд зүйлс зэрэгт үзлэг, шалгалтад ашиглаж болно.

978. Албаны нохойг тээвэрлэлтийн дараа шаардлагатай хугацаанд амраах, үүрэг гүйцэтгэхэд бэлтгэж газар орчинд зугаалуулан дасгах, нэгжлэгийн явцыг бодож боловсруулах, өөрийн саналаа илэрхийлэх, нохойн ажлыг хүндрүүлж байгаа нөхцөлийг арилгах болон агааржуулалтын арга хэмжээ авах, хайгч нохойн хянаж чадахгүй газруудыг тэмдэглэх, үүрэг гүйцэтгэсэн талаар тэмдэглэл үйлдэж нохойн хувийн хэрэгт хийнэ.

979. Аврагч-нохой хөтлөгч нохойн үйлдэл, түүний зан байдал, дохионд анхаарал тавих, сэжигтэй газруудыг тэмдэглэх, боломжгүй газарт нохой ойртож очиход нь туслах, нохойн эерэг дохио, зан төрхийн өөрчлөлтийн талаар дүгнэлт хийж тэмдэглэх, шаардлагатай тохиолдолд тэмдэглэж авсан дэвсгэрт дахин үзлэг, шалгалт хийлгэхээр явуулж болно.

980. Аврагч-нохой хөтлөгч эрж хайх ажилд нохойн хамт дангаараа үүрэг гүйцэтгэх ба хайгч нохойг тасралтгүйгээр 20 минутаас дээшгүйгээр ажиллаж 15 минут орчим амраасны дараагаар үргэлжлүүлэн ашиглана.

981. Үзлэг, шалгалт явуулж байгаа бүх тохиолдолд хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны шаардлагыг хангаж ажиллана.

982. Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийг илрүүлсэн тохиолдолд “Аюултай” гэсэн бичиглэлтэй тэмдэг тавьж, холбогдох мэргэжлийн байгууллагад хүлээлгэн өгнө.

Өндрийн ажиллагааны үед олсоор албаны нохойг өргөж гаргах, буулгах

983. Нисдэг тэрэгнээс болон барилга, байгууламж, уул, хад асга зэрэг албаны нохой явах боломжгүй газарт олсоор татаж гаргах, буулгах үеийн зааварчилгааг сайтар судалсан, зааварлагч, бүлгийн даргын командаар бууна.

984. Нисдэг тэрэгнээс албаны нохойг олсоор буулгахын өмнө өндрийн бэлтгэлд хамрагдаж дасгасан байна.

985. Олсоор буулгах үед нохойд зориулалтын өмсгөл /хударга/, хошуувчийг зүүлгэж түгжээтэй карабин ашиглан хөтлөгчийн өмсгөл /хударга/-өөс бэхлэн буулгана.

986. Нисдэг тэргэнд нохойг хөтлөгчийн хөлийн дэргэд, шаардлагатай тохиолдолд зориулалтын торон үүрэнд хийж байрлуулж болно.

987. Олсоор буух үед аврагч-нохой хөтлөгч, нохойн өмсгөл /хударга/ -ийг шалган нягталж, нохой олстой орооцолдохоос урьдчилан сэргийлнэ.

988. Өндрийн ажиллагааны бүх тохиолдолд хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны шаардлагыг хангаж ажиллана.

Харуул хамгаалалтын чиглэлээр албаны нохой ашиглах

989. Онцгой байдлын байгууллагын дотоод аюулгүй байдлыг хангах зорилгоор харуул хамгаалалтын чиглэлээр албаны нохой ашиглана.

990. Харуул, хамгаалалтын чиглэлээр албаны нохойг ашиглахдаа нохойг гүйлгээ уяанд болон байнгын хяналтын цэгт байрлуулахад зориулалтын байр,

сүүдрэвчтэй байх ба үүрэг гүйцэтгэж байгаа алба хаагчийн хяналтад байлгана. Нэг нохойг газар, байршлын онцлогоос шалтгаалж 100-150 метр хүртэлх талбайд гүйлгээ уяанд байнга болон түр ашиглах хэлбэртэйгээр зохион байгуулж ашиглана.

991. Онцгой байдлын байгууллагын харуул хамгаалалтад байгаа объект руу нууцаар нэвтрэн орсон, эсхүл зэвсэг хэрэглэх буюу бүлэглэн довтолсон, алба хаагчийн тавьсан хууль ёсны шаардлагыг эсэргүүцэж амь нас, эрүүл мэндэд ноцтой хохирол учруулж болзошгүй тохиолдолд нохойг оосор, хошуувчгүйгээр ашиглаж болох ба тухайн хариуцан ажиллаж байгаа алба хаагч нь үүссэн нөхцөл байдалд дүгнэлт хийж “Зогс, нохой тавилаа” гэж урьдчилан анхааруулж, нохойг өөрийн хяналтаас гаргахгүйгээр ашиглана. Хүн нохойд уруулж гэмтэл авсан тохиолдолд эмнэлгийн тусламж үзүүлэх арга хэмжээг нэн даруй авч, захирах даргадаа шуурхай мэдэгдэнэ.

992. Албаны нохой ашиглаж байгаа байгууллага нь “Анхаар нохойтой” гэсэн анхааруулах тэмдгийг иргэдэд харагдахуйц газарт байрлуулна.

Нисдэг тэрэгтэй эрэн хайх, аврах ажиллагааны үеийн аюулгүй ажиллагаа

993. Нисдэг тэрэгнээс гарах үед зөвхөн аврах ажиллагааны мэргэжилтний дохиогоор ажиллана.

994. Нисэх баг, инженер техникийн бүрэлдэхүүн нислэгийн аюулгүй байдлыг нисэхийн дүрмийн дагуу хариуцан ажиллана.

995. Аврах ажиллагааны мэргэжилтэн дохио өгөх үед нисдэг тэрэгний гадна талд гарч чарга дээр зогсож бэхэлгээнүүдийг нэг бүрчлэн шалгана.

996. Аврах ажиллагааны мэргэжилтэн аврагчийг доош буулгах үед хөл газарт хүрэхээс 2 метр өндөрт хоёр гарыг алдлан доошлох хурдыг багасгах.

997. Үүний дараа доош харан газардахад бэлдэнэ.

998. Хөл газарт хүрмэгц татлагыг салгаж аврах ажиллагааны мэргэжилтэнд тороосыг дээш өргөх дохио өгнө.

999. Аврагч дээш өргүүлэх үед холболтыг зөв хийж дээш өргөх дохиог аврах ажиллагааны мэргэжилтэнд харагдахаар өгнө.

1000. Өргөгдөөд 2 метр өндөрт ирмэгц өргөлтийг зогсоох дохиог өгч ахин холболтуудыг шалган /15 секунд/ өргөх дохиог өгнө.

1001. Аврагч нисдэг тэргэнд ойртох үед хамгаалалтын дуулгаар нисдэг тэрэгний эд ангид цохихоос болгоомжилно.

1002. Аврагч нисдэг тэрэгний хаалганд ирэх үед аврах ажиллагааны мэргэжилтэн бүхээгийн бэхэлгээг аврагчид холбон нисдэг тэрэг рүү орох дохио өгнө.

1003. Аврагч бүхээгт орсон үед зөвхөн аврах ажиллагааны мэргэжилтний дохиогоор дараагийн үйлдлүүдийг хийнэ.

1004. Дамнуургатай ажиллах үед нисдэг тэрэгний ирэх чиглэлийн дагуу нэрвэгдэгчийн толгой хэсгийг харуулсан байна.

1005. Чиглүүлэгч олсыг дамнуургатай бэхэлсэн эсэхийг сайтар шалгана.

1006. Дамнуурга өргөгдөн аврах ажиллагааны мэргэжилтнийг салгах хүртэл чиглүүлэгч олсыг тунараалгүй байна.

1007. Дамнуургыг нисдэг тэргэнд орох үед нисдэг тэрэгний их биед цохихоос хамгаалан оруулна.

Нисдэг тэрэг, шүхэртэй ажиллах аюулгүй ажиллагаа

1008. Нисдэг тэрэгний ачааны нээлхийгээр болон урд хаалгаар ачааг ачна.

1009. Ачааны бүхээгт тээвэрлэж байгаа техник, овор ихтэй ачааг шалан дээрх бэхэлгээний цагаригт ган татлагаар бэхэлнэ.

1010. Нисдэг тэргээр тээвэрлэж байгаа ачааг нислэгийн үед хөдлөхгүй байхаар бэхэлнэ. Жижиг ачааг хооронд нь холбох буюу тусгай хайрцагт хийх ба эсвэл ачаа даруулах тор, ган татлагаар шаланд бэхэлнэ.

1011. Нислэгийн үед бүхээгт нисэх багийн гишүүн, бүлгийн ахлагчийг байраа сольж явахыг зөвшөөрнө.

1012. Эрэн хайх, аврах бүлгийн дарга буюу бортмеханик нислэгийн үеийн аюулгүй байдал болон ослын үед нисдэг тэргийг яаж орхин гарах талаар аврагч нарт зааварчилгаа өгнө.

1013. Нисдэг тэргийг газардсаны дараа хөдөлгүүр унтарч, сэнсний эргэлт бүрэн зогссоны дараа ойртон очно.

1014. Хэрэв нисдэг тэрэг газардсаны дараа хөдөлгүүрээ унтраалгүйгээр нэрвэгдэгсэд, багаж хэрэгслийг ачиж, буулгах үед нисдэг тэрэгний зөвхөн урд хэсгээр ойртоно.

1015. Нэрвэгдэгсдийг дамнуургаар зөөх болон төрөл бүрийн багаж зэвсгийг зөөхдөө аль болох доогуур газартай ижил түвшинд авч явна.

1016. Олсыг эвхсэн байх ба хөнгөн багаж, эд зүйлсийг үүргэвч, бусад саванд эвхэж хийнэ. Цана, цанын таяг, хоосон дамнуургыг зөвхөн хэвтээ байдлаар зөөнө.

1017. Газардсаны дараа аврагчид бортмеханикийн заавраар нисдэг тэрэгнээс бууна.

1018. Газардах талбайн бүх үйл ажиллагааг агаарын ажиллагааны удирдагч буюу тусгай томилогдсон алба хаагч удирдана.

1019. Нисдэг тэрэгний ойролцоо ажиллаж байгаа алба хаагч хамгаалалтын дуулга өмссөн, эрүүвчийг чангалсан, хамгаалалтын нүдний шилтэй байна.

1020. Нисдэг тэрэгний хөдөлгүүр асах, хөөрөх, буух үед шүхэрчид, аврагчид буултын талбайгаас аюулгүй зайд байрлана.

1021. Нисдэг тэрэгнээс 50м-ийн радиуст байгаа хөнгөн жинтэй зүйлсийг (цанын малгай, бээлий, сав суулга, олс гэх мэт) хийсэж нисдэг тэрэгний хөдөлгүүр, сэнсэнд орохоос сэргийлж хөдөлгөөнгүй байхаар бэхэлнэ.

1022. Нисдэг тэрэгний доторх багаж хэрэгслийг бортмеханикийн заасан газарт хурааж, шаардлагатай бол бэхэлнэ. Алба хаагчид сандал дээр суудлын даруулгаар даруулж сууна.

1023. Нисдэг тэрэгний нисгэгч өмнө нь бууж үзээгүй газар буулт хийхэд газраас радиостанц буюу гараар өгөх дохионы тусламжтайгаар чиглүүлэлт хийнэ.

1024. Дохионы буу түүдэг гал, туг дарцгаар дохио өгч болно.

1025. Дохиог шаардлагатай үед өөрчлөх нөөц хугацаатайгаар нэг дэх болон хоёр дах дохиог өгнө.

1026. Нисдэг тэргийг харагдаж эхэлмэгц газардах талбайг хурдан зааж өгөхийн тулд дохионы пуужингаар чиглэлийн хажуу дээш нь буудаж дохио өгнө.

1027. Газардах талбайгаас 100-200 м зайтай нисэж байх үед дохионы буугаар дохио өгнө. Талбайг онгоцны баг илрүүлсний дараа салхины дагуу пуужинг харваж нисэх багт чиглэлийг зааж өгнө.

1028. Шүхэр тээвэрлэх аюулгүй байдал.

1029. Шүхрийг тээвэрлэхэд хориглох зүйлс.

1029.1. Шүхрийг тээвэрлэхэд тос, химийн төрөл бүрийн бодис ачсан машин дээр тээвэрлэх,

1029.2. Хэрэглэлтэй шүхрийг машин дээр хоёроос илүү давхарлаж тээвэрлэх, ачсан шүхэр дээр суух,

1029.3. Шүхэр эвхэлтийг зориулалтын брезент дээр эрх бүхий зааварлагчийн хяналтын дор зөвхөн өөрийн шүхрийг эвхэнэ.

1030. Шүхэр эвхэхэд хориглох зүйлс.

1030.1. Эвхэлтийн үеийн үзлэгүүдийг алгасахгүй, дарааллын дагуу хийлгэх ба томилогдсон зааварлагчаас өөр бусад хүнээр хийлгэх,

1030.2. Тэнцүүлэгч шүхрийг эвхэхэд газраас хөндийрүүлэх,

1030.3. Шүхэр эвхэлтийн талбайгаас шүхэр эвхэж байгаа үед зааварлагч нарын зөвшөөрөлгүйгээр явах, шүхэрчдийг дуудах,

1030.4. Өөр хүний эвхсэн шүхрээр буух,

1030.5. Шүхрийг эвхэсний дараа паспортыг хөтөлж зааварлагчийн гарын үсгээр баталгаажуулж буултад бэлтгэнэ.

Усанд буюу усархаг газар оронд буух ажиллагаа

1031. Усанд буух үедээ аврах хантааз заавал хэрэглэх.

1032. метрээс өндөргүй, хөл усанд хүрэх үед шүхрийг салгах.

1033. Хэрэв эргийн зүг салхитай байвал өргөгч холбогч системээс барин эргийн зүг сэлнэ.

1034. Шүхэр салгахгүй усанд орвол орооцолдох аюултай ба эрэгт хэт ойр буувал оосрыг салгахгүй.

1035. Дадлагын үед аврах завь, цагариг зэргийг ашиглана.

Шөнө шүхрээр буух ажиллагаа

1036. Шөнийн буултад шүхрийн задаргааг хянах, гэрэлтүүлэх гар чийдэнтэй явахыг шаардана.

1037. Өндрийн хэрэглэл, салхины чиг тогтоогч, газардалт ойртолтыг мэдрүүлэх талбайн хэрэглэл тус тус гэрэлтүүлнэ.

1038. Газардахад анхаарч хөлийг сайн барих хэрэгтэй.

1039. Шүхэрчид хоорондоо мөргөлдөхөөс зайлсхийж гар чийдэн хэрэглэх ба газардалтын тэмдэг (гал, гэрэл) ямар байдалтай (зөв, буруу) байгааг байнга ажиглах.

Модонд буух үеийн ажиллагаа

1040. Модонд буухдаа биеийг зөв байрлуулж, хөл гарыг зөв барьж (нүүр, ил хэсгийг далдлах) газардах.

1041. Модонд дүүжлэгдсэн үед савалтыг зогсоох.

1042. Хэр дүүжлэгдсэнээ тогтоох, модноос буух арга (нөөц шүхэр ашиглах)-ыг чадамгай ашиглах.

1043. Модноос шүхрийг салгах үед мод унах, дарагдахаас болгоомжлох.

1044. Модонд цугларах үедээ галт хэрэглэл ашиглахдаа зааврын дагуу ашиглах, гал түймрээс сэргийлэх.

Аврах гарц /люк/ -ээр гардаг онгоцноос гарах үеийн ажиллагаа

1045. 140-150 км/цаг хурдтай онгоцноос хажуу буюу арын люкээр хоорондоо маш бага зайтай гарна.

1046. Люк онгойход гарах хүчтэй дуунаас сэргийлж хамгаалалтын малгай өмсөнө.

1047. Гэрлэн болон дуут дохиог маш сайн биелүүлэх.

1048. Боссон тохиолдолд хөлийг мөрний хэмжээтэй салгаж, бие биеийн шүхэр дээр духыг нааж зогсоно. Энэ нь онгоцны зайлалтаас хамгаалах арга.

1049. Гарах командаар гүйхдээ замдаа унахаас болгоомжлох, унасан нөхрөө босоход туслан зай авахаас болгоомжилно.

1050. Хөл, гарт тэнцүүлэгч орохоос хамгаалж онгоцны салхинаас гартал хөл, гараа салгахыг хатуу хориглоно.

Онцгой тохиолдолд шүхэрчний ажиллагаа

1051. Шүхрээр бууж байгаа үед үндсэн шүхрийн хэвийн ажиллагаанд саад учирч болно. Эдгээр нөхцөлүүдэд:

1051.1. Шүхэрчид хоорондоо хэт ойртох, орооцолдох, доошлох үед төрөл бүрийн саад (ус, намаг) тааралдах, тогтворжуулагч шүхэр зэвсэг хэрэгсэлтэй орооцолдох, үндсэн шүхрийн бүнхэр оосортой орооцолдсоноос болж урагдах нөхцөлүүд байж болно.

1051.2. Агаарт доошилж буй шүхэрчин нөгөө шүхэрчнийхээ бүнхэр лүү орж болох тул бие биенээсээ аль болох хол явна.

1051.3. Нэгэнт ойртсон шүхэрчид аль болох ашигтай гулсалтыг хийх ба чиглэлийг сонгож нөгөө шүхэрчиндээ хашхирч заана.

1051.4. Оосрууд болон бүнхрүүд орооцолдсон тохиолдолд шүхэрчид нэг шүхрээр ч гэсэн осолгүй газардуулах арга хэмжээ авна.

1051.5. Нэг шүхэрчин нөгөө шүхэрчнийхээ оосруудын хоорондуур ороод дээр нь байрласан тохиолдолд унтарч байгаа бүнхрийг газардах хүртлээ барина.

1051.6. Шүхэрчин нөгөө шүхэрчнийхээ хэдэн оосруудын дундуур ороод дэгээдсэн тохиолдолд нөгөө гогцоолсон оосруудыг хурдан тастах ёстой.

1051.7. Шүхэрчин савж байгаа тохиолдолд газардахад хэцүү байдаг тул савалтын дээд цэгт байгаа хэсэг оосруудыг савалтын чигт хүчтэй татаж савалтын доод цэгт хүртэл тэдгээрийг барьж байна. Дараа нь тэдгээрийг тавьж эсрэг талд байгаа оосрыг татна. Үүнийг хэд хэдэн удаа хийнэ.

1052. Хадтай гүн жалганд газардах тохиолдолд агаараар дүүрсэн бүнхрийг ашиглан хөлөөрөө саадыг гэтлэн давж жалганы ёроолд хурдан буух хэрэгтэй.

1053. Шүхэрчин усанд буух тохиолдолд өргөж холбох систем хэрэгслээсээ хурдан салахын зэрэгцээ түүнээс гэнэт унах аюулаас сэрэмжлэх хэрэгтэй. Уснаас цухуйсны дараа зэвсэгтэйгээр эрэг лүү сэлнэ.

1054. Үндсэн бүнхэр урагдсан буюу оосруудтай орооцолдсоны улмаас доошлох хурд ихэссэн тохиолдолд нөөц шүхрийг хурдан задлах хэрэгтэй. Хэрэв үндсэн бүнхэрийн жижиг гэмтлийн үед шүхэрчин босоо чигтээ эргэлдэн доошлох тохиолдолд эргэлтийн хөдөлгөөнөө зогсоосны дараа нөөц шүхрээ задална.

1055. Эргэлдэх хөдөлгөөнөө зогсоож чадаагүй тохиолдолд нөөц шүхрээ задлан түүний бүнхэрийг шиднэ.

1056. Шүхэрчин онгоцноос тасрах дүрмийг зөрчсөнөөс болж тогтворжуулагч шүхэр хөлд болон зэвсэг хэрэгсэлд орооцолддог ба энэ үед яаралтай арга хэмжээ авахгүй бол үндсэн шүхэр задрахгүй байж болно. Иймд тогтворжуулагч шүхрийг орооцолдоог гаргахын тулд хөлөө хол тэлэх хэрэгтэй. Энэ явдал амжилтгүй болсон тохиолдолд нөөц шүхрийг яаралтай задална.

1057. Үндсэн шүхрийн бүнхэр бүтэн задраагүй шинж тэмдгүүд:

1057.1. Тогтворжуулагч шүхрийн татах хүч үйлчлээгүй, эмх замбараагүй уналт, гар задаргааны татах бариул ажиллаагүй зэрэг нөхцөлүүдэд шүхэрчин нөөц шүхрийг ашиглах хэрэгтэй.

ЗУРГААДУГААР БҮЛЭГ

ОНЦГОЙ БАЙДЛЫН БАЙГУУЛЛАГЫН АЛБА ХААГЧДЫН АВТОМАШИНТАЙ ЗОРЧИХ, ДУУДЛАГА МЭДЭЭЛЭЛ, ТОМИЛОЛТООР АЖИЛЛАХ ҮЕД МӨРДӨХ АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ЗААВАР

Онцгой байдлын байгууллагын автомашин замын хөдөлгөөнд оролцох үеийн аюулгүй ажиллагаа

1058. Онцгой байдлын байгууллагын эзэмшлийн авто тээврийн хэрэгслийг хариуцаж, ашиглаж байгаа ажиллагсад, жолооч нар нь Тээврийн хэрэгсэл жолоодох, засвар үйлчилгээ хийх үеийн аюулгүй ажиллагааны зааварчилгаа, дүрэм журмыг мөрдөн аюулгүй байдлаа ханган ажиллана.

1059. Энэхүү заавраас гадна Монгол улсын Замын хөдөлгөөний дүрэм, “ОББ-ын дотоод журам, тушаал”, “Галын аюулгүй байдлын үндсэн дүрэм”, Хууль зүйн сайдын 2017 оны А/292 дугаар тушаал “Тээврийн хэрэгсэлд тусгай дуут болон гэрэл дохио тавьж хэрэглэх”, Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2017 оны дугаар 157 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт “Онцгой байдлын байгууллагын тээврийн хэрэгсэл ашиглах журам”-ыг дагаж, мөрдөнө.

1060. Гамшиг осол, гал түймрийн дуудлага, мэдээлэл, дадлага сургуулилт, орон нутгийн томилолт, томилгоот ээлж хүлээн авах, халалцах, автомашиныг хөдөлгөөн үйлдэх болон зогсох үедээ дуут дохио /сигнал/-г 3 удаа дуугаргах, их гэрлээр 3 удаа анивчуулах зэрэг үйлдлийг хийж аюулгүй байдлыг хангуулсны дараа жолооч хөдөлгөөнийг үйлдэнэ.

1061. Жолооч нь тухайн тээврийн хэрэгслийн ангилалд тохирсон жолоодох эрхийн үнэмлэхтэй, техникийн засвар, үйлчилгээ, оношилгоо хийх чадвартай, хариуцлагатай, ачаалал даах чадвартай, эрүүл мэндийн үзлэгт хамрагдсан, зохих ангиллын зөвшөөрөлтэй, 3-аас доошгүй жил мэргэжлээрээ ажилласан, дадлага туршлагатай алба хаагч байх бөгөөд замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль, дүрмийг чанд баримтлан, хөдөлгөөний аюулгүй байдлыг шууд хариуцан ажиллана.

1062. Тээврийн хэрэгсэл нь тээврийн хэрэгслийн даатгал, техникийн үзлэг, тооллогод хамрагдсан байх ба жолооч нь жолоочийн хариуцлагын, гэнэтийн ослын даатгалд даатгуулсан байна.

1063. Гамшиг осол, аврах ажиллагааны дуудлага, хөдөө орон нутагт томилолтоор ажилд гарахын өмнө “Тээврийн хэрэгслийг шалгах хуудас”-аар шалгуулан, шалгах механик, инженерээс аюулгүй ажиллагааны зааварчилгаа авч, гарын үсэг зурж баталгаажуулсны дараа ажилд гарна.

1064. Замд тухайн тээврийн хэрэгслээр явах цаг хугацаа 10-аас дээш цагаар үргэлжлэх, мөн сэлгээний жолоочгүй явахаар бол түр зогсож амрах, шөнө хоноглох газруудыг урьдаас тооцож төлөвлөсөн байх.

1065. Жолооч 4 цаг тутамд замд яваад доод тал нь 15 минут амрах шаардлагатай.

1066. Жолоочийг холын замд явж ирсний дараа 24 цаг амраахгүйгээр 8-аас дээш цагаар үргэлжлэх тээвэрт оролцуулахгүй.

1067. Албаны автомашиныг хувийн ашиг сонирхлоор ашиглахыг хориглоно.

1068. Тээврийн хэрэгслийн суудлын тооноос илүү хүн тээвэрлэхийг хориглоно.

1069. Албан томилолт /ажлаар/ нэгдсэн сургалт, дадлага, уралдаан, тэмцээнд оролцож буй алба хаагчид өөрсдийн аюулгүй байдлыг хангаж, согтууруулах ундаа, сэтгэцэд нөлөөлөх эм бэлдмэл ууж хэрэглэхийг хатуу хориглоно.

Автомашинтай цуваагаар хөдөлгөөн хийх үеийн аюулгүй ажиллагаа

1070. Цувааг ахлахаар заавал офицер томилох ба бүх албан хаагчид, тээврийн хэрэгслийг зохион байгуулан удирдаж явах бөгөөд хамгийн эхний болон сүүлийн тээврийн хэрэгсэл дээр “ЦУВАА” гэсэн тод бичлэгтэй байна.

1071. Цуваанд байр эзлэх дугаарыг (А4 хэмжээтэй) тээврийн хэрэгслийн ард болон урд талд харагдахуйцаар байрлуулж, оврын гэрлийг асаасан байна.

1072. Цуваа нь гүйцэж түрүүлэх, тойрон гарах, зүүн гар тийш буюу буцаж эргэхийн тулд байр эзлэхээс бусад тохиолдолд зорчих хэсгийн хамгийн баруун гар талын эгнээгээр явна.

1073. Тээврийн хэрэгсэл бүрт офицер, ахлагч нараас ахлах дарга томилох бөгөөд түүнд тухайн тээврийн хэрэгслийн бүх бүрэлдэхүүн, жолооч захирагдан ажиллана.

1074. Хөдөлгөөний үед гар болон суурин станцыг зөвхөн шаардлагатай үед зориулалтын дагуу ашиглана.

1075. Цуваа нь зөвхөн батлагдсан маршрутын дагуу явах ба зайлшгүй зогсох шаардлагатай үед аваарын гэрэл болон аюулгүй ажиллагааны торомз /кардан/ татаж зогсоно.

1076. Цуваанд тээврийн хэрэгслүүд ойрын гэрлээ асааж явна.

1077. Цуваанд яваа тээврийн хэрэгслийн хөдөлгөөний хурд болон хоорондын зай, зогсох, хөдөлгөөн эхлэх, үргэлжлүүлэхийг замын байдал, цаг агаарын нөхцөл, тээврийн хэрэгслийн байдалд тохируулан цувааны ахлагч тогтоох бөгөөд цувааны хурд нь Монгол Улсын Замын хөдөлгөөний дүрэмд заасан хэмжээнээс хэтрэхгүй байна.

1078. Цуваагаар яваа тээврийн хэрэгсэл зорчих хэсгийн баруун гар талын захаар нэг эгнээгээр явна.

1079. Түр зогсолтын үед зорчигчид замын зөвхөн баруун гар тал руу бууж бие хөнгөлнө.

1080. Цувааны ахлагчийн зөвшөөрөлгүйгээр цуваанаас гарах, гүйцэж түрүүлэх, цувааг тасалж хоцрохыг хориглоно.

Жолоочийн аюулгүй ажиллагаа

1081. Жолооч нь Монгол Улсын Замын хөдөлгөөний дүрмийг мөрдөж ажиллана.

1082. Жолооч өглөө ажилд гарахын өмнө масло, усны түвшнийг үзсэний дараа мотороо асааж бүх гэрлэн дохио, рулийн механизм, толь, тормозыг шалгасны дараа замын хуудас авч ажилд гарна.

1083. Заагдсан маршрут, объектод хуваарийн дагуу ажил үүргээ гүйцэтгэх ба зөвшөөрөгдөөгүй маршрут заагдаагүй ажилд явахыг хориглоно.

1084. Хурдыг дүрэмд заасны дагуу тохируулж явна.

1085. Ачааг ачиж буулгахдаа тухайн бараа материалыг хариуцсан мастер, няравт хүлээлгэн өгнө.

1086. Кузовын хогийг байнга цэвэрлэж ачааг ачиж байна.

1087. Овор хэмжээ томтой ачааг тээвэрлэхдээ дүрэмд заасны дагуу дарцаг анхааруулах, хамгаалах дохио тэмдгийг хэрэглэнэ.

1088. Халтиргаатай, үзэгдэх талбай хязгаарлагдмал үед анхаарал болгоомжтой явах, хурд, хоорондын зайг дүрэмд заасны дагуу тохируулж явна.

1089. Орой ажлаас бууж машиныг гражид тавихдаа галын болон ямар нэгэн аюулын үед саадгүй байхаар байрлуулж бүхээгийн хаалгыг түгжиж харуулд түлхүүрээ өгч машиныг хүлээлгэн өгнө.

1090. Машинд ачаа ачихдаа бүхээгээс заавал гарч ачна.

1091. Дугуйнд засвар хийхдээ демократын хажуугаар бат бөх тулгуур хийж дугуйн хойд урд талд заавал ивээс хийнэ.

1092. Тогтоосон ачааны даацаас хэтрүүлэн ачаа ачих, өргөхийг хориглоно.

1093. Засвар хийхдээ тохирсон зориулалтын багаж түлхүүрийг хэрэглэхээс гадна гэмтэлтэй багаж хэрэглэхийг хориглоно.

1094. Өвлийн цагт моторыг гэсгээх шаардлагатай тохиолдолд ил галаар галлахыг хориглоно.

1095. Авто машинд гагнуур хийх нөхцөлд аккумуляторыг заавал салгана.

1096. Машиныг зогсоох үед арааг салгаж, түлхүүрийг сугална.

Эрэн хайх, аврах ажиллагааны дуудлагаар гарах үеийн аюулгүй ажиллагаа

1097. Эрэн хайх, аврах ажиллагааны дуудлагаар болон томилолтоор ажилд гарахдаа хувийн бэлтгэлээ сайтар базааж, хамгаалах бүсийг хэрэглэх үүрэгтэй ба зорчигчдыг хамгаалах бүсийг зөв зүүж хэрэглүүлнэ.

1098. Цасанд дарагдсан газар орны байдал, хүчтэй салхи, шуургатай үед гэр, хашаа, саравч, барилга байгууламж нурж эвдэрснээс мод, чулуу, тоосгонд цохиулан гэмтэж бэртэхээс сэргийлж, байрлах газраа зөв сонгож, зам гарцын байдлыг урьдчилан судалж, явах чиглэлийг заах, аюултай газрыг тэмдэглэнэ.

1099. Халтиргаатай зам дээр гэнэт огцом тоормос гишгэх болон хурдаа огцом авахгүй байх, жолооны хүрдийг огцом эргүүлэхгүй байх, тов толгод, уулын уруу авцуулах холбоог салгахгүйгээр хурд багатай уруудах, шаардлагатай үед 4 дугуйгаараа маажих /мост залгах/, үзэгдэх орчин хязгаарлагдсан үед машины их гэрлийг асаах бөгөөд хэрэв зам, орчин сайн харагдахгүй бол тээврийн хэрэгслийг зогсоох, тээврийн хэрэгслийг зогсоол дээр орхихоосоо өмнө түүний аюулгүй байдлыг ханган хариуцсан жолоочоос нь өөр хүн хөдөлгөхөөргүйгээр тавина.

1100. Цацраг идэвхт ачааг тээвэрлэх автомашины жолооч нарт үйлчилгээнд гарахын өмнө аюулгүй ажиллагааны зааварчилгаа өгч хамгийн аюулгүй, оновчтой чиглэлийг тогтоож, тусгай тоноглогдсон автомашинаар тээвэрлэнэ.

1101. Аюултай хортой бодис ачсан жолооч уг барааг 2 талын толинд үргэлж хянаж, ажиглаж тээвэрлэлтийн даац ихтэй үед машины хурд 50 км/цагаас хэтрүүлэхгүйгээр явна.

1102. Тээврийн хэрэгсэл цаг ямагт аюулгүй ажиллах ёстой. Ялангуяа тээврийн хэрэгслийн хурдыг тухайн замын нөхцөл байдал, үзэгдэх орчин, цаг агаар зэрэг орчны нөхцөл байдлаас хамааруулан сонгохдоо маш их анхаарах ёстой. Тухайлбал халтиргаатай зам, эргэлт тойруу гэх мэт. Хурдны тэмдгийн хязгаарыг хэзээ ч хэтрүүлж болохгүй.

1103. Тээврийн хэрэгслийн хажуу болон хойд талуудыг шалгаж, ямар нэгэн объект, хүн эсвэл бусад тээврийн хэрэгсэл байхгүй байгааг магадалж, анхааруулах дохио өгсний дараа ухрах үйлдлийг хийнэ.

Ой, хээрийн гал түймрийн дуудлагаар ажиллах үед

1104. Дуудлага мэдээллээр явж буй автомашины жолооч нь цаг агаарын нөхцөл байдал, үзэгдэх орчин, автомашины даац, замын нөхцөл байдлаас хамааруулан тээврийн хэрэгслийн хурдыг тохируулна.

1105. Жолооч нь түймэр унтраахад газар орны байдлыг ашиглах боломж, салхины хурд, чиглэл, өвсний болон уулын өндөр, намыг харгалзан гал унтраах арга, тактикийг гал түймэр унтраах удирдагчаас сонсож мэдэн, түр амрах аюулгүй байрлал, түүнд хүрэх замыг сонгон тогтоож автомашин, техникээ аюулгүй газар байрлуулна.

1106. Ойн зах, гал түймрийн зурваст түймэр унтраах автомашин техник, багаж хэрэгсэл хүргэх, шатлагийг зогсоож унтраах зам гарц байгаа эсэх, байгалийн усны хүрэлцээ, ойртож очих замыг ашиглах бололцоо байгаа эсэхийг анхаарч байрлуулах.

1107. Дуудлагаар явах үед автомашиныг бүхээгт болон тээшин дээр тоног төхөөрөмж, багаж хэрэгслийг тээвэрлэхдээ хөдөлгөөнгүй бэхэлж аюулгүй байдлыг хангана.

1108. Хориглох зүйлс:

1108.1. Монгол улсын Замын хөдөлгөөний дүрмийн дөрөвдүгээр хавсралтад заагдсан “Тээврийн хэрэгслийн ашиглахыг хориглох эвдрэл, гэмтэл, техникийн зөрчил”-тэй тээврийн хэрэгслээр хөдөлгөөнд орох,

1108.2. Алба хаагчид нь тээврийн хэрэгсэл жолоодох, түүгээр зорчих, ажиллагаанд явах үедээ согтууруулах ундаа, мансууруулах бодис, сэтгэцэд нөлөөлөх эм бэлдмэл хэрэглэх,

1108.3. Тэсрэх бодис, тэсэлгээний материалыг ачиж, буулгахдаа цохиж доргиох, хаяж шидэх, эдгээр материалыг хадгалж байгаа газраас 100 м-ээс дотогш зайд гал гаргах тамхи татах,

1108.4. Хөдөлгүүр нь асаалттай тээврийн хэрэгслийн бүхээг дотор амрах, унтах,

1108.5. Хөдөлгүүр ажиллаж байхад буюу дугуйны ивүүр хийгээгүй тээврийн хэрэгслийн доогуур орж ямар нэгэн засвар, үйлчилгээ хийх,

1108.6. Түймрийн ойролцоо унтаж, амрах, түймрийн цурмын дотуур зам товчилж явах, хөрсний гүний түймрийн хил хязгаарыг урьдчилан тогтоосон тэмдэглэгээнээс дотогш нэвтрэх, нийлэг эдлэлээр хийсэн хувцас хэрэглэх хөвч, тайгын намгархаг газар ганцаараа автомашин техникээ орхиж явах,

1108.7. Авто тээврийн хэрэгслийг хариуцаж байгаа ажилтан тээврийн хэрэгслийг бусад хүнд шилжүүлэхгүй, ахлах даргын зөвшөөрөлгүй хөдөлгөөн үйлдэх,

1108.8. Тээврийн хэрэгсэл жолоодож буй жолооч тасралтгүй 10 цагаас дээш хугацаагаар тээврийн хэрэгсэл жолоодох,

1108.9. Хөдөлгөөнд оролцох үедээ гарын оролцоотой утсаар ярих, ашиглах,

1108.10. Цуваагаар хөдөлгөөн үйлдэж байх үед зөвшөөрөлгүйгээр цуваанаас түрүүлэх, хоцрох, гарч явах, хоноглох үед өөр газар буудаллах,

1108.11. Үзлэг хийж туршаагүй мөсөн дээгүүр төрөл бүрийн тээврийн хэрэгслээр шууд гарах, ан, цав, халиа гарсан мөсөн замаар тээвэр хийх, цасан шуурга манантай үед мөсөн дээгүүр явах.

1109. Мөсөн дээгүүр явж байгаа тээврийн хэрэгслийг огцом зогсоох, гүйцэж түрүүлэх, ширүүн бороо, үер, цас, будан, манан, цөн түрэлт, давлагаатаа үед гол гатлах, бүрэн бус тээврийн хэрэгслээр гол гатлах, аккумулятор, түүнээс гарсан цахилгаан дамжуулах зохицуулах тоноглолууд усанд норхоор байвал гол гатлахыг хатуу хориглоно.

1110. Гамшиг, ослын дуудлагаар яваа алба хаагчид автомашины бүхээгт тамхи татахыг хатуу хориглоно.

1111. Орон нутагт томилолтоор яваа үед үзэгдэх орчин хязгаарлагдмал үед хөдөлгөөн үйлдэхийг хатуу хориглоно.

Дадлага, сургалт хийх, гал түймрийн дуудлагаар хүрэлцэн очих, буцах аюулгүй ажиллагаа

1112. Тусгай дохиогоор бие бүрэлдэхүүн баганаар доош буухдаа өмнөх хүнээ бууж баганаас холдсоны дараа, аюулгүй байдлыг хангаж бууна. Баганаар бууж байгаа хүн газардмагц баганаас даруй холдоно.

1113. Тусгай дохиогоор томилгоот ээлжийн бүрэлдэхүүн цугларч тавиулангаас гал түймэр унтраах дүрэмд заасны дагуу хамгаалах тусгай хувцас, хэрэгслийг бүрэн өмсөж, автомашин тавиулангаас энэ дүрмийн 6 дугаар бүлгийн 1093 дахь заалтыг хэрэгжүүлэн хөдөлгөөний аюулгүй байдлыг хангаж гарсны дараа богино хугацаанд автомашинд сууна.

1114. Гал унтраах автомашинд бие бүрэлдэхүүн бүрэн сууж бүхээгийн хаалга хаасны дараа хөдөлгөөнийг эхэлнэ.

1115. Гал унтраах автомашины жолооч замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль, дүрмийг чанд баримтлан, хөдөлгөөний аюулгүй байдлыг шууд хариуцна.

1116. Гал түймэр унтраах, аврах ангийн салааны захирагч, туслах, тасгийн дарга замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль, дүрмийг мэдэж, замын хөдөлгөөнд оролцох үед гал унтраах автомашины жолоочид замын хөдөлгөөний дүрмийн шаардлагыг биелүүлж байхыг анхааруулж явах үүрэгтэй.

1117. Гал унтраах автомашиныг шөнийн цагт байрлуулж ажиллах, ирэх, буцах замд аюулгүй байдлыг хангаж тусгай гэрлэн дохиог заавал асаана.

1118. Гал түймэр унтраах, аврах дадлага, сургууль хийх, гал түймрийн дуудлагаар хүрэлцэн очих, буцахад хориглох зүйлс.

1118.1. Гал унтраах автомашин замын хөдөлгөөнд оролцох үед бие бүрэлдэхүүн тамхи татах, цонхоор биеийн хэсгийг гадагш ил гаргах, хаалга онгойлгох, гишгүүр дээр зогсож явахыг хатуу хориглоно.

ДОЛООДУГААР БҮЛЭГ

УЛСЫН НӨӨЦИЙН БАРАА, БҮТЭЭГДЭХҮҮН АЧИХ, БУУЛГАХ ҮЕИЙН АЮУЛГҮЙ АЖИЛЛАГАА

Шатахууны нөөцийн салбарт мөрдөх аюулгүй ажиллагаа

1119. Шатахууны нөөцийн салбарын алба хаагчид нь “Нефть баазын техник ашиглалтын дүрэм”, “Галын аюулгүйн үндсэн дүрэм” болон хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дүрэм, аюулгүйн техникийн заавар, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, материалуудтай ажиллах дүрмийн шаардлагыг хатуу мөрдөж ажиллана.

1120. Нефть бүтээгдэхүүн асгарсан газруудыг нэн даруй цэвэрлэж элсээр дарж, хаягдал хог навч, хуурай ургамлыг агуулахын нутаг дэвсгэрээс холдуулж тогтоосон хогийн цэгт хаяж байх.

1121. Шатахууны агуулахаас гадагш 200 м-ийн дотор болон нутаг дэвсгэр, үйлдвэрлэлийн цех, тасгуудад тамхи татахыг хориглох бөгөөд зөвхөн тусгай зориулалтын байранд тамхи татахыг зөвшөөрнө.

1122. Шатахууны агуулахын нутаг дэвсгэр дээр чүдэнз, лаа, керосины дэнлүү зэрэг ил гал, дөл гаргах, гэрэлтүүлгийн хэрэгсэл ашиглах, хог хаягдал шатаахыг хатуу хориглоно. Шатахуун тосолгооны материалыг хүлээн авах, түгээх шахах станц, ачих, буулгах байгууламж, жижиглэн савлах, торх угаах газар зэрэг шатах, тэсрэх аюултай газарт шөнийн цагаар болон ажлын үед зөвхөн тэсрэлтээс бүрэн хамгаалагдсан цэнэг хураагчийн гэрэлтүүлэг ашиглахыг зөвшөөрнө.

1123. Шатахуун хадгалах агуулах, шугам хоолой, худаг, шатахуун, тос савлах байр, шахах станц зэрэг тэсрэх холимог үүсдэг газарт засвар хийхдээ оч үсэргэдэггүй өнгөт металлээр хийсэн түлхүүр багажийг хэрэглэнэ. Тусгай зориулалтын түлхүүр багаж байхгүй тохиолдолд жирийн түлхүүрийг өтгөн тосоор тослон ашиглаж болох бөгөөд түлхүүрээр боолт, эрэг чангалах, суллах үед уртасгагч зэрэг хүч нэмэгдүүлсэн хөшүүрэг хэрэглэхийг хориглоно.

1124. Шугам хоолой, хаалтыг заагдсан хугацаанд тогтмол тосолж, түргэн нээгддэг, хаагддаг нөхцөлийг бүрдүүлсэн байна. Хаалтыг нээх, хаах зориулалтаар төмөр лоом, труба зэрэг хөших материал хэрэглэхийг хориглоно.

1125. Шатахууны агуулах дээр хийгддэг гагнуурын болон ил гал гаргасан ажлыг зөвхөн зориулалтын талбайд хийх бөгөөд энэ талбайгаас бусад газарт ажил гүйцэтгэх бол Гал түймрийн улсын хяналтын байцаагчаас албан ёсны зөвшөөрөл авч, гал түймэр унтраах багаж хэрэгслийг бэлэн болгосны дараа гүйцэтгэнэ.

1126. Шахах болон бусад төхөөрөмжийн эргэлтийн эд ангиудын хэсэгт зориулалтын хамгаалалт хийгдсэн байхаас гадна насос эргэлтийн механизмыг хамгаалалтгүй ашиглах, насос ажиллаж байгаа үед хөдлөх эд ангиудыг тослох, засварлахыг хориглоно.

1127. Резервуар, шугам хоолой, ачих, буулгах зогсоол, цахилгаан тоног төхөөрөмж, цахилгаан дамжуулах агаарын шугамын тулгуур багана, өндөр яндан зэрэг нефть агуулахын тоног төхөөрөмж, байгууламжуудыг үрэлтийн цахилгаанжилт, аянгаас хамгаалж газардуулга, аянга зайлуулагчаар тоноглоно.

Автоцистернд нефть бүтээгдэхүүн ачиж буулгах үед газардуулгыг байнга хэрэглэхээс гадна ачиж, буулгах хоолой, шатахуун түгээгүүрийн хушууг заавал газардуулна.

1128. Резервуар саванд хэмжилт хийх, дээж авах зэргээр өндөрт авирах, ажиллах үед шаардлагатай тоног төхөөрөмжийг тусгай зориулалтын уут, саванд хийж явахаас гадна дээжийг бариултай модон сав, цүнхэнд хийнэ.

1129. Аврах гарц, зориулалтын хаалгыг ажлын цагаар цоожилж түгжихийг хориглоно.

1130. Ажлын үед зөвхөн тусгай хувцас гутлыг хэрэглэнэ.

1131. Улсын нөөцийн газрын тосны бүтээгдэхүүн хадгалах агуулах, шатахуун түгээх станцын ажлын байранд мөрдөх аюулгүй ажиллагаанд Эрдэс баялаг, эрчим хүчний сайдын 2010 оны 257 дугаар тушаалаар батлагдсан үлгэрчилсэн зааврыг мөрдөнө.

Ачих, буулгах ажил гүйцэтгэх аюулгүй ажиллагаа

1132. Ачиж, буулгах ажлыг, өргөж тээвэрлэх механизм ба ачааны ачааллыг даах чадвартай, хатуу тэгш хучилттай тусгаарлагдсан талбайд гүйцэтгэнэ.

1133. Ачиж, буулгах ажлын байр нь орон сууцны барилгаас мөрдөж байгаа нормын дагуу аюулгүй ажиллагааны хамгаалалтын бүсээр тусгаарлагдсан байна.

1134. Ачиж, буулгах талбай дээр ачаа хурааж, өрөх байрны хязгаар болон ачаа хоорондуур нэвтрэх гарцыг тэмдэглэж үзүүлсэн байна.

1135. Битүү агуулахад ачиж, буулгах ажлыг гүйцэтгэх орчны агаарын найрлага дах тоос, хортой бодисын хэмжээ нь стандартад заасан зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс хэтрэхгүй байна.

1136. Ачиж, буулгах ажлыг гүйцэтгэгч нь ариун цэврийн болон ахуйн байр цэвэр усаар хангагдсан байна.

1137. Автомашин, авто ачигч дээр ажиллахаар хуваарь авсан ажилчид нь автомашин, авто ачигчийн гишгүүр дээр зогсох буюу ачсан, өргөсөн ачаан дээр суух, зогсож явахыг хатуу хориглоно.

1138. Өргөгч цамхаг дээр ажиллаж байгаа ажилчид нь ямагт хамгаалалтын малгайтай ажиллана.

Савтай буюу ширхгийн ачааг ачиж, буулгах аюулгүй ажиллагаа.

1139. Ачих, буулгах ажлын үед хайрцгийн гадна тал дээрх үсгэн болон зурган тэмдэглэгээ, анхааруулга санамжийг мөрдөж ажиллана.

1140. Бүтэн хайрцаг савтай ачааг тогтвортой хураалга хийж өгнө. Хураах өндөр нь 3 м-ээс илүүгүй байна. Механизмаар хураахдаа хураасан бараа, материал тогтвортой байвал 6 м хүртэл нэмэгдүүлж болно.

1141. Хураасан бараа, материалаа тогтвортой болгохын тулд ёроолын үеийг хооронд нь бага зайтай тавьж дээш нь ойртуулан шахаж хураана.

1142. Шуудай савтай барааны хураалтын өндөр нь 12 үе байна. 7-оос дээш үенд шуудайтай ачааг хүргэхдээ 1 м-ээс доошгүй өргөнтэй дамнуурга хэрэглэнэ.

1143. Хураалгыг задлах буюу буулгахдаа хэвтээ үе үеэр нь дэс дараатайгаар хэт огцом үе гаргахгүйгээр авна.

Урт болон хүнд ачааг ачиж, буулгах аюулгүй ажиллагаа.

1144. Урт болон хүнд ачааг өргөгч цамхаг болон авто ачигчаар ачиж, буулгах ба зөөх ажлыг хийнэ.

1145. Өргөгч цамхагаар урт болон хүнд ачааг ачих, буулгах үед найдвартай бэхэлгээг хэрэглэн өргөх ба дэгээтэй олсоор ачаанаас оосорлон ачаанд хийнэ.

1146. Хүнд ачааг налуу хавтгайг ашиглан буулгаж болно. Буулгах үед уг ачааны мөр дээр зогсож ажиллахыг хориглоно.

Торхтой болон өнхрүүлж болох ачааг ачиж, буулгах аюулгүй ажиллагаа.

1147. Торхтой болон өнхрүүлж болох барааг тэгш газарт өнхрүүлж шилжүүлж болно. Хэрэв дээрээс нь доош буулгах, дороос нь дээш гаргах үед заавал налуу дамнуурга ашиглавал зохино.

1148. Налуу дамнуурга ачааны өргөнд таарсан, ачааг найдвартай даах бөх, бат хийгдсэн байна.

Хүнсний бараа, бүтээгдэхүүн ачиж, буулгах үеийн аюулгүй ажиллагаа

1149. Хүнсний бараа, материал ачих, буулгах үед ачигч, жолооч нарт об'ектод мөрдөх галын аюулгүй байдлын болон хөдөлмөрийн аюулгүй байдлын зааварчилгаа өгч, гарын үсэг зуруулж хяналт тавин ажиллана.

1150. Ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгслийг зориулалтын дагуу хэрэглэх.

1151. Өөрийгөө болон бусдыг аюул эрсдэлд учруулахгүй байхаар ачих.

1152. Ачиж, буулгах ажлыг зориулалтын өргөх, тээвэрлэх тоног төхөөрөмж болон механикжсан хэрэгслийн тусламжтайгаар гүйцэтгэнэ.

1153. Ачааг гараар өргөх, зөөх үед түүний аюулгүй ажиллагааны талаар мөрдөж байгаа дүрэм, журам, зааврыг биелүүлж ажиллах ба өргөх ачаа нь MNS4970-2000 стандартад заасан норм, хэмжээнээс хэтрэхгүй байна.

1154. Ачиж, буулгах ажлыг технологийн карт, заавар, тухайн ажлыг гүйцэтгэх үед тавих аюулгүй ажиллагааны шаардлагыг тусгасан дүрэм, журам, норматив техникийн баримт бичгийн дагуу гүйцэтгэнэ.

1155. Ачиж буулгах ажлын байранд анхааруулга, дохио, аюулгүй ажиллагааны тэмдэг тавигдсан байна.

1156. Ачиж, буулгах ажлын байранд замын хөдөлгөөний тэмдгүүдийг байрлуулж, тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг зохицуулсан байна.

1157. Ачиж, буулгах ажлын байрны ажлын бүсийн агаар дахь хортой хий, уур, тоосны хэмжээ нь MNS 4990-2015-д заасан зөвшөөрөгдөх хэмжээнээс хэтрэхгүй байвал зохино.

1158. Хураалтын өндөр нь 1.2 м хүртэлх ачааг краны буюу төмөр замын ачаан талын зам, төмрийн гаднах ирмэгээс 2.0 м-ээс багагүй зайд, хураалтын өндөр 1.2м-ээс их үед 2.5м зайд хураавал зохино.

Сэрээт өргөгч ажиллуулах үеийн аюулгүй ажиллагаа

1159. Сэрээт өргөгч механизмыг ажиллуулж эхлэхийн өмнө аюулгүй ажиллагааг шалгах.

1160. Сэрээт өргөгч механизмыг хөдлөхөөс өмнө орчин тойрноо шалгасан байх.

1161. Сэрээт өргөгч механизмын толийг сайн арчсан байх.

1162. Сэрээт өргөгч механизмд жолоочоос өөр хүн хамт суухгүй байх.

1163. Ачааг өрж хураахад дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:
1163.1. ачааны багц, түүний өрөлтийн тогтвортой байдал,
1163.2. өргөх төхөөрөмжийн аюулгүй ажиллагаа,
1163.3. өрөлт түүний дэргэд ажил гүйцэтгэгчдийн аюулгүй ажиллагаа,
1163.4. галын техник хэрэгсэл, түүнийг ажиллуулагчийн хамгаалах хэрэгсэл,
1163.5. битүү агуулахын ердийн ба зохиомол салхижуулалт, агаарын солилцоо шалгасан байна.

1164. Ачааг өргөх буюу шилжүүлэхийн өмнө ачааны тогтвортой байдал, оосорлолт нь зөв эсэхийг шалгасан байна.

1165. Ачааг тээврийн хэрэгсэлд ачих, буулгах, өргөж, тээвэрлэх төхөөрөмжөөр шилжүүлэх үед ачаа унаж болох бүсэд тээврийн хэрэгсэл явах ба хүн ажиллахыг хориглоно.

1166. Үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж, түүнийг бүрдүүлэх хэсгүүд нь оосорлоход тохиромжгүй хийцтэй бол өргөх зөөвөрлөхөд шаардагдах тусгай хэрэгслээр хангагдсан байна.

1167. Үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж нь цахилгаан статик цэнэгийг аюултай хэмжээгээр хуримтлуулахгүй байх ёстой.

1168. Үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийн ажил гүйцэтгэх хэсэг, мөн хамах, хавчих, өргөх, зөөх төхөөрөмжүүд нь тэдгээрийг ажиллуулах эрчим хүчний эх үүсвэр (цахилгаан гүйдэл, шингэн, шахагдсан хий гэх мэт) нь тасарснаас үүсэх аюул ослоос урьдчилан хамгаалах эрчим хүчний эх үүсвэрийг дахин залгах үед эдгээр төхөөрөмжүүд өөрөө залгагдахгүй хэрэгслээр тоноглогдсон байвал зохино.

1169. Үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж нь хэт өндөр, хэт богино давтамжтай дуу шуугиан, доргилтгүй байх, эсвэл тэдгээрийн түвшинг тогтоосон хэмжээнд хүртэл бууруулах боломжтойгоор хийгдсэн байвал зохино.

Хүнсний бараа, бүтээгдэхүүн хураах үеийн аюулгүй ажиллагаа

1170. Нуранги ачааг тухайн ачааны гулсалтын өнцгөөс багагүй налуутай буюу бэх бат хийцийн хаалтаар хашиж хураасан байна.

1171. Нуранги ачааг механикжсан аргаар ачиж буулгах ба нуралт үүсэхээс болгоомжлон овоолж хураасан ачааг хөндийлж ухахыг хориглоно.

1172. Ачааг хураахдаа шахагдаж гэмтэхээс хамгаалсан байна.

1173. Тасралтгүй ажиллагаатай машин механизмаар ачааг ачих, буулгах ажлыг гүйцэтгэх үед:

1173.1. Ачааны өрөлт нь ажлын хэсгүүдэд жигд ачаалал өгөх ба ачааны тогтвортой байдлыг хангасан байх,

1173.2. Тээвэрлэлтийн үед ачаа унах, холилдох, гэмтэх явдал гаргахгүйн тулд тэдгээрийг зөв байрлуулж, бэхэлсэн байвал зохино.

1174. Савтай ширхгийн ачааг ачих, буулгах үед чингэлэг болон бусад төрлийн багцлах хэрэгслийг ашиглана. Багцлагдсан ачаа нь бэхлэгдсэн байна.

1175. Ачааны физик, химийн чанарт нөлөөлөх цаг уурын өөрчлөлтийн үед ачиж, буулгах ажлыг зогсоох буюу ажил явуулах аюулгүйн нөхцөлийг бүрдүүлэх арга хэмжээг авна.

1176. Амьтан, түүхий эд ба амьтны гаралтай бүтээгдэхүүнийг ачиж, буулгах ажлыг зөвхөн ачааны шинж чанарын тодорхойлолт байгаа тохиолдолд гүйцэтгэнэ.

Ажил эхлэхийн өмнө ачааг мал эмнэлгийн хяналтын байгууллагаар шалгуулсан байна.

1177. Хорио, цээрийн үзлэг хийх шаардлагатай ачааг ачих, буулгах, шилжүүлэхдээ ариун цэврийн шаардлагыг хангасан тусгай талбайд гүйцэтгэнэ.

1178. Амьтан, түүхий эд ба амьтны гаралтай бүтээгдэхүүнийг ачих, буулгах ажлыг гүйцэтгэсний дараа ажлын байр, эд хогшил оосорлох, хамгаалах хэрэгслийг ариутгасан байна.

1179. Бараа материалыг галын аюул дамжихгүйгээр хоорондоо зайтай болон хөдөлгөөнд саадгүйгээр хураах.

1180. Ачиж буулгах ажлыг, өргөж тээвэрлэх механизм ба ачааны ачааллыг даах чадвартай, хатуу тэгш хучилттай тусгаарлагдсан талбайд гүйцэтгэнэ.

1181. Ачиж, буулгах ажлын байр нь орон сууцны барилгаас мөрдөж байгаа нормын дагуу аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн хамгаалалтын бүсээр тусгаарлагдсан байна.

1182. Ачиж, буулгах талбай дээр ачаа хурааж өрөх байрны хязгаар болон ачаа хоорондуур нэвтрэх гарцыг тэмдэглэж үзүүлсэн байна.

1183. Ачиж буулгах ажлын байр, ачааны хоорондуур нэвтрэх гарц нь MNS 4996-2000 стандартад заасны дагуу хүрэлцэх хэмжээний байгалийн болон зохиомол гэрэлтүүлэгтэй байна. Гэрэлтүүлэг нь жигд тусгалтай байх ба ажил гүйцэтгэгч нарт гялбуулах нөлөө үзүүлэхээргүй байна. Саравчтай агуулахуудад байрлуулах гэрэлтүүлэх хэрэгслийг ачааны онцлог ба орчны нөхцөлийг харгалзан сонгож авна.

1184. Битүү агуулахад ачиж, буулгах ажлыг гүйцэтгэх орчны агаарын найрлага дахь тоос, хортой бодисын хэмжээ нь MNS-4990-2015-д заасан зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс хэтрэхгүй байна.

1185. Ачиж буулгах ажил явуулах, өргөж тээвэрлэх тоног төхөөрөмж нь MNS 4930-2000 стандартад заасан аюулгүй ажиллагааны шаардлагыг хангасан байна.

1186. Краны ашиглалтын паспортад заасан зөвшөөрөгдөх хэмжээнээс салхины хурд хэтэрсэн үед, ачаа өргөх краныг ажиллуулахыг хориглоно.

1187. Ачаа буулгах үед өргөж тээвэрлэх тоног төхөөрөмж, тээврийн хэрэгслийг өөрөө хөдөлж шилжихгүйгээр байрлуулсан байна.

Өвс тэжээлийн агуулахад мөрдөх аюулгүй ажиллагаа

1188. Ажилд гарахын өмнө хамгаалах тусгай хувцас, хүн нэг бүрийн хамгаалах хэрэгслийг зориулалтын дагуу бүрэн өмссөн байх. Хувцас нь машин, техниктэй харьцахад саад болохгүй, элдэв уяа, төмөр тоноглолгүй байх.

1189. Биедээ хурц үзүүртэй зүйл авч явахыг хориглоно.

1190. Нөөцийн бараа, материал хадгалагддаг бүсэд тамхи татах, ил гал гаргахыг хатуу хориглоно.

1191. Автомашинд өндөр ачигдсан өвс, тэжээл дээр суухгүй, өвс тэжээл дээрээс үсрэхийг хориглоно. Автомашины бүхээгийн гишгүүр дээр зүүгдэж явахгүй байх.

1192. Автомашин агуулахад орох, гарах, хөдөлгөөн үйлдэх үед өөрийгөө болон бусдыг аюул, эрсдэлд учруулахгүй байх.

1193. Тэжээлийн агуулах, талбайд тавигдсан мэрэгчийн хорыг тараахгүй байх, хор болон хордсон мэрэгчтэй бээлийтэй гараар харьцаж, зориулалтын саванд хийж устгах.

1194. Ажлын байранд ашиглагдаж байгаа машин техник, тоног төхөөрөмжийн аюулгүй байдал, техникийн бүрэн бүтэн байдалд байнга үзлэг шалгалт хийж, аюулгүй байдлыг хангасан нөхцөлд ажиллах.

1195. Галч нар үнс нурмаа ил задгай асгахгүй, галын аюулаас болгоомжилж ажиллах.

1196. Албан хаагч, ажилчид цахилгааны шитэд зөвшөөрөлгүй нэвтрэн орж, залгаж салгахыг хатуу хориглоно.

1197. Харуулын байр, агуулах, саравчны цахилгаан хэрэгсэл, гэрэлтүүлгийг асаалттай орхихыг хатуу хориглоно.

1198. Анги, салбар, цэгийн байршил руу нэвтэрч буй тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг 8км/цагаас хэтрүүлэхгүй байх.

НАЙМДУГААР БҮЛЭГ ТУСГАЙ ХУВЦАС, ХЭРЭГСЛИЙН ТУРШИЛТ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ҮЕИЙН АЮУЛГҮЙ АЖИЛЛАГАА

Хөдөлмөрийн аюулгүй байдлын ерөнхий шаардлага

1199. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, дүрэм, стандарт, технологийн горим, зааварчилгааг чанд мөрдөнө.

1200. Ажил эхлэхийн өмнө тоног төхөөрөмжийн эд ангийн бүрэн бүтэн байдлыг тогтмол шалгаж, гэмтэл доголдол илэрвэл засварчнаар засуулна.

1201. Цахилгаан төхөөрөмжид нойтон гараар хүрэх, төхөөрөмжийг нойтон чийгтэй зүйлээр арчих, ойр орчимд ус асгахыг хориглоно.

1202. Цахилгааны ямар нэг гэмтэл, эвдрэл бүхий тоног төхөөрөмж дээр ажиллахыг хориглоно.

1203. Машин тоног төхөөрөмжтэй болгоомжтой харьцах, гэмтэл бэртэл авсан тохиолдолд ажил үүргээ гүйцэтгэхийг зогсоож, нэн даруй удирдах ажилтанд мэдэгдэнэ.

1204. Тухайн ажилбарт шаардлагагүй эд зүйлсийг тоног төхөөрөмж дээр байрлуулахыг хориглоно.

1205. Ажлын байранд хүний анхаарал сарниулахаар чанга ярих, дуу чимээ гарах, чихэвчтэй хөгжим сонсох, хоорондоо ярих, ноцолдох, хөөцөлдөх, гүйхийг хатуу хориглоно.

1206. Хувийн эрүүл мэндийн байдал муудсан, алжааж ядарсан үед ажил үүрэг гүйцэтгэхийг зогсоож, удирдах ажилтанд мэдэгдэнэ.

1207. Өөрийгөө болон бусдыг аюул, эрсдэлд оруулахгүй байх, амь нас эрүүл мэндэд сөрөг нөлөөлөх нөхцөлд аюулгүй байдлын дүрэм, журмын дагуу шуурхай арга хэмжээ авна.

1208. Гал гарсныг харсан, мэдсэн хэн боловч яаралтай Онцгой байдлын албаны /101/ тоот утсанд дуудлага өгч, удирдах хүмүүст мэдэгдэнэ.

1209. Ажилтан бүр гал унтраагуурыг ашиглаж чаддаг, түүний ажиллах зарчим, бүтцийг мэддэг байх шаардлагатай.

1210. Архи, согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн, мансуурсан, эрүүл мэндийн хувьд чадавхгүй болсон тохиолдолд ажил, үүрэг гүйцэтгэхийг хориглоно.

Эрүүл ахуйн ерөнхий шаардлага

1211. Албан хаагч бүр ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгслийг зориулалтын дагуу өмсөж хэрэглэнэ.

1212. Ажилчдын хувцас солих болон ариун цэврийн өрөөтэй байна.

1213. Гадна орчны цаг агаарын өөрчлөлтөөс үл хамааран үйлдвэрийн цех тасгийн агаарын хэм 18- 20оС -аас доошгүй, агаарын харьцангуй чийглэг 30-60% байвал тохиромжтой.

1214. 1 хүнд ноогдох талбай 2,5 м.кв байна.

1215. Ариун цэврийн өрөөний 1 хүнд ноогдох хэмжээний өргөн нь 0,9 м-ээс доошгүй, урт нь 1,2 м-ээс доошгүй байна. 15 хүн тутамд 1 ариун цэврийн өрөөтэй байна.

1216. Ариун цэврийн өрөөний үүдний хэсэгт угаалтуур, шингэн саван, гар арчих зориулалтын цаастай, толь, хогийн сав, үнэр дарагч суурилуулсан байна.

1217. Ажилтанд зориулсан хоолны болон амралтын тусгай өрөөтэй байж болно.

1218. Цех тасгуудыг өдөрт 2-3 удаа хог авч, чийгтэй цэвэрлэгээ хийж, 14 хоногт 1-ээс багагүй удаа их цэвэрлэгээ хийх ба ажлын цаг дууссаны дараа халдваргүйтгэлийн бодис, уусмалаар зориулалтын дагуу халдваргүйжүүлнэ.

1219. Үйлдвэр нь хэт халсан, чийгтэй, тоостой агаарыг зайлуулах цэвэр агаарыг оруулах агааржуулалтын системтэй байна.

1220. Ажлын байрны гэрэлтүүлэг MNS6767:2019 стандартад нийцсэн байна.

Оёдлын тоног төхөөрөмжтэй ажиллах аюулгүй ажиллагааны зааварчилгаа

1221. Оёдлын машинд засвар үйлчилгээ хийх /зүү солих, дамар солих, утас сүвлэх, боолт чангалах, цэвэрлэх, тослох/ үед цахилгаан залгуурыг салгасан байна.

1222. Оёх ажиллагааг эхлүүлэхдээ машины хурд тохируулагч гишгүүрийг аажмаар хөдөлгөж эхлүүлнэ.

1223. Түр орхиж явах, өөр ажилбарт шилжих, засвар үйлчилгээ хийхдээ оёдлын машинаа унтраана.

1224. Хайч, багаж хэрэгслийг хөдөлгөөнт эд ангийн ойролцоо байрлуулахыг хориглоно.

1225. Ул өргөгчийн өвдгөнд хүрдэг төмөр хэсгийг резин материалаар бүрсэн байх шаардлагатай.

1226. Оёдлын машины болон гар зүү, товч зэргийг амандаа зуух, шүд чигчлэх, өөрийн хувцсанд хатгаж, халаасанд хийх, шидэж дамжуулахыг хатуу хориглоно.

1227. Зүүг тусгай хатгуурт хатгаж хэвшинэ.

1228. Хурд тохируулагч гишгүүр дээр хөл нүцгэн гишгэхийг хориглоно.

1229. Ажил дууссаны дараа оёдлын машины улыг буулган зөөлөвч хийн, зүүг доошлуулж хүчдэлээс салгасан байна.

Чийг, дулаанаар боловсруулах тоног төхөөрөмжтэй ажиллах аюулгүй ажиллагааны зааварчилгаа

1230. Ажил эхлэхийн өмнө тоног төхөөрөмжийн эд анги, халаагчийн бүрэн бүтэн байдлыг тогтмол шалгана.

1231. Цахилгаан төхөөрөмжид нойтон гараар хүрэх, төхөөрөмжийг нойтон чийгтэй зүйлээр арчих, ойр орчимд ус асгахыг хориглоно.

1232. Түр орхиж явах, өөр ажилбарт шилжихдээ индүүний тавцанг болон индүүний залгуурыг салгаж унтраана.

1233. Индүүний усны түвшинг хянаж, илүүдэл ус, уурыг тухай бүрд асгана.

1234. Уурын даралтын хэмжээг тогтмол хянаж, зөвшөөрөгдсөн хэмжээнд хүрсэн тохиолдолд хөргөх араг хэмжээг яаралтай авна.

1235. Уур гадагшлах үед гар, нүүрийг ойртуулахгүй байж түлэгдэх аюулаас болгоомжилно.

1236. Халуун уур, индүүтэй болгоомжтой харьцах, гэмтэл бэртэл авсан тохиолдолд ажил үүрэг гүйцэтгэхийг зогсоож, нэн даруй удирдах ажилтанд мэдэгдэнэ.

1237. Наалтын машин, индүүний тавцан дээр тухайн ажилбарын бүрдэл хэсгүүдээс өөр эд зүйлс тавихыг хатуу хориглоно.

Эсгүүрийн тоног төхөөрөмжтэй ажиллах аюулгүй ажиллагааны зааварчилгаа

1238. Ажил эхлэхийн өмнө тоног төхөөрөмжийн эд анги, хутганы бүрэн бүтэн байдлыг тогтмол шалгаж гэмтэл доголдол илэрвэл засварчнаар засуулна.

1239. Хайч, багаж хэрэгслийг эсгүүрийн тоног төхөөрөмжийн ойролцоо байрлуулахыг хориглоно.

1240. Түр орхиж явах, өөр ажилбарт шилжихдээ эсгүүрийн машиныг унтраана.

1241. Хэсэгчилсэн болон нарийвчилсан огтолгооны машин дээр өөр ажил эрхэлдэг болон дагалдан ажиллаж байгаа хүнийг ажиллуулахыг хориглоно.

1242. Эсгүүрийн машин дээр ажиллахдаа хамгаалалтын бээлий, нүдний шилийг зүүж ажиллана.

1243. Эсгүүрийн цехийн ширээний тавцангийн гадаргуу нь тэгш, гөлгөр, жигд байна.

1244. Бөөнөөр эсгэх ажиллагааны үед материалын нэг татлагад байх давхрын тоог тогтоосон нормативаас хэтрүүлэхгүй байх шаардлагатай.

1245. Эсгэх ажиллагааны үед гарсан өөдөс хаягдлыг түүнд зориулагдсан хайрцаг, саванд хийнэ.

1246. Эсгүүрийн цехэд барааг зориулалтын тавиур дээр унагахгүй байхаар хөдөлгөөнгүй хураасан байна.

1247. Ажил дууссаны дараа эсгүүрийн машиныг хүчдэлээс салгана.

1248. Ганцаарчилсан эсгүүрийн хайч, зүү болон бусад туслах багаж хэрэгслийг эсгүүрийн машин дээр тавихыг хориглоно.

1249. Эсгүүрийн хайчны ирийг үргэлж хурц байлгаж, хайчаар даавуу материалаас бусад зүйл хайчлахыг хориглоно.

1250. Хайчийг тусгай уутанд хийж, тогтмол нэг газарт хадгалах.

ЕСДҮГЭЭР БҮЛЭГ

БУСАД ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ЗААВАР

Албан тасалгаа /оффис/-ны ажилтны аюулгүй ажиллагаа

1251. Ажлын ширээ, сандал, хувцасны шүүгээний бүрэн бүтэн байдал, цэвэрлэгээ, компьютер, телефон утас зэрэг цахилгаан хэрэгслүүдийн хэвийн ажиллагаа, галын аюулгүй байдал зэргийг шалгана.

1252. Дээрх шалгалтуудыг хийх үед ямар нэг гэмтэл, үл тохирол илэрвэл холбогдох ажилтанд мэдэгдэж, засаж арилгасны дараа ажил үүргээ эхэлнэ.

1253. Ажлын байрны эмх цэгцийг хангаж, бичиг баримтуудыг шалан дээр болон хэт өндөрт тавихгүй байна. Компьютертой ажиллахдаа өөртөө ажиллахад амар, чөлөөтэй зүй зохистой байхуйц байрлалыг сонгон ажиллах бөгөөд 2 цагт тутамд завсарлаж нүдээ амраана.

1254. Хөлийн улыг шалан дээр бүрэн гишгэж байхаар сандлын өндрийг тохируулна.

1255. Цахилгаан хэрэгсэл болон эд хогшил эвдэрч гэмтсэн үед мэргэжлийн ажилтанд хандаж, аюулгүй ажиллагааг хангаж ажиллана. Эвдрэл, гэмтэлтэй цахилгаан хэрэгсэл, эд хогшил хэрэглэхийг хориглоно.

1256. Өрөөний гэрэлтүүлэг, агааржуулалт, чийгшил, дулааны горимыг зохих хэмжээнд тохируулан ажиллана.

1257. Ажлын байранд ил гал гаргах /лаа, арц, хүж асаах, тамхи татах г,м/-ыг хориглоно.

1258. Албан тасалгаанд хэт чанга дуу чимээ гаргах, зүй бусаар харьцах, удирдах албан тушаалтны шийдвэргүйгээр шөнийн цагаар ажиллах зэргээр хөдөлмөрийн сахилга дэг журмыг зөрчихгүй байна. Албан тасалгаанд цахилгаан зуух хэрэглэх, хоол хийхийг хатуу хориглоно.

1259. Ажил гүйцэтгэх явцад биед ямар нэг зовуурь илрэх зэргээр эрүүл мэндэд таагүй нөхцөл үүсвэл, эмч болон шууд удирдах ажилтанд нэн даруй мэдэгдэнэ.

1260. Байгууллагад гал түймрийн аюул, байгалийн гамшиг тохиолдох зэргээр онцгой байдал үүссэн нөхцөлд өөрийн болон бусдын амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгийг хамгаалах арга хэмжээнд идэвхтэй оролцоно.

1261. Галын анхан шатны багаж хэрэгслийг ашиглах, гал унтраагуурын төхөөрөмжийг ажиллуулах чадвартай байна.

1262. Гал түймрийн үед ажлын байрнаас дүрвэн гарах маршрут нөөц хаалга, гарцыг мэддэг байх. Аюул ослын үед анхны тусламж үзүүлэх чадвар эзэмшсэн байна.

1263. Албан тасалгааны бүх цахилгаан хэрэгслүүдийг цахилгааны тэжээлээс салгаж болзошгүй аюулаас сэргийлнэ.

1264. Албан тасалгааны агааржуулагч, салхивч, халаагуурын аюулгүй ажиллагааг шалгана. Өрөө тасалгаагаа цоожилж, лацадна.

1265. Шатаар буухдаа шатны бариулаас барьж гишгүүрт хөлийн улыг бүрэн гишгэж шатан дээр халтирахаас сэргийлж, болгоомжтой бууна. Цахилгаан шатанд суухдаа хэвийн ажиллаж байгааг урьдчилан шалгаж, хаалга бүрэн нээгдсэний дараа сууна.

1266. Ажилдаа ирж очихдоо аюулгүй, баталгаажуулсан маршрутыг сонгон аюулгүй байдлаа ханган зорчино.

Уртасгагч залгууртай ажиллах үеийн аюулгүй ажиллагааны зааварчилгаа

1267. Уртасгагч залгуурыг цахилгаанаас салгахдаа кабелиас нь татаж болохгүй.

1268. Уртасгагч кабелиар цахилгааны байнгын буюу суурин утсыг орлуулж болохгүй. /Байшингийн хана туурганд хадаж тогтоож болохгүй

1269. Цахилгааны залгуурыг уртасгахын тулд зориулалтын бүтэн бүтэн ажиллагаатай уртасгагч ашиглах бөгөөд зориулалтын бус кабель холбохыг хориглоно. Залгасан уртасгагч болон хэт урт уртасгагч нь хүчдэлийн хэмжээг бууруулдаг бөгөөд багаж, төхөөрөмжийг гэмтээж болох аюултайг анхаарах.

1270. Уян кабель болон цахилгааны утсыг шалбарах, гэмтэхээс хамгаалах, доторх утаснуудыг тусгаарладаг бүрээс нь зүсэгдсэн, урагдсан, цуурсан эсэхийг байнга шалгаж байх. Ил монтаж хийсэн цахилгааны утас нь ороолцолдох, бүдэрч унах аюултай тул цахилгааны утсыг үүдний ерөө, хана, цонх, тааз, шалан дээгүүр хөндлөн татаж болохгүй.

1271. Мэргэжлийн болон зөвшөөрөлтэй хүн уртасгагч утсыг засах, кабелийг солино.

Ачааг гараар өргөх, зөөх үеийн аюулгүй ажиллагааны зааварчилгаа

1272. Баглаа боодолтой болон бусад ширхгийн ачааг зөөвөрлөхдөө гараа шархлуулахгүйн тулд бүгдийг нь урьдчилан сайтар шалгаж үзэх хэрэгтэй, / төмөр баглааны үзүүр, хадаасанд гараа ураг, зүсэх эрсдэлтэйг анхаарах./ Хайрцгийг буюу боодлыг хураасан газраас авахдаа хажууд нь байгаа ачаа унахгүй, тогтвортой байдалд байгаа эсэхийг шалгах хэрэгтэй. Ачааг зөвхөн хураалтын дээд талаас авбал зохино. Ачааны хүнд, хөнгөнийг сайн тохируулах. Хэт хүнд, овор ихтэй ачаа өргөхгүй байх.

1273. Ачаандаа үнэлгээ хийх-Өргөж явах хооронд ачааны зарим хэсэг хөдөлж болох эсэх /бөөрөнхий зүйлс, лонх, хуйлсан зүйл гэх мэт/.

1274. Хөлөө зөв тавих. /нэг хөлөө ачааны ард, нөгөө хөлөө явах гэж байгаа зүг рүүгээ харуулж ачааныхаа хажууд тавь./

1275. Ачаанд хүрэх гэж бүсэлхийгээрээ бүү тонгой. Өвдгөө нугал. /дараа нь доошоо тонгойж ачаандаа хүр./

1276. Ачаагаа эсрэг хоёр талаас нь чанга барь.

1277. Ачааг бүсэлхийгээрээ тонгойсон үедээ бүү өргө. Ачаа өргөж байхдаа огцом хөдөлж, эргэж болохгүй.

1278. Өөрөө өргөж чадахааргүй бол бусдаас тусламж авах.

1279. Хүнд, овор хэмжээ ихтэй барааг зөөхдөө өргөх механизм ашиглах.

1280. Баллон шил савыг зөөвөрлөхдөө тусгай тавиур дээр тавьж зөөвөрлөх ба ийм ачааг зөөх, өндөрт гаргахдаа бие дээрээ зөөвөрлөхийг хориглоно.

1281. Бургидаг ачааг зөвхөн тоос үл нэвтрэх нүдний шил ба амьсгалуур хэрэглэсэн нөхцөлд гараар ачиж буулгаж болно.

1282. Өдөр бүр ажлын тусгай хувцасны тоосыг гөвнө. Амьсгалуурын шүүлтүүрийг бохирдвол сольж байх.

1283. Хлорт шохойг ачиж буулгахдаа шүүлтүүртэй буюу амьсгалууртай хорт хийн багийг заавал өмсөнө.

1284. +40° С ба түүнээс дээш халуун байгаа үед цементийг гараар ачиж болохгүй.

1285. Хүний гараар өргөх ачааны дээд хэмжээ нь стандартад заасны дагуу эмэгтэй хүн - 20 кг, эрэгтэй хүн — 36 кг байна.

Няравын аюулгүй ажиллагааны зааварчилгаа

1286. Хөдөлмөрийн аюулгүй байдал, технологийн горимыг мөрдөж ажиллана.

1287. Ажлын байрны лац ломбо болон цахилгаан хэрэгслүүдийн хэвийн ажиллагааг шалгана. Гэмтэл, үл тохирол илэрвэл холбогдох ажилтанд мэдэгдэж, засаж арилгасны дараа ажил үүргээ эхэлнэ.

1288. Нярав нь ажил үүргийн хуваарьт тусгагдсан буюу ажил удирдагчийн заасан ажлыг гүйцэтгэхтэй холбогдсон аюулгүй ажиллагааны зааварчилгаатай танилцаж, дэвтэрт гарын үсгээ зурна.

1289. Агуулах нь байнга эмх цэгцтэй. цэвэрхэн байх бөгөөд гаднын хүн орж болохгүй.

1290. Агуулахын байр нь хангалттай гэрэлтүүлдэг, гадна талдаа хамгаалалттай гэрэлтүүлэгтэй байна. Гэрлийн монтаж нь далд, цахилгааны утасны диаметр нь ачаалал даахуйц байна.

1291. Агуулахын гэрлийн унтраалга, залгуурууд нь технологийн дагуу хийгдсэн, контакт нь найдвартай, сул биш байх.

1292. Агуулахын тавиурууд нь бат бөх хийгдсэн байна.

1293. Агуулахад хэрэглэх зөөврийн шат нь бат бөх, хөдөлгөөнгүй, дээд талын тавиурт байгаа бараа, эд зүйлийг авахад хүрэлцэхүйц өндөртэй байх.

1294. Тавиур, тавцан руу бүү авир. Дээд талын тавиурт хүрэхийн тулд шат, тавцан, гишгүүр ашиглах.

1295. Сэлбэг хэрэгсэл, эд хогшлыг хураахдаа нурж унахааргүй, цөөн тоогоор давхарлаж тавих.

1296. Труба, лааз, торх зэрэг өнхрөх зүйлсийн наагуур хаалт хийх буюу бэхэлсэн байх.

1297. Жижиг, хүнд зүйлсийг дээд тавиурт нүдэнд харагдахуйц тавих.

1298. Химийн бодисыг хадгалахдаа зохих агааржуулалт, температурыг хангах болон бусад хамгаалах арга хэмжээг авсан байна. Зарим бодисуудыг хамтад нь хадгалахыг хориглоно.

1299. Бараа материалыг хөлд тээглэхгүй, тавиураас илүү гарган хурааж болохгүй. Тавиур дээр тавьсан эд зүйлсийн хаяг, нэр, тоо ширхгийг нүдэнд ил харагдахуйцаар бичиж тавьсан байх.

1300. Шатах, тослох, тэсэрч дэлбэрэх материалыг тусгай зориулалтын байранд хадгална. Шатах, тослох, тэсэрч дэлбэрэх материалын агуулахын гадна, дотор талд анхааруулах санамжийг байрлуулах шаардлагатай агуулахад галын дохиоллын системээр тоногдсон байх.

1301. Онцгой байдлын үед агуулахаас түргэн гарах боломжтой байна. Тавиур хоорондын зай, эгнээ зэргийг битүүлж мухарлахыг хориглоно.

1302. Агуулах дотор болон агуулах орчимд гал унтраах төхөөрөмж байрлуулсан байх.

1303. Агуулах доторх галын хор, галын хоолой, бусад төхөөрөмжийг халхалсан байдлаар барааг бүү хураахгүй байх.

1304. Агуулахын агааржуулагч, салхивч, халаагуур зэргийг шалгаж, цахилгаан хэрэгслүүдийг тэжээлээс салгах.

1305. Агуулахын хаалгыг лацдан, жижүүрт хүлээлгэн өгөх.

1306. Ажлын хувцас, бээлий, ариун цэврийн хэрэгслийг хувцасны шүүгээнд хийж хадгалах бөгөөд бусад зүйлсийг хадгалахыг хориглоно

1307. Ажлын хувцастайгаа цайны газарт орох, гудамж талбайд явах, гэртээ авч явахыг хориглоно.

1308. Ажлын хувцсыг тогтоосон хугацаанд цэвэрлүүлж байх бөгөөд хэт бохир хувцас, хэрэгсэл өмсөхийг хориглоно.

Хяналтын цэгт үүрэг гүйцэтгэх үеийн аюулгүй ажиллагаа

1309. Алба хаагч нь хяналтын цэгт үүрэг гүйцэтгэхдээ холбогдох хууль дүрэм, журам, зааврыг мөрдлөг болгон ажиллана.

1310. Хяналтын цэгийн байр нь гадна талдаа гэрэлтүүлэг, таних тэмдэгтэй байна.

1311. Хяналтын цэгийн байрны цахилгаан угсралт, пийшин зуух нь галын аюулгүй байдлын холбогдох дүрэм, норм, стандартын дагуу хийгдсэн, аюулгүй байдлыг хангасан байна.

1312. Улсын болон орон нутгийн чанартай авто замуудад хяналтын цэгийг байрлуулахдаа Замын хөдөлгөөний аюулгүй байдлын дүрмийн нэгдүгээр хавсралтыг удирдлага болгон тэмдэг, тэмдэглэгээг байршуулна.

1313. Шатах, тослох материал, шингэрүүлсэн шатдаг хий, ариутгал, халдваргүйтгэлийн бодис, материалыг ашиглах, хадгалахдаа аюулгүй байдлыг хангаж хяналтын цэгээс тусад нь байршуулна.

Цахилгаанчин, засварчны ажил гүйцэтгэх үеийн аюулгүй ажиллагаа

1314. Цахилгаанчин нь өдөр бүр зааварчилгаатай танилцаж гарын үсэг зурж ажилд гарна.

1315. Салгалт хийгээгүй тохиолдолд ямар нэгэн үйлдэл, ажил гүйцэтгэхийг хориглоно.

1316. Ажил хийж байгаагаас бусад цахилгааны шүүгээний хаалга цоожтой байх ёстой.

1317. Хөндийрүүлэх бүрээстэй бахь, отвёртка хэрэглэнэ.

1318. Хөндийрүүлэх резин бээлий богино ханцуйтай хувцастай ажиллах, төмрийн хөрөө, хуурай, төмөр металл хэрэглэж ажиллахыг хориглоно.

1319. Шаардлагатай таслалтуудыг хийж, таслах, залгах аппаратууд өөрөө залгагдах буюу тэдгээрийг андуурч залгахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авна.

1320. Цахилгаан хөдөлгүүр ажиллаж байхад түүний эргэлдэх хэсгийн хаалтыг авч болохгүй.

1321. Багаж хэрэгслүүдээ бүрэн бүтэн болон эвдрэлгүй эсэхийг байнга шалгаж байх шаардлагатай.

1322. Цахилгаанчинд дараах зүйлсийг хориглоно. Үүнд:

1322.1. Дэд станцтай ажиллахдаа бороотой, цасан шуургатай үед болон ганцаар ажиллах, үзэгдэх орчин хязгаарлагдмал үед ажиллахыг хориглоно,

1322.2. Нам талын цахилгааны шитнээс бусад өндрийн цахилгаан шит самбарт гар хүрэх оролдохыг хориглох,

1322.3. Архи согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ болон биеийн байдал муу байгаа үед ажиллахыг хориглоно,

1322.4. Хамгаалах хэрэгсэлгүй, хаалт хашлагагүй ажиллахыг хориглоно.

Үйлчлэгчийн аюулгүй ажиллагаа

1323. Ажил эхлэхийн өмнө ажлын багаж хэрэгслийн бүрэн бүтэн байдлыг тогтмол шалгаж, дутуу бол гүйцээн эхэлнэ.

1324. Ажил үүргээ биелүүлэхдээ халтирч, бүдэрч унах, өрөө тасалгааны хаалганд гар хөлөө хавчуулах, толгойгоо цохих, үзүүртэй хурц зүйлд гар хөлөө зүсэх, хатгах аюул эрсдэлээс сэргийлж анхаарал болгоомжтой ажиллана.

1325. Өрөө тасалгааг цэвэрлэхдээ компьютер дээр ажиллаж байгаа хүнд хийж байгаа зүйлээ хадгалахыг сануулан шаардлага тавин цэвэрлэнэ.

1326. Цэвэрлэгээ хийж байхдаа нойтон чийгтэй гараар цахилгаан хэрэгсэлд хүрэх, цахилгаан хэрэгсэл дээр ус асгах, нойтон зүйл хүргэхэд тогьд цохиулах аюул тулгарч болзошгүй тул анхааралтай ажиллана.

1327. Цонх, тавцан зэрэг өндөр зүйлс дээр ажиллахдаа унаж бэртэхээс болгоомжлон аюулгүй байдлаа ханган ажиллана.

1328. Шал, шат гадаргууг цэвэрлэхдээ өөрөө болон бусад хүмүүс халтирч унах эрсдэл үүсэж болохыг анхааруулж ажиллана.

1329. Цех тасаг, өрөө тасалгааны цахилгааны болон телефон утас, үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж зэрэгт тээглэн унаж, бэртэж гэмтэхээс сэргийлэн ажиллана.

1330. Цэвэрлэгээний бодисыг үнэртэж хордох, гар хөлөө түлэх, харшил үүсэхээс сэргийлэн хамгаалалтын бээлий, амны хаалтыг өмсөж хэвшинэ.

Тогоочийн ажиллах аюулгүй ажиллагаа

1331. Тогооч нь дараах эрүүл ахуйн шаардлагыг хангасан байна. Үүнд:

1331.1. Гадуур хувцас, малгай, гутал, бусад зүйлийг заавал тайлж хувцасны шүүгээнд хийнэ.

1331.2. Ажил эхлэхийн өмнө гараа заавал савандаж угаах ба ажлын цэвэр хувцас өмсөж, үсээ зориулалтын малгайгаар халхална. /урт үстэй бол дээш нь шууна/

1331.3. Ээмэг, бөгж, цаг, хүзүүний зүүлт зэргийг ажиллах үед авсан байх ба хумсаа богиносгож, лак түрхээгүй байна.

1331.4. Бие засах газар орох бүртээ гараа савандаж угаах ба ажлын хувцсыг бохирдсон тухай бүр цэвэрлэж хэрэглэнэ.

1331.5. Ажлыг зөвхөн зориулалтын бүрэн бүтэн багаж хэрэгслээр гүйцэтгэнэ.

1332. Ажлын байрыг зохих дүрмийн дагуу цэвэрлэсэн байх ба шалан дээр ямар нэг бүтээгдэхүүн, ус, тос асгасан байхыг хориглоно.

1333. Халуун зүйлтэй харьцахдаа заавал гар хамгаалах бээлий өмссөн байна.

1334. Хайрцаг савтай, таглаатай зүйлийг онгойлгохдоо зориулалтын багаж хэрэглэх ба ямар нэг зүйлийг орлуулан хэрэглэхийг хориглоно.

1335. Хутгатай харьцаж ажиллахдаа гараа зүсэхээс болгоомжлон ажиллах ба ашиглаагүй үед заавал хамгаалалтын гэр, уутанд хийж байлгана. Ажил гүйцэтгэж байх үедээ хутгыг гартаа барьж явах, ирийг нь гараараа шалгах, огцом эргэлт, хөдөлгөөн хийх, овор ихтэй бүтээгдэхүүн, түүхий эд авахыг хориглоно.

1336. Халуун хоолтой савыг зөөвөрлөхдөө “өөрөөсөө гадагш” гэсэн хөдөлгөөний чиглэлээр тавина.

1337. Гал тогооны болон хооллох өрөөний шалыг хуурай цэвэр байлган цэвэрлэгээг хоол цай бэлдэхээс өмнө хойно зохицуулан хийлгэж шалан дээр

асгарсан тос шингэнийг даруй цэвэрлэж хагархай эмтэрхий сав суулгыг хэрэглэхгүй байх ёстой.

1338. Түргэн буцалгагчийн хийг урьдаар гаргаж, даралт бууруулсны дараа тагийг авна.

1339. Ажлын бүсэд шатдаг хий үнэртвэл хамраа нойтон салфеткаар таглаж, цонх, хаалгыг онгойлгож, агааржуулах, хий дамжуулах хоолойн крантыг хаана. Энэ үед цахилгаан тоног төхөөрөмж, гэрэлтүүлэг, агааржуулалтын системийг ажиллуулах, ил гал гаргахыг хатуу хориглоно.

1340. Тос хэт халснаас гал гарч шатвал тэр даруй зузаан даавуу зэргээр бүтээж унтраана.

1341. Хийн тоног төхөөрөмжийг ажиллаж байхад хяналтгүй орхиж явахыг хориглоно.

1342. Ажлын үед хийн тоног төхөөрөмжийг төмөр мод зэргээр цохих, хий дамжуулах хоолой болон хийн плиткийн хаалтыг зориулалтын бус /бахь, түлхүүр, чимхүүр, хөшүүрэг гэх мэт/ зүйлээр эргүүлэхийг хориглоно.

1343. Хийн тоног төхөөрөмжийг ажиллаж байхад түүний ямар нэг эд ангийг солих, засварлах оролдлого хийхийг хатуу хориглоно.

1344. Хийн тоног төхөөрөмжийг ажиллаж байхад тогтмол хяналт тавьж байх ба ямар нэг зөрчил /хийн үнэртэх, очлуур ажиллахгүй байх гэх мэт/ илэрвэл тэр даруй хийн тоног төхөөрөмж хариуцагчид мэдэгдэж, зөрчлийг арилгуулсны дараа ажлаа үргэлжлүүлэн гүйцэтгэнэ.

1345. Баллоны баталгаат хугацаа дууссан, хаалт гэмтсэн, баллоны их бие гадаргуу гэмтсэн тохиолдолд ажиллуулахыг хатуу хориглоно.

1346. Үйл ажиллагааны явцад хийн алдагдлыг тодорхойлох зорилгоор гал ашиглахыг хатуу хориглоно. Баллоны хаалтыг хааж холбох хоолой дахь үлдэгдэл хийг хийн зуухны очлуурыг дарж асаан дуусгана.

Сантехникийн слесарийн ажиллах аюулгүй ажиллагаа

1347. Слесарь нь ажилчдын мөрдөх аюулгүй ажиллагааны ерөнхий заавар, галын аюулаас хамгаалах дүрэм заавар, сантехникийн слесарийн ашиглалтын заавар журмын шаардлагыг мөрдөнө.

1348. Өөрийн ажлын хувцсыг эмх цэгцтэй, ханцуйг товчилж, унжиж санжсан зүйлийг засаж, үсийг малгай дотуур хийж, хамгаалах хэрэгсэл ба ажлын хувцсыг бүрэн зөв өмссөн байна.

1349. Гагнуурын ажлыг гүйцэтгэхэд гагнуурчинд тусалж байгаа засварчин нь гагнуурчны адил хамгаалах хэрэгсэлтэй байна.

1350. Слесарийн ажилд хэрэглэх багаж хэрэгсэл нь бүрэн бүтэн эсэхийг шалгана. /түлхүүрийн ам сунаагүй, лантуу ба алхны цохиур нь толигор хуурай цүүц нь зориулалтын иштэй, хөрөө нь зориулалтын рамтай байна/

1351. Ажиллахад бүх саад болж байгаа зүйлийг зайлуулах, багаж хэрэгсэл, зориулалтын зүйлс, зайлшгүй хэрэгтэй материал, деталь зэргийг хэрэглэхэд ашигтай дарааллаар аюулгүй тохиромжтой хэсэгт байрлуулна.

1352. Нойтон чийгтэй хувцастай цахилгаантай харьцахыг хориглоно.

1353. Эргэн холбоосыг чангалах үед эрэг эвдэрч ус цацагдаж болох учраас эсрэг талд нь зогсож ажиллах шаардлагатай.

1354. Халаалтын шугамтай ажиллахдаа түлэгдэх аюулаас сэргийлэн ажиллана.

Нам даралтын зуух галлах үеийн аюулгүй ажиллагаа

1355. Зуух ба халаалтын сүлжээг усаар дүүргэж сүлжээний хийг суллаж 2-3 атмосферын даралтад оруулсны дараа зуухаа галлаж, усны хэм 60-70 градус С болсон тохиолдолд сүлжээний эргэлтийн шахуургыг ажиллуулна. Эргэлтийн шахуурга нь зуухнаас халсан усыг сорж, халаалтын сүлжээнд шахах замаар халаалтын усыг эргүүлнэ.

1356. Зуухыг дараах нөхцөлд галлахыг хориглоно.

1356.1. Усны алдагдалтай үед,

1356.2. Тэжээлийн усны бүх төхөөрөмж ажиллахгүй үед,

1356.3. Аваарын хавхалга ажиллагаагүй үед,

1356.4. Зуухан дотор гэмтэл үүсэх, ус алдах зэрэг тохиолдолд галлах.

Уурын зуухны ажилтан /галч/-ны аюулгүй ажиллагаа

1357. Зуухны галч нь мэргэжлийн үнэмлэхтэй, эмнэлгийн үзлэгт орж магадалгаа гаргуулсан, 18 наснаас дээш настай эрэгтэй хүн байна.

1358. Зуух бүрд манометр, термометр болон аваарын клапан бүрэн тавьсан байна.

1359. Ажлын байранд эмийн сан, зөөврийн гэрэл, хамгаалах хэрэгсэл, ахуйн байраар хангасан байвал зохино.

1360. Зуухны галч өөрийн ажиллах хугацаанд зуухны ажиллагааны хэвийн горим тоноглолын бүрэн бүтэн байдлыг хариуцан ажиллах үүрэгтэй.

1361. Зуухны тоног төхөөрөмжийг ажиллуулах /ус хангамжийн сүлжээний ажиллагаа, халаалтын сүлжээг усаар дүүргэх, усыг юүлэх технологийг бүрэн мэддэг байх/ Мөн галч нь зууханд доголдол илэрсэн бол үүссэн хор уршгийг арилгах анхан шатны арга хэмжээг бие даан авч чаддаг байх.

1362. Зуухны байранд гадны хүн болон галд шатамхай бензин, керосин оруулахгүй байх.

1363. Галч нь аюулгүй ажиллагааны талаар дараах шаардлагыг ханган ажиллах үүрэгтэй. Үүнд:

1363.1. Усны температур өсөж, чимээ гарах тохиолдолд галлагааг шууд зогсоох.

1363.2. Зуухны галын хотолд хаа нэгтэйгээс ус алдах тохиолдолд галын хотолд байгаа оч, нурмаа яаралтай зайлуулах, үлээгүүр, сэнс, ус шахах үйлдлийг зогсоох

1363.3. Зууханд аваар үүсгэх болзошгүй нөхцөлд өөрийгөө түлэгдэлтээс хамгаалах хэрэгслийг бэлэн байлгаж ашиглах,

1363.4. Зуухны байранд угаар гарах үед хаалга, цонхоо нээн өөрийгөө хордохоос хамгаалах,

1363.5. Үүдэнд гэрэлтүүлэг, гар чийдэн зэргийг заавал тавих,

1363.6. Ээлжийн ажилчид өдөр бүр тэмдэглэл хөтөлж, зуухны ажиллагааны талаар харилцан хүлээлцэж байх,

1363.7. Зуухны эргэн тойрон дахь тоос шороог байнга цэвэрлэх,

Мужааны ажил хийх үеийн аюулгүй ажиллагаа

1364. Ажил эхлэхийн өмнө суурин хөрөө болон бусад хэрэгслийн ажлын бэлэн байдлыг заавал шалгана, ээлжийн ахлах, хөдөлмөрийн аюулгүй байдал хариуцсан мэргэжилтнээс зааварчилга авч, дэвтэрт гарын үсэг зурна.

1365. Багажид үйлдвэрлэгчийн зааснаас илүү ачаалал өгөхгүй байх, багаж хэрэгслийг зөвхөн зориулалтаар нь ашиглах,

1366. Цахилгаан дриль, дискэн зүлгүүр, өнгөлөгч болон, цахилгаан (дугуй) ба моторт (гинжин) хөрөөнүүд /гар бариултай бол/ удирдлагын товч дээр байнга дарахгүй ажиллуулах.

1367. Цахилгаан болон моторт хөрөөнүүд нь ажиллуулах удирдлагыг түгжих хэрэгслээр тоноглогдоогүй байх.

1368. Өнгөлөгч точилын дугуй ажиллаж байх үед нүүрний хамгаалалт эсвэл нүдний битүү хамгаалалтыг заавал хэрэглэх.

1369. Үсэрч хүн гэмтээж болзошгүй үртэс материал, гар багажаар ажиллахад үүсэж байгаа бол ажлын талбайг тойруулан тохирох хашлага, хөшиг байрлуулна.

1370. Цахилгаан багажийг гар бариулаас нь барьж өргөх буюу доош буулгана. Харин өргөх буюу тавихдаа хийн хоолой болон залгуур кабелиас татаж болохгүй.

1371. Цахилгааны болон багаж хэрэгслийн аюулгүй байдлыг хангаж ажлын байрыг цоожилж лацдаж байх.

1372. Цүүц, халив (отвёртка), болон үзүүртэй багажуудыг халаасанд хийхгүй байх, багажийн хайрцаг, тэргэнцэр, бүс, багажийн уутанд эсвэл үзүүртэй хэсгийг биеэс гадагш чиглүүлэн гартаа барьж явна.

1373. Халивын бариул нь жигд гөлгөр, цэвэрхэн, хошуу нь хурц, дөрвөлжин байгаа эсэхийг шалгах. Цахилгаан гүйдэл төхөөрөмжийн ойр ажиллахдаа тусгаарлагчтай халивыг урьдчилан сэргийлэх зорилгоор хэрэглэнэ.

1374. Алхны бариул нь хугарч, хагараагүй, цэвэрхэн, толгойн нүүр нь жигд гөлгөр мөн цэвэр байгаа эсэхийг шалгах.

1375. Хадаасны алх_ Ердийн зөөлөн хадаас, өнгөлгөөний хадаасыг алхны толгойн нүүрний төв хэсгээр цохиж хадах зориулалттай. Хадаасны алх шулуун, махир хошуутай буюу ооль хэлбэртэй байх.

1376. Тавлах, тараах алх_ Эдгээр нь метал лист дээр холбон тавлах, хурц булан гаргах, давхаргуудын ам ирмэг дарах, хумих гэх мэт ажилд хэрэглэх зориулалттай. Алх хэрэглэж байхдаа байнга нүдний хамгаалалтын шил зүүх. Алхаар цохихдоо толины талбайг бүрэн ашиглаж, эгц цохих ёстой. Хажуулдуулж, хальт цохихоос болгоомжил.

1377. Цоолтуур: Үзүүрийнх нь ирнээс илүү зөөлөн металл болон өөр материалыг тэмдэглэх, шаантаглах ба гаргах, нүхнүүдийг зэрэгцүүлж цоолоход ашиглана. Ир ба үзүүр нь элэгдсэн, мөлийсөн, хэв гажсан цоолтуурыг хэрэглэхийг хориглоно.

1378. Хуурайнууд: Хуурайны бариул бат бөх, шүд нь хурц бөгөөд цэвэр байна. Хуурайг зөв барихдаа нэг гартаа чанга атгаж, нөгөө гарын эрхий ба долоовор хурууг ашиглан хуурайдах газраа чиглүүлнэ. Хуурайг урагш түлхэхдээ дарж, буцаахдаа дарахаа больж эхний байрлалд нь аваачна. Барзгар гадаргуутай, хагардаггүй бариултай хуурайг хэрэглэнэ. Тухайн ажилдаа тохирсон хуурайг сонгох.

1379. Хутга: Бариул бүтэн, ир нь хурц байгаа эсэхийг шалгах. Хутганы иртэй хэсгийг хүний биеэс гадагш чиглүүлнэ. Илүү хөдөлгөөн аль болох хийхгүй байх.

Хутга болон бусад иртэй багажуудыг бусад багаж хэрэгслээс тусгаарлах. Хутганы хурц ирийг гараар барихыг хориглоно.

Гагнуур хийх үеийн аюулгүй ажиллагаа

1380. Гагнуурын ажил хийх алба хаагч нь гагнуурын ажил хийхийн өмнө ээлжийн ахлах даргад мэдэгдэж зааварчилгаа авсан байна.

1381. Гагнуурын баг, малгай эсвэл халхавч, хамгаалалтын бээлий, гутал, хувцас өмсөж хэрэглэнэ.

1382. Гидроацетилены эсвэл бусад төрлийн хийн гагнуур хийж байгаа гагнуурчид хамгаалалтын нүдний шил зүүх, Гагнуураар огтлох ажлын үед галд тэсвэртэй чихний халхавчийг зүүх.

1383. Цахилгаан хүчдэлд цохиулах аюултай чийглэг газар ажиллаж байгаа гагнуурчид резин эсвэл өөр хамгаалалттай гутал өмсөх, гуталд халуун металл орохоос сэргийлэх.

1384. Шатахууны савны гагнуурыг зөвхөн мэргэжлийн гагнуурчнаар хийлгэх бөгөөд савыг инерт хийгээр бүрэн дүүргэсний дараа гүйцэтгэнэ.

1385. Цинк, хар тугалга, кадмий, мөнгөн ус болон бериллиэр хийсэн эсвэл хучсан материалыг хаалттай битүү газар гагнах буюу таслах үед хортой хий ялгаран гарч болох тул зохих цаг агаарын эсвэл амьсгалын замыг хамгаалах багаар хангах.

1386. Гагнуурын болон бусад халуун ялгарах ажил явагдаж байгаа газар галын аюулаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах.

1387. Галын аюулаас хамгаалахын тулд идэвхтэй ажил явагдаж байгаа огтлох буюу гагнах ажлын талбарыг галд үл шатах буюу галд тэсвэртэй материалаар хийсэн шитээр тусгаарлах шаардлагатай.

1388. Тэсрэлт үүсэх аюултай тул хийн болон хүчилтөрөгчийн хоолой, холбогчдод хялбар авалцан асах шингэн ба аливаа тос, тослох материал хүргэхийг хориглоно.

1389. Хийн гагнуур хийхийн өмнө бүх баллон дээр даралтыг намсгах тохируулагч болон дөл баригч хамгаалагчийг суурилуулсан байх.

1390. Гагнуурын хийн баллон даралт тохируулагчийг салгахын өмнө баллоны хаалтыг хааж, тохируулагчаас даралтыг суллан гаргах.

1391. Тээвэрлэх, хадгалах болон ашиглах үед гагнуурын хийн баллоныг босоо байдалд найдвартай бэхэлж, түүнийг өнхрүүлэх буюу унагаахыг хориглоно.

1392. Дүүрэн эсвэл хоосон хүчилтөрөгчийн болон ацетилины баллоныг хооронд нь 3 метрээс хол зайтай хадгалах, шатах тослох материалд гал авалцах тоног төхөөрөмжийг гагнах үед үүсэх эрсдэлээс урьдчилан сэргийлж хөндлөнгийн хяналт тавих.

1393. Гагнуурын хийн баллон, түүний таглаа, хаалт, шалаанк болон даралт тохируулагчийг тосноос ангид байлгах бөгөөд тостой гараар буюу бээлийгээр хүрч болохгүй. Хамгаалалтын тагийг баллон болгонд суулгавал зохино.

1394. Гагнуур хийх үед хориглох зүйл:

1394.1. Гагнах, устөрөгчөөр огтлох, таслах ажлын үед асаагуур ба чүдэнзийг халаасанд байлгах.

1394.2. Гэмтэлтэй тоног төхөөрөмж ашиглах.

1394.3. Баллоныг хаалттай битүү газарт ашиглахыг/ Гидроацетилены дөлийг зөвхөн ил задгай газар асаах/

1394.4. Гагнуурын төмөр, гар хэсгүүдийг битүү газар эзгүй орхих /Цахилгаан гүйдлийн нөлөөллөөс хол баллоныг байрлуулах/

1394.5. Цахилгаан нум үүсгэх, электродыг баллон руу ойртуулах

1394.6. Баллон хадгалах байранд тамхи татах болон оч гаргахыг хориглоно.

АРАВДУГААР БҮЛЭГ СПОРТЫН ТЭМЦЭЭН, УРАЛДААН, НЭГДСЭН АРГА ХЭМЖЭЭНД ОРОЛЦОХ ҮЕИЙН АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ЗААВАР

Албаны спортын тэмцээний бэлтгэл, тэмцээнд оролцох үеийн аюулгүй ажиллагаа

1395. Спортын тэмцээнд оролцохдоо тухайн спортын төрлийн хувцас, хамгаалах хэрэгслийг бүрэн өмсөх ба зориулалтын спортын хувцас, хамгаалах хэрэгсэлгүй тэмцээнд оролцохыг хориглоно.

1396. Дадлага, сургууль, тэмцээнд оролцохдоо багаж хэрэгсэл ашиглах бол тухай бүрт өөрийн биед тохируулсан байна.

1397. Дадлага сургууль тэмцээн дуусмагц өөрийн хариуцаж ажилласан багаж хэрэгсэл, хувцас, хамгаалах хэрэгслийг аюулгүй ажиллагааг шалгаж хайрцаг, цүнхэнд хийнэ.

1398. Хамгаалах хувцас хэрэгсэл, багаж хэрэгслийн бүрэн бүтэн байдлыг тухайн албан хаагч өөрөө бүрэн хариуцна.

1399. Тэмцээн уралдаанд оролцохдоо өөрийн болон бусдын аюулгүй байдлыг хангаж, тухайн спортын дүрмийг судалж, дүрмийг чанд мөрдөнө.

1400. Гал унтраах техникийн олон төрөлт спортоор хичээллэх, тэмцээн уралдаанд оролцох үед тухайн спортын дүрэмд заасан техник, хэрэгсэл, багаж зэвсэглэмжийг ашиглах.

1401. Дасгалжуулагч, багийн ахлагч нь бэлтгэл сургуулилт, тэмцээн уралдаанд самбар, гүүр, байшин зэрэг техник хэрэглэлийн аюулгүй байдлыг хангасныг шалгасаны дараа хэрэглэлтэй бэлтгэл, уралдаанд оролцуулах.

1402. Гэмтэлтэй хэрэглэл дээр дасгал сургууль, бэлтгэл хийхийг хатуу хориглоно.

Марш-тусгай бэлтгэлийн сургалт, дадлага тэмцээний бэлтгэл, тэмцээнд оролцох үеийн аюулгүй ажиллагаа

1403. Тэмцээнд оролцож буй алба хаагч, ажилтан нар улирлын цаг агаарын нөхцөл байдалд тааруулан хувцаслах.

1404. Гранат шидэлтийн талбайд ажиллагаа явуулахдаа алба хаагчид гранатыг шидэхдээ гар, мөрөө гэмтээхээс урьдчилан сэргийлж техникийн дагуу шидэх, алба хаагчид нэгнийхээ араас гранат шидэхийг хориглоно.

1405. Ерөнхий цэргийн саадын зурваст алба хаагчид саадтай зурвасыг туулж байхдаа хоорондоо давхралдах, толгой, гарын хэсгийг торонд хүргэхийг хориглох.

1406. Хөнөөлийн голомтод цэргийн алба хаагч нар тээврийн хэрэгслийг байрнаас хөдөлгөх үед тоормос, ивүүр зэргийг хэрэглэх. Мөн сум галт хэрэгслийг зөөх явцад газар хүчтэй хаяхгүй байх.

1407. Бууг байнга бай руу чиглүүлэн буудлагын хавтгайд барих.

1408. Бууг зөвхөн цээлд чиглүүлсний дараа гох дээр хуруу тавих бусад үед хурууг гох дээр тавихгүй байх.

1409. Цэнэглэсэн бууг хараа хяналтгүй орхихыг хатуу хориглоно.

1410. Гал нээх зөвшөөрлийг буудлагын ахлах удирдагч улаан дарцаг өргөн гал нээх тушаал өгнө.

1411. Буудлагын үед зэвсэг техникт гацаа гэмтэл тохиолдвол буудагч бие даан гал зогсоож буудлагын удирдагчид илтгэж мэдэгдэх.

1412. Буудлагын удирдагч буудлагын өмнө болон төгсгөлд буунд үзлэг хийнэ.

1413. Буудлагын зэвсгийн баарсан сумыг дахин хэрэглэх оролдлогыг хориглоно.

1414. Буудлагын талбайд хүн мал тээврийн болон нам өндөрт нисэж байгаа нисэх онгоц нисдэг тэрэг илэрвэл буудагч нь бие дааж эсвэл буудлагын удирдагчийн командаар галыг нэн даруй зогсооно.

1415. Буудлагаас болж гал түймэр гарвал буудлагыг зогсооно.

1416. Бууг сумласан сумлаагүй ямар ч тохиолдолд хүн рүү, хажуу болон буудлагын артал руу харуулахыг хатуу хориглоно.

1417. Үй олноор хөнөөх зэвсгээс хамгаалах бэлтгэлийн цэг дээр цэргийн алба хаагч нар хордохоос сэргийлж хамгаалах хэрэгслийг заагдсан нормативаар өмсөж багны битүүмжлэлийг алдагдуулалгүй өмсөж, холбох хоолойг угсарч уутанд хийнэ. Хордсон тохиолдолд яаралтай цэвэр агаарт тусгаарлах.

1418. Цэргийн алба хаагч нар замд гүйж байх хугацаанд батлагдаагүй зам, даваа, мөс, цасан дээгүүр гүйхгүй байх.

Бусад

1419. Тэмцээн, уралдаанд оролцох үед спортын төрлүүдээс шалтгаалан тухай нь спортын дүрмийг сайтар судалж, мөрдөх бөгөөд, нийцүүлэн гарсан аюулгүй ажиллагааны зааврыг мөрдөнө.

1420. Дасгалжуулагчийн зөвшөөрөлгүйгээр бэлтгэл сургуулилт хийхийг хатуу хориглоно.

1421. Орон нутгийн болон бүс, улсын чанартай сургалт, дадлага, тэмцээнд оролцохоор явахдаа эмчийн үзлэгт бүрэн хамрагдсан байна.

1422. Холын замд явахдаа нэгдсэн унаа болон даатгалтай зорчигч тээврийн хэрэгслээр зорчих, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг бүрэн хангах.

1423. Аян замд согтууруулах ундаа, сэтгэцэд нөлөөлөх эм бэлдмэл хэрэглэхгүй байх.

1424. Спортын тэмцээн эхлэхээс өмнө бие халаалтын дасгалыг 30 минутаас доошгүй хугацаанд тухайн спортын төрөлд нийцүүлэн хийж гүйцэтгэнэ.

1425. Тэмцээн, уралдаанд оролцож буй алба хаагч, ажилтан нь эрүүл мэнд муудах, бэртэл гэмтэл авахаас урьдчилан сэргийлж оролцохгүй байж болно.


1426. Албаны болон нийтийн биеийн тамирын спортын төрлүүдээр тэмцээн уралдаан зохион байгуулах үед эрүүл мэндийн тусламж үзүүлэх эмч заавал байна.

1427. Нэгдсэн зохион байгуулалтаар байрлуулан 14 ба түүнээс дээш хоног бэлтгэл хийх үед эмчийн хяналтын үзлэгт хамруулна.

1428. Энэ дүрмээр зохицуулаагүй үйл ажиллагааг бусад холбогдох дүрэм, журам, эрх зүйн актуудаар зохицуулна.

---oOo---

Онцгой байдлын ерөнхий газрын даргын
2023 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн
АБ38 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт



ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ЗААВАРЧИЛГААНЫ ХЯНАЛТЫН ХУУДАС

(анги, салбар, байгууллагын нэр)

Цол, овог нэр
Төрсөн огноо
Албан тушаал
Мэргэжил, тусгай мэргэжил
Газар, хэлтэс, албад (анги, салбар).....
Зааварчилгааны утга:

.....
.....
.....
.....
.....
.....
.....
.....
.....
.....

Зааварчилгаа авсан.

.....
/албан тушаал/ /овог, нэр/ /гарын үсэг/

Зааварчилгаа өгсөн.

.....
/ албан тушаал / /овог, нэр / /гарын үсэг/

Зааварчилгаа өгсөн тухай
тэмдэглэл.....

.....
.....
.....

..... оны сарын-ны өдөр


Ажиллуулахыг зөвшөөрсөн хүний

.....
/албан тушаал/ /овог, нэр/ /гарын үсэг/

Ажилд томилсон шийдвэрийн утга, дугаар, он, сар, өдөр

.....

Онцгой байдлын ерөнхий газрын даргын
2023 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн
А/338 дугаар тушаалын гуравдугаар хавсралт



..... дугаар анги, салбарын бие бүрэлдэхүүнээс хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дүрэм судлуулж авсан шалгалтын дүнгийн хүснэгт.

№	Овог нэр	Цол	Ажилд орсон он, сар, өдөр	Албан тушаал цол	Шүүлэг өгсөн он, сар, өдөр	Шүүлгийн үнэлгээ	Шүүлэг өгсөн хүний гарын үсэг

Шүүлэг авсан ажлын хэсгийн дарга.....

Гишүүд:.....

.....
.....

Онцгой байдлын ерөнхий газрын даргын
2023 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн
А/БЗХ дугаар тушаалын тавдугаар хавсралт

**АНГИ, САЛБАРУУДЫН
ЭМИЙН САНД БАЙХ ЗҮЙЛС**

д/д	Эм, ороох боох материалын нэрс	Хэмж их нэгж	Тоо ширхэг	Хэрэглэх заавар
1. Эм				
1	Амоксациллин 500мг	таб	5	Нянгаар үүсгэгдсэн бүх төрлийн үрэвсэлт өвчний үед хэрэглэнэ.
2	Ципрофлаксацин 500мг	таб	5	Нянгаар үүсгэгдсэн бүх төрлийн үрэвсэлт өвчний үед хэрэглэнэ.
3	Левомецетин 500мг	таб	5	
4	Метронидазол 500мг	таб	5	
5	Гроприносин 500мг	таб	5	Вирусын халдварын үед бие махбодын дархлааг дэмжих үйлчилгээтэй.
6	Ацикловир 200мг	таб	4	
7	Ибупрофен 400мг	таб	5	Өвдөлт намдаах, халуун бууруулах үйлчилгээтэй бэлдмэл.
8	Диклоденк 100мг	таб	5	
9	Нош-па 40мг	таб	5	Өвдөлт намдаах, булчин сулруулах, агчил тавиулах үйлчилгээтэй.
10	Цитрамон 500мг	таб	5	Толгойн өвдөлт намдаах үйлчилгээтэй.
11	Парацетамол 500мг	таб	5	Халуун бууруулах үйлчилгээтэй.
12	Дибазол 20мг	таб	5	Артерийн даралт бууруулах үйлчилгээтэй.
13	Энап 5мг	таб	3	
14	Энап 10мг	таб	3	
15	Амлоденк 5мг	таб	3	
16	Атенолол 50мг	таб	3	Судасны цохилт олшрох, зүрхний хэм алдагдах, даралт ихсэх үед хэрэглэнэ.
17	Валидол 60 мг	таб	3	Тайвшруулах, зүрхний өвдөлт намдаах үйлдэлтэй.
18	Долоогоны ханд	фл	1	
19	Бамбайн ханд	фл	1	
20	Аспирин 81	таб	1	Цус шингэрүүлэх үйлдэлтэй.
21	Уголь (идэвхжүүлсэн нүүрс)	таб	10	Хордлого, харшил, гэдэсний гүйлгэлт, хэвлийгээр базалж өвдөх зэрэг өвчний үед хэрэглэнэ.
22	Мезимфорте 40мг	таб	3	Хоол боловсруулах эрхтэн тогтолцооны хямралын үед хэрэглэнэ.
23	Имопек	таб	3	Хордлого, харшил, гэдэсний гүйлгэлт, хэвлийгээр базалж

24	Омепразол 40мг	таб	3	Ходоодны шархлаа, нойр булчирхайн үрэвсэл, цэсний өтгөрөлд хэрэглэнэ.
25	Хросол 12мг	уут	10	Хордлогын үед шингэн нөхөх үйлдэлтэй.
26	Терафлу	уут	10	Халуун бууруулах, өвдөлт намдаах, ханиад томууны эхэн үед хэрэглэнэ.
27	Нолколд	таб	3	Халуун бууруулах, өвдөлт намдаах, ханиад томууны эхэн үед хэрэглэнэ.
28	Дармон	таб	5	Уушгины халдварт өвчнүүд, цэр ховхлох, хий ханиадны үед хэрэглэнэ.
29	Нормон	таб	5	Ханиад томуугийн эхэн үед халуун бууруулах, цусны эргэлт сайжруулах, өвдөлт намдаах үйлчилгээтэй.
30	Фарангосепт 10мг	таб	5	Амны хөндий, залгиур хоолой үрэвсэлт өвчний үед хэрэглэнэ.
31	Септолете 3мг	таб	5	
32	Кофлет	таб	5	
33	Ризин 10мг	таб	5	Бүх төрлийн харшлын үед хэрэглэнэ.
34	Хлорфенамин	таб	5	
35	Цистон	фл	1	Бөөр, шээсний замын үрэвсэлт өвчнүүдийн үед хэрэглэнэ.
2. Шарх цэгцлэх, ороох боох материал				
36	Спирт 75%	литр	1	Төрөл бүрийн ил шархны үед гадуур ариутгах үйлдэлтэй.
37	Ам зайлах тамедин 100гр	гр	1	Амны хөндий, залгиур хоолой үрэвсэлт өвчний үед гадуур хэрэглэнэ.
38	Повидон иод 0,7%-300 мл	гр	1	Төрөл бүрийн ил шархны үед гадуур ариутгах үйлдэлтэй.
39	Устөрөгчийн хэт ислийн уусмал 3%-40мл	мл	1	Төрөл бүрийн ил шархны үед гадуур ариутгах нян, вирус устгах үйлдэлтэй.
40	Панфеникол-5гр	гр	1	
41	Синафлан тосон түрхлэг	фл	1	Микробын бус гаралтай арьсны харшлын өвчний үед гадуур түрхэж хэрэглэнэ.
42	Ацикловир тосон түрхлэг	фл	1	Херпес вирусээр үүсгэгдсэн хомхой болон шархны үед гадуур түрхэж хэрэглэнэ.
43	Диклоденктэй тосон түрхлэг	фл	1	Бүх төрлийн үе мөчний өвчний үед гадуур түрхэж хэрэглэнэ.
44	Мазь вешневский (өмхий тос)	гр	1	Арьс салстын бүрхүүлийн идээт шарханд гадуур хэрэглэнэ.
45	Ариутгасан бинт	ш	5	Бүх төрлийн шарханд боолт хийж хэрэглэнэ.
46	Ариутгасан хөвөн	ш	5	
47	Шархны хурууны лент	ш	2	Шарханд халдвар дамжихаас

48	Шархны лент 2*500 /туузан/	ш	10	сэргийлнэ.
49	Мэс заслын наалт /том/	ш	5	Шархыг халдваргүйтгэх, бохирдлоос хамгаалах
50	Мэс заслын наалт /жижиг/	ш	5	
51	Халууны шил	ш	1	Биеийн халуун хэмжих
52	Чангалуур (стандарт)	ш	1	Цус тогтоох, судас боох
53	Чиг (стандарт)	ш	1	Хугарал, гэмтэлд хөдөлгөөн хязгаарлахад хэрэглэнэ
54	Уян боолт (том)	ш	5	
55	Уян боолт (жижиг)	ш	5	
56	Хайч	ш	1	Гэмтэл бэртлийн үед бинт, уян боолтыг тастахад хэрэглэнэ.

Онцгой байдлын ерөнхий газрын даргын
2023 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн
А/БЗЗ8 дугаар тушаалын зургаадугаар хавсралт

БАТЛАВ: Онцгой байдлын газар, /хэлтэс/-ын дарга

ОСЛЫГ ТОГТООСОН АКТ (ОТА)

/5 хувь үйлдэнэ/

20... оны ... сарын ... өдөр үйлдэв.

1. Байгууллагын нэр
2. Осолдогчийн овог нэр
3. Осолдогчийн албан тушаал
4. Нас, хүйс.....
5. Боловсрол
6. Мэргэжил
7. Осолдогчийн улсад ажилласан хугацаа
8. үүнээс тухайн албан тушаалд ажилласан хугацаа
9. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дүрмээр шүүлэг, шалгалт өгсөн
.....он..... сар.....өдөр.
10. Осол гарсанон..... сар өдөр.
11. Осол гарсан нөхцөл байдал
12. Осолд хүргэсэн шалтгаан /тоног төхөөрөмж гэмтэлтэй бүрэн бус байсан, эсвэл
аюулгүй ажиллагааны дүрэм, технологийн горим зөрчсөн, ажиллагч буюу албан
тушаалтны буруу үйл ажиллагаанаас болсон зэргийг тодорхой бичнэ. /...../
13. Ослын улмаас:
14. Хөдөлмөрийн чадвар түр алдсан өдөр
15. Олгосон тэтгэмж төгрөг
16. Тахир дутуугийн I , II , III группэд орсон, нас барсан эсэх / доогуур нь зур /
17. Осолдогч ямар бэртэл, гэмтэл авсан
18. Эвдэрч гэмтсэн тоног төхөөрөмж, материалын үнэ.....төг
19. Ослын шалтгааныг арилгах арга хэмжээ.....

АКТ ТОГТООСОН АЖЛЫН ХЭСГИЙН


ДАРГА:...../...../

ГИШҮҮД:...../...../

...../...../

...../...../

Онцгой байдлын ерөнхий газрын даргын
2023 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн
А/338 дугаар тушаалын долоодугаар хавсралт



ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ОСОЛ, ХУРЦ ХОРДЛОГЫН ТУХАЙ
ЯАРАЛТАЙ МЭДЭГДЭХ ХУУДАС

1. Аж ахуйн нэгж, байгууллагын нэр
2. Цех, тасгийн нэр
3. Осол, хурц хордлогын хэлбэр: хөнгөн, хүнд, хүн нас барсан, бүлэг осол /зурах/
4. Осол, хурц хордлогод өртсөн хүний тоо
5. Осол, хурц хордлого гарсан он ... сар ... өдөр ... цаг минут
6. Мэдэгдэл өгсөн он сар ... өдөр ... цаг ... минут
7. Осол, хурц хордлогын тухай мэдээлэл

.....
.....
.....
.....
.....
.....
.....

Энэхүү мэдэгдлийг
.....
.....
..... нарт өгсөн болно.

Тайлбар: Мэдэгдлийг бичгээр, утсаар өгч болно. Мэдэгдлийг утсаар өгсөн тохиолдолд хаана, хэнд мэдэгдсэн тухайгаа энэхүү хуудсанд бичиж, осол, хурц хордлогын материалд хавсаргана.

Мэдэгдэл өгсөн хүний албан тушаал
.....
.....
/...../

/гарын үсэг/

/нэр/